

СУРАЛЦАГЧИЙН СУДАЛГАА, ИННОВАЦИЙН ХӨГЖИЛД

Эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл

НЭЭЛТТЭЙ СУРГУУЛЬ, СУДАЛГАА ИННОВАЦИ

2021 ОН



“СУРАЛЦАГЧДЫН ЭКОЛОГИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЖ, СУРГУУЛИЙН НОГООН ОРЧИНГ САЙЖРУУЛАХ БОЛОМЖ”

ИЛТГЭГЧ: АХУА2ААНГИЙН СУРАГЧГ. ЦЭЛМЭГ
УДИРДСАН БАГШ: З.ДОЛГОРМАА

Агуулга

1. Зорилго, зорилт
2. Судалгааны үндэслэл
3. Онолын хэсэг
4. Судалгааны хэсэг
5. Шийдвэрлэх боломж, санал
6. Дүгнэлт
7. Ашигласан ном

СЭДЭВ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ

Байгаль орчны доройтлын 53 хувь нь хүний нөлөөнөөс, 47 хувь нь байгалийн өөрийнх нь зүй тогтлоос шалтгаалж байна гэж байгаль орчны яамнаас судалгаа гаргажээ. Тиймээс байгаль экологийн доройтлыг бууруулахад том бага гэлтгүй хүн бүрийн хүчин чармайлт хэрэгтэй.

ТИЙМЭЭС БИД...

- Байгаль дэлхийгээ хайрлахад хувь нэмрээ оруулж чадах уу?
- Экологийн боловсролыг олгох, дээшлүүлэх боломж байна уу?
- Сургуулийн ногоон орчноо сайжруулах боломж байна уу? гэдэгт хариу авахын тулд энэхүү сэдвийг сонгосон.

ТҮЛХҮҮР ҮГ

- Экологийн боловсрол
- Ногоон орчин

ЗОРИЛГО

Энэхүү судалгааны ажил нь суралцагчдын экологийн боловсролыг дээшлүүлж, сургуулийн ногоон орчинг сайжруулах боломжийг эрэлхийлэхэд оршино.

ЗОРИЛТ

- Экологийн боловсролын тухай судлах
- Суралцагчдын экологийн боловсролыг дээшлүүлэх боломж арга замыг судлах
- Сургуулийн ногоон орчинг сайжруулах боломжийг эрэлхийлэх

СУДАЛГААНЫ АРГА

- Асуулгын арга / Google form
- Ажиглалтын арга
- Нэгтгэн дүгнэх арга

ЭКОЛОГИ, ЭКОЛОГИЙН БОЛОВСРОЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Экологи гэдэг нь эко буюу оронзай, логи буюу орчноо судлах гэсэн үгнүүдээс гаралтай. Энэхүү нэр томъёог анх 1886 онд Германы эрдэмтэн А.Геккель гаргаж иржээ. Түүний тодорхойлсноор “Экологи бол байгалийн тэнцвэрийн тухай ойлголт бөгөөд амьд бие ба түүний хүрээлэн буй орчны органик, органик бус бүрэлдэхүүн хэсгийн хоорондын харилцан хамаарлын тухай шинжлэх ухаан” юм гэжээ.

Экологийн боловсрол олгоно гэдэг нь байгаль экологийн тухай ойлголтыг өгч, байгалиа хамгаалах, хөгжүүлэх, ногоон орчныг бүрдүүлэх зорилгоор хандлага төлөвшлийг бий болгож буй боловсролыг хэлнэ.

ДЭЛХИЙН ЭКОЛОГИЙН ӨДРҮҮД

Дэлхий нийт болон төр засаг экологийн боловсрол дээр жил ирэх тусам анхаарч ажиллаж байгаа бөгөөд дэлхийн экологийн өдрүүдийг тогтмол тэмдэглэн өнгөрөөж сурталчилдаг болсон байна.



Монгол улс
Байгаль орчин
Аялал жуулчлалын яам

МОНД ТАРХИХ ТОХИРОМЖТОЙ ҮЕ

ХАВАР 4 сарын 15
3 сарын 23

НАМАР 9 сарын 10
10 сарын 10

ОЙ, МОД БОЛ ЭХ ДЭМЖЛЭН УУШГИ

ТАНИН 4 сарын 1-нээс
6 сарын 15 хүртэл

ЗАГАС БАРИХЫГ ХОРИГЛОХ ҮЕ

4 сарын 1-нээс
6 сарын 15 хүртэл

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

ХУВАНЦАР ХЭРГЭГЧНИЙГ ТАТГАЛЗАЖ БАЛГАЛ ДЭГХЛЭДЭЭ ЭЭПТЭЙ АМЬДАРЦАГАА!

МОД ТАРНАМЫН АШИГ ТУС:

- Хүншигээр ашигласныг
- Усныг эргэлтэл оруулах
- Агаарыг хэвдэрүүлэх, чийгшүүлэх
- Харсныг эдгээх, сэрвэх

ШАР ӨВСНИЙ ТҮЙМРЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛБЭ!

ВАЛРИН БОЛОН ВУСОМ АНХ НАС 10 ХАВАНГИЙГ ХАНГААЛЫ!

Судалгаанд Үйлдвэрлэл Урлалын Политехник коллежийн
нийт 71 оюутан хамрагдсан



Хүйсний хувьд 67 хувь нь эмэгтэй
33 хувь нь эрэгтэй хүүхэд судалгаанд
хамрагдсан байна.





Судалгаанд 16-18 насны буюу
Мэргэжлийн анхан шатны суралцагчид
илүү хамрагдсан байна.




Үүнээс харахад экологийн талаар дундаж болон бараг мэдэхгүй гэсэн суралцагч дийлэнх хувийг эзэлж байна. Тиймээс суралцагчдад экологийн боловсролыг олгох шаардлагатай болох нь харагдаж байна.

Тулгамдаж буй асуудал




Эдгээр судалгаанаас харахад суралцагчид байгаль экологийн холбогдолтой үйл ажиллагаанд хангалгүй оролцож байна гэж дүгнэж байна.

Та хамгийн сүүлд хэзээ байгаль экологитой холбоотой, ургамал мод тарих сургалтанд хамрагдсан бэ?



Энэ судалгаанаас харвал сургалтанд огт хамрагдаж байгаагүй гэсэн дүгнэлт гарч байна. Гэхдээ энэ нь ковидын үеийн хөл хорионоос бас шалтгаалсан байх магадлал өндөр юм.

Хэрэв экологийн боловсролын тухай сургалт явбал та хамрагдах уу?




Энэ судалгаанаас харахад экологийн боловсрол олгох сургалт, дугуйлан хичээллэвэл хамрагдах сонирхол их байна.

ТАНД МАНАЙ СУРГУУЛИЙН НОГООН ОРЧИН ХЭР САНАГДДАГ ВЭ?



Энэ судалгаанаас харахад манай сургуулийн орчин боломжийн хангалттай харагдаж байна. Хангалтгүй гэж нэг ч хариулт ирээгүй нь маш сайхан санагдаж байна.

Та сургуулийн ногоон орчинг улам сайжруулах шаардлагатай гэж бодож байна уу?



Аливаа зүйлийг байнга сайжруулж хөгжүүлж дэвжүүлэх шаардлагатай байдаг учраас бүгд 100 хувийн саналтайгаар ШААРДЛАГАТАЙ гэж хариулжээ.

Дэвшүүлж буй санал

Экологи байгаль хамгаалалттай холбоотой уралдаан тэмцээн зохион байгуулах / Эсээ, АХА, Өдөрлөг гэх мэт/

"Эко бүлгэм" нэртэй экологийн баг байгуулах

Дэлхийн экологийн өдрүүдийг суралцагчдад тогтмол түгээдэг байх



Ногоон булантай болох / 216 тоот ангид багштайгаа хамт ногоог булан бүрдүүлэхээр төлөвлөж байсан/

Ногоон төгөлтэй Эко сургууль болох

216 тоот ангид ногоон булан хийхээр төлөвлөсөн төлөвлөгөө



Загасны аквариум

1. АХҮА 1в анги аялал жуулчлалын ангийн суралцагчтай яриа хийж санал дэвшүүлж дэмжигдсэн. Үүний үр дүнд дараах зүйлүүд дээр тохиролцсон байсан. Үүнд

- АХҮА 1в, ЗБЖБҮА 1а, ЗБЖБҮА 2а ангиудын суралцагчид нэг нэг цэцэг авчрах болсон

Ангийн суралцагчид багахан хэмжээний төсөв гаргаж гэрэл, цэцэг суулгах том хайрцаг, бусад тохижилтын зүйлийг авахаар тохиролцсон байсан.

АХҮА ангид ногоон орчин бүрдүүлэхэд тулгамдаж байсан асуудал нь:

- 216 тоот дэндүү хүйтэн
- Байгалийн гэрэл байхгүй
- Байрны хүүхдүүд оройн цагаар тогтмол орж, өөриймсөг бус ханддаг
- Суралцагчдаас хураах төсөв хүрэхээргүй байсан.



ДҮГНЭЛТ

Байгаль дэлхийг хамгаалах нь хүн бүрийн үүрэг ухамсар билээ.

Эрт дээр үеэс өвгөд дээдэс маань “Голдсүү хийж болохгүй” “Ганц модыг тайрч болохгүй, лус хилэгнэнэ.” “Шувууны өндгөн дээр сүүдрээ тусгаж болохгүй, ээж нь голоод хаяад явчихна” гэх мэтээр ёс заншилтай холбон байгаль хамгаалах арга ухааныг олгодог байсан. Энэ өвөг дээдсийн ёс заншилтай хамтатган сургуулийн зүгээс суралцагчдад экологийн боловсролыг олгож байгаль эх дэлхийгээ хамгаалах хандлага төлөвшил суулгах нь чухал юм.

Экологийн боловсролтой болж мод, цэцэг тарих, хайрлаж хамгаалах сэтгэлгээтэй болчихвол энэ нь тухайн хүүхдийн ирээдүйн амьдрал ахуйд нь насан туршид нь хэрэг болох юм.

ЭКОЛОГИЙН БОЛОВСРОЛ – НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛ



Ном зүй

1. <http://www.mne.mn/>
2. <https://www.facebook.com/mne.mn>
3. Ж. Өлзийсайхан Н.Болдбаатар “Экологи байгаль хамгаалал” 2006

[illegible]

Илтгэгч: : НБДАХА2а анги Д. Оюундарь
Удирдсан багш: Б. Оюун

Агуулга

Нэгдүгээр бүлэг: Удиртгал хэсэг

- 1.1 Судалгааны үндэслэл
- 1.2 Судалгааны зорилго
- 1.3 Судалгааны арга зүй, ач холбогдол

Хоёрдугаар бүлэг: Онолын хэсэг

- 2.1 . Гэр бүлийн талаарх ойлголт
- 2.2 . Гэр бүлийн үүрэг, нийгмийн нөлөөлөл
- 2.3. Хүүхэд гэж хэн бэ?
- 2.4. Хүүхдийн хүмүүжил, төлөвшилд гэр бүлийн үзүүлэх нөлөөлөл

Судалгааны хэсэг

4. Дүгнэлт
5. Ном зүй

**Нэгдүгээр бүлэг: Удиртгал хэсэг****Судалгааны үндэслэл:**

Монголчууд хүн болох багаасаа, хүлэг болох унагнаасаа гэж ярьдаг гүн утгатай. Улсын сайн хүнээсээ Хүний сайн хүүхдээсээ...

Хүүхдийн хүмүүжил-хандлага гэдэг нь зөвхөн сургуульд орсноор л яригддаг зүйл огт биш юмаа. Үүнд нөлөөлөх маш олон хүчин зүйл байдаг.

Гэр бүл бол нийгмийн жижиг хэсэг бөгөөд энэ жижиг хэсэг нь хүүхдийн хөгжилд ихээхэн нөлөө үзүүлдэг. Яагаад гэвэл бага насны хүүхдийн өсөж бойжиж буй орчин нь гэр бүл.

Монгол уламжлалаас харахад ил буюу далд аргаар хүүхэд багачуудаа хүмүүжүүлж ирсэн байдаг. “Хүмүүжил гэдэг нь хүнжүүлэх, хүмүүнжүүлэх, хүнээр хүн хийх, хүн шиг хүн болгох, амьдрах ур дүй, ухаантай болгох гэсэн үг юм” өөрөөр хэлбэл хүн шиг хүн болгохыг ихэд эрмэлзэн хүмүүжүүлж ирсэн билээ.

Өөрөөр хэлбэл гэр бүлийн амьдралын хэв маягаас нийгмийн гишүүдийн зан үйл ихээхэн хамаардаг. Хүмүүс өөрсдийн амьдралын гол асуудлууд тухайлбал үр хүүхэдтэй болох тэдгээрийг өсгөж хүмүүжүүлэх ирээдүйн амьдралаа төлөвлөх зэрэг асуудлыг гэр бүлийн хүрээнд шийдвэрлэдэг.

Тиймдээ ч монголчууд “Биеэ засаад гэрээ зас. Гэрээ засаад төрөө зас” гэж ярьдаг байх. Хүүхдийг идэвхтэй амьдрах чадвар бүхий зөв хүмүүжил, төлөвшилтэй иргэн бэлтгэхийн тулд тэдэнд тавих гэр бүлийн үүрэг, оролцоо чухал байна.

Иймээс гэр бүлийн орчин нь тухайн хүүхдийн ирээдүйд, гэр тусмаа хүмүүжил, төлөвшилд нь мөн мэргэжил эзэмшин суралцахад нь нөлөөлдөг гол хүчин зүйл мөн учраас цаг үеийн шаардлагад нийцүүлэн цаашид анхаарах зүйлсийг тодорлуулах үүднээс энэхүү сэдвийг сонголоо.

Судалгааны зорилго:

Сурагчдын хүмүүжил төлөвшил, мэргэжил эзэмшин суралцахад гэр бүлийн үзүүлэх нөлөө, гарч буй сөрөг зүйлсийн талаар судалж, дүн шинжилгээ хийх төдийгүй Үйлдвэрлэл Урлалын Политехник коллежид суралцагчдад гэр бүлийн үзүүлэх нөлөөлөл ямар түвшинд байдгийг судлахыг зорилоо.

Судалгааны зорилт:

- Сурагчдад үзүүлэх гэр бүлийн нөлөө ямар байна вэ?
- Гэр бүлийн харилцаанд саад болж буй зүйлсийг илрүүлэх?

Судалгааны арга зүй:

Судалгаанд асуулгын, түүврийн, ярилцлагын гэх мэт аргуудыг ашигласан бөгөөд сурагчид — багш — эцэг эх гэсэн 3 талбарыг хамарсан судалгаа явуулсан.

Сэдвийн судлагдсан байдал:

Гэр бүл, түүний харилцааны талаар өмнө нь олон судлаач, эрдэмтэд бүтээл туурвисан.

Хоёрдугаар бүлэг: Онолын хэсэг

1. Гэр бүлийн талаарх ойлголт

“Гэр бүл” гэдэг энэ холбоо үгийг хүн болгон мэддэг бөгөөд ямар утга илэрхийлдэг болохыг нь өөр өөрийнхөөрөө тодорхойлж чадна.

Өнөөдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байгаа Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль нь 1999 онд батлагдсан бөгөөд энэхүү хуулиар гэр бүлтэй холбоотой харилцааг зохицуулахаар хуульчилсан.

“Гэр бүл” гэдэг нь: Гэр бүлийн тухай хуульд зааснаар гэрлэлтийн үр дүнд бий болсон, эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг хэлдэг байна.

Гэрлэлт гэдэг нь 18 насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хүмүүс, хэний ч дарамт шахалтгүй, сайн дурын үндсэн дээр гэр бүл болох зорилгоор төрийн эрх бүхий байгууллагад буюу иргэний гэр бүлийг бүртгэх албанд бүртгүүлж байгаа үйлдлийг хэлдэг.

Монгол Улсын Гэр бүлийн тухай хуульд зааснаар эрэгтэй хүн нэг л эхнэр, эмэгтэй хүн нэг л нөхөртэй байх ёстой. Гэр бүл болохоор сонгож байгаа эхнэрээ, нөхрөө болгох гэж байгаа хүн нь заавал Монгол улсын иргэн байх шаардлагагүй бөгөөд тэр ч байтугай ямар ёс заншлаар гэрлэх нь тэдний эрхийн асуудал юм.

Ер нь хүмүүс ямар ч ёс заншлаар гэрлэсэн, ямар ч соёл иргэншилтэй бай тэр бүхнээс үл хамааран гэр бүлийнхээ өмнө эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлага нь адил хэмжээтэй байдаг.

Гэрлэгчид нь хэн хэнийхээ өмнө дараах нийтлэг тэгш эрхтэй байдаг. Үүнд:

Гэр бүлээ төлөвлөх,

- Оршин суух газар, эрхлэх ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох,
- Хуваарь эд хөрөнгөтэй байх,
- Дундаа хамтран өмчлөх эд хөрөнгөө ашиглах, захиран зарцуулах гэх мэт.
- Харин дараах нийтлэг үүргийг хүлээдэг. Үүнд:
- Бие бидээ үнэнч байх,
- Хүүхдээ өгсөн хүмүүжүүлэх,
- Гэр бүлийн гишүүд нь бие биеэ халамжлах, хүндэтгэх, тэжээн тэтгэх, туслах,
- Гэр бүлд шаардагдах эдийн засгийн нөхцлийг бүрдүүлэх,
- Хэн нэгнийхээ эрхийг зөрчихгүй, бие биеэ аливаа хэлбэрээр хүчирхийлэхгүй байх,
- Угийн бичгийг хөтлөх гэх мэт.

Гэр бүл гэдэг нь цусан төрлийн холбоо бүхий, хоорондоо гэрлэлтээр холбогдсон, хүүхдийнхээ өмнө үүрэг хариуцлага хүлээсэн 2 ба түүнээс дээш хүмүүсийн нэгдэл юм. Гэр бүлийн амьдралд эхнэр нөхрийн төгс харилцаа, бие биенээ ойлгох, хүндлэх, хүлээцтэй хандах зэрэг зүйлс маш чухал үүрэг гүйцэтгэдэг. Хүүхэд ухаан орсон цагаасаа л ээж аавыгаа харан тэдний хийж буй үйлдэл бүрийг дуурайж байдаг.

Гэр бүл судлаач Л.Нарантуяа гэр бүлийг “Хүн бүр амар тайван, эрх чөлөөгөө мэдэрч болох цорын ганц хайрын өргөө бол орон гэр юм. Хүнээр хүн хийх дадлагын бааз, зан суртахууны төлөвшилтийн сургууль, хариуцлагаа ухамсарлах, хүмүүжлийн яам юм. Гэр бүлд улс тэр чигээрээ багтана” хэмээн тун оновчтой хийгээд ойлгомжтой тайлбарлажээ. Гэр бүлийн гол багана нь эхнэр, нөхөр хоёр ба тэд хайраар бялхаж, амар тайван аз жаргалтай байвал үр хүүхэд аз жаргалтай хүн болж хүмүүжинэ гэж оновчтой хэлсэн байна.

Гэр бүл бол хүүхдийн хүмүүжих, суралцах, төлөвших, нийгэмшихүйн анхдагч орчин. Эцэг эх нь тэдний анхны хүмүүжүүлэгч ба амьдралын багш нь болохоор тэдний хүмүүжил төлөвшлийг ээж аавтай нь холбон үзэх нь зүйтэй хэрэг.

Гэр бүлийн нийгмийн үүрэг

Хүнээр хүн хийнэ, хүүхэд хүмүүжүүлнэ гэдэг амаргүй ажил. Хүүхэд хүмүүжүүлэх нь эцэг эхээс үнэхээрийн их ур ухаан, хичээл зүтгэл шаардаж байдаг.

Хүүхдийн хүмүүжил, төлөвшлийн 80-90 хувь нь гэр бүлийн нөлөөнөөс бий болдог гэж Европын судлаачид үзсэн байдаг.


“Эх нь хээр алаг бол, унага нь шийр алаг” гэдэг Монгол ардын зүйр үг бий.

Үнэхээр л тухайн хүүхдийн амьдралд хандах хандлага, зан чанар, байгаа байдал нь аав ээжийхээ хэн нэгэнтэй заавал биш юмаа гэхэд ямар нэг хэмжээгээр төстэй байдаг. Манай настайчуудын “Хүнтэй суухдаа удам судрыг нь сайн шинж” гэдэг нь оргүй хоосон зүйл бас биш юм. Тэр бүхэн юу хэлээд байна вэ? гэхээр гэр бүлийн нөлөө тухайн хүнд ямар их нөлөөлдгийг харуулж байна.

Монгол Улсын “Боловсролын тухай хуулинд” эцэг эхийн үүргийг :

- “Эцэг эх нь хүүхдийн авъяас чадварыг бага наснаас нь дэмжин хөгжүүлэх, боловсрол эзэмшихэд нь шаардагдах нөхцөлийг бүрдүүлэх, багштай хамтран ажиллах, мэргэжлээ сонгоход нь туслах”.
- “Хүүхдийг гэр бүлийн орчинд сургах арга барил эзэмшүүлэх” гэсэн заалтууд байдаг нь миний судалгааны эрх зүйн /онолын гэх үү?/ гол тулгуур үндэслэл болж байгаа юм.

Гэр бүл нь нийгмийн өмнө дараах үүргийг хүлээнэ.



Хүүхэд гэж хэн бэ?


Хүүхдийн эрхийн конвенцэд 18 нас хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэнэ гэж тунхагласан байдаг. Тодоруулбал:

Нас бие сэтгэцийн хувьд эрчимтэй хөгжлийн замыг туулж яваа, нийгмийн харилцаанд бие даан оролцох чадвар хараахан төлөвшөөгүй, эцэг эх асран хамгаалагчдын хараа хяналтанд байдаг, өөрийн гайхамшигт ертөндөөр хүрээлэн буй орчин болон бусдыг танин мэдэж буй 18 нас хүртэлх хүн бүрийг хүүхэд гэнэ.


Дэлхийн улс үндэстэн бүр өөрийн орны ирээдүй болсон хүүхэд багачуудаа хүн болгон төлөвшүүлэхийн тулд санаа тавьж ажилладаг байна.

Өнөө үед дэлхий нийтээрээ хүний хөгжил өрх гэрээс эхтэй гэдгийг хүлээн зөвшөөрч, эцэг эхчүүдийн боловсрол, төлөвшлийн асуудлыг тэргүүн зэрэгт тавих болсон байна. Гэвч дэлхийн хөгжилтэй хөл нийлүүлэн алхаж байгаа Монголчууд бидний хувьд эцэг эхчүүд нь ажил амьдралаа залгуулах, нийгмийн амьдралд оролцож өөрийгөө хөгжүүлэх шаардлага байгаа учраас үр хүүхдээ хүмүүжүүлж төлөвшүүлэхэд анхаарал халамжаа зарим талаараа орхигдуулаад байна уу гэлтэй.


Хүүхдийн хүмүүжилд гэр бүл дараах байдлаар нөлөөлнө.



Тэгвэл 12-17 насны /өсвөр нас/ суралцагчдын хүмүүжил нөлөөлдөг хүчин зүйлсийг авч үзвэл: /сөрөг/



Эндээс хүүхдийн хүмүүжил, төлөвшилд гэр бүлийн нөлөө чухал гэдэг нь харагдаж байна.



Суралцагчдад үзүүлж буй гэр бүлийн нөлөөлөл

Гэр бүл нь нийгмийн өмнө хүлээсэн үүргээ хэр зэрэг биелүүлэхээс нийгмийн ирээдүйн төлөв байдал ихээхэн шалтгаална.

Өнөөдөр Монголд 1 гэр бүл дунджаар 4-5 гишүүнтэй бөгөөд хүн амыг нөхөн үйлдвэрлэхээс гадна хүний оюун санаа, ёс суртахуун, ирээдүйн хөгжил төлөвшилд чухал нөлөө үзүүлдэг.

Эцэг эхчүүд хүүхдээ ЕБС төгссөний дараа мэргэжил эзэмшүүлж, их дээд сургуульд нь хөрөнгө оруулалт хийнэ гэж үздэг бол хүүхдийг ирээдүйд ямар хүн болгох вэ? гэдэг нь түүнээс өмнө яригдах асуудал юмаа.

Хүмүүсийн нэг их тоодоггүй, хамгийн бага хөрөнгө мөнгө зарцуулдаг СӨБ, бага боловсрол нэн чухал болохыг бидний өнөөгийн хүүхдүүдийн хандлага, төлөвшил харуулж байгаа болохоор хамгийн их анхаарал, хамгийн их хөрөнгийг энд л зарцуулах хэрэгтэй юм шиг. Өөрөөр хэлбэл хүний хүмүүжил нь хүүхэд ахуй наснаас эхлэн төлөвшдөг байна.

Тэгэхээр бие хүний хүмүүжил төлөвшилд нөлөөлөх гол хүчин зүйлүүдийн нэг бол гэр бүл.

Суралцагчдад үзүүлж буй гэр бүлийн нөлөөлөл

Судалгааг googleform-е программ ашиглан авсан болно.

Судалгааг 3 хэсгээр авч нэгтгэсэн болно.


1. Суралцагчдаас /асуулгын аргаар/
2. Эцэг эхээс /түүврийн аргаар/
3. Багш нараас /анги удирдсан багш нараас,асуулгын аргаар/

Суралцагчдаас:

Суралцагчдаас түүнд нөлөөлж буй гэр бүл болон бусад хүчин зүйлсийн талаар өөрийн мэргэжлийн НБДАХА авсан судалгааны үр дүнг нэгтгэлээ.


Судалгаа 1:

1. Та хэн хэнтэйгээ амьдардаг вэ? гэсэн асуултанд:



Аав, ээж гэр бүлийн хамт – 45%
 Ах, эгчийн хамт – 25%
 Өвөө, эмээгийн хамт – 15%
 Лавтайгаа – 5%
 Ээжтэйгээ – 20%
 Үүнээс үзэхэд МСҮТ-д суралцагчдын гэр бүлийн байдал тийм ч тогтвортой биш гэдэг нь харагдаж байна. Ихэвчлэн аав ээж нь салсан буюу тусдаа амьдардаг гэр бүлийн хүүхэд олон байдаг.

2. МСҮТ-д суралцахад юу хамгийн ихээр нөлөөлсөн бэ?



Эцэг эх, гэр бүл – 55%
 Найз нөхөд – 15%
 Өөрийн сонирхол – 25%
 Мэдээллийн хэрэгсэл – 15%

Үүнээс үзэхэд МСҮТ-д суралцахад гэр бүл ихээхэн нөлөөлсөн болох нь харагдаж байна.


3. Та гэр бүл /аав, ээж/-гээ чин сэтгэлээсээ ярилцдаг уу?



Бараг үгүй – 40%
 Хааяа л – 10%
 Санахгүй байна – 40%
 Үргэлж – 10%

Судалгаанаас харахад сурагчид гэр бүл /аав, ээжтэйгээ/ төдийлөн ярилцдаггүй байна. Энэ нь гэр бүлийн халуун дулаан уур амьсгал дутмаг байна гэж үзэж байна.

4. Чи чөлөөт цагаараа юу хийдэг вэ? гэсэн асуултанд:



Эндээс харахад хүүхдүүд хичээлээ тараад гадуур тэнэх, тоглоом тоглох хандлага байна. Үүнд гэр бүлийн зүгээс хараа, хяналт тавих, түүнээс урьдчилан сэргийлэх шаардлагтай байна. Мөн үүнээс гадна хичээлээ тараад найзуудтайгаа сагс тоглодог гэж хариулсан байна.

5. Танай гэр бүлийн уур амьсгал таны бодлоор... гэсэн асуултанд:

- Сайн, муу хосолсон байдаг
- Заримдаа үнэхээр хэцүү байдаг
- Гэртээ харимааргүй санагдах үе байдаг...гэх зэргээр хариулсан байна.
- Халуун дулаан байгаасай гэж хүсдэг

Судалгаа 2:

Эцэг эхийн зүгээс: /ганцаарчилсан ярилцлагын/

1. Хүүхэддээ цаг гаргаж түүний найзшиг нь халуун дотноор ярилцаж үзсэн үү? гэсэн асуултанд:

- Тэр бүр боломж гардаггүй - 35
- Хааяа ярилцдаг - 25
- Ярилцаж байгаагүй - 40

2. Таны бодлоор орчин үеийн хүүхдүүдийн ёс суртахуунд юу хамгийн ихээр нөлөөлж байна вэ?

- Интэрнэт цахим ертөнц
- Гэр бүлийн орчин
- Нийгмийн өнөөгийн байдал
- Найз нөхөд

3. Та яагаад хүүхэдээ МСҮТ-ийг сонгон мэргэжил эзэмшүүлэх болсон бэ?

- Өөрийнх нь сонирхлын дагуу суралцуулсан
- Эрэлт хэрэгцээ ихтэй мэргэжлийг сонгосон
- Цаг хугацаа хожихын тулд
- Амьдралын боломж муу
- Их сургуулийн сургалтын төлбөрийн чадамжгүй

4. Хүүхдээ мэргэжил эзэмшихэд суралцахад та байнга тусламж дэжмэлэг үзүүлдэг үү?

1. Тэр бүр чаддаггүй - 40
2. Үргэлж тусалдаг - 25
3. Тусалъя гэсэн хэдий ч боломж байдаггүй - 30


5. Та хүүхдийхээ төлөө багш болон сургуультай байнга холбоотой байж чаддаг уу?

- Чаддаггүй

Судалгаа 3:


Багшийн зүгээс:

1. Танай ангийн сурагчдын эцэг эх тантай хэрхэн хамтарч ажилладаг вэ?



Эндээс харахад эцэг эхчүүдийн багштай хамтарч ажиллах болон хүүхдэдээ тавих анхаарал сайн биш гэж харагдаж байна.


2. Танай ангид ар гэрийн анхаарал халамж шаардлагтай суралцагчид хэр олон байдаг вэ? гэсэн асуултанд:



3. Та ангийн даасан ангийн суралцагчдын эцэг эхтэй хэрхэн хамтран ажилладаг вэ? гэсэн асуултанд:

- Улиралдаа нэг удаа ангийн хурал хийдэг.
- Утсаар харилцдаг.
- Шаардлагтай тохиолдолд дуудаж уулздаг гэх зэргээр хариулсан байна.

4. Сургууль болон анги хамт олны зүгээс зохион байгуулсан ажилд эцэг эхийн оролцоо хэр байдаг вэ? гэсэн асуултанд:



Дүгнэлт

Энэхүү сэдвийн хүрээнд судалгаа хийснээр дараах дүгнэлтэд хүрч байна. Хүүхдэд тэр тусмаа МСҮТ-д суралцагчдад гэр бүлийн үзүүлэх нөлөө зайлшгүй шаардлагтай гэдэг нь судалгаанаас харагдаж байна. Үүний тулд:

1. Судалгаанаас үзэхэд тухайн хүүхдийн хүмүүжил, төлөвшилтөд гэр бүлийн орчин нөлөөлдөг болох нь харагдаж байна. Иймээс бүлийн хөгжилд төр засгийн зүгээс анхаарал тавих. Өөрөөр хэлбэл:
 - Гэр бүлийн амьдралын түвшинг тасралтгүй дээшлүүлж, гэр бүлийн харилцаа, ёс зүйн эрүүл орчин, үр хүүхдийхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нөхцөл бүрдүүлэх
 - Төрөөс тогтвортой амьдарч, үүр хүүхдээ сайн сайхан өсгөж байгаа гэр бүлүүдийг дэмжих
2. Сургууль, тэр тусмаа мэргэжлийн сургуулиудын хувьд сүүлийн жилүүдэд эцэг эхтэй хамтран ажиллах хүмүүжлийн ажил эзэнгүйдсэн. Үүнийг тасралтгүй явуулах, чанаржуулах
3. Уламжлал, шинэчлэлийг хослуулж чадаагүй.
4. Залгамж холбоо дутагдалтай
5. Мөн хөдөө орон нутгийн хүүхдүүд их суралцдаг, эсвэл өрх толгойлсон эцэг, эхчүүд хүүхдээ МСҮТ-д оруулах хандлага их байдаг.
6. Мөн МСҮТ, Политехник коллежид элсэн суралцаж байгаа хүүхдүүд ЕБС-ийн хүүхдүүдийг бодвол харьцангуй биеэ даасан ажил хийх чадвартай болсон байдаг.
7. Хүүхдүүд гэр бүлийнхээ харилцааг үргэлж сайхан байгаасай гэж хүсдэг ч үргэлж тэдний хүссэнээр болдоггүй ба гэр бүлийн маргаан гарах хэмжээгээр өсвөр насны хүүхдийн сэтгэл зүйд нөлөөлж тавгүй байдлыг үүсгэж гэмт хэрэгт татагдах буруу замрууорох үндэс нь болж байдаг байна.

Үүнээс үндэслээд дараах шинэлэг санаа буюу зөвлөмжийг хүргэж байна.

1. Гэр бүл нь хүний нийгэмшлийн анхдагч орчин болохын хувьд хүүхдийн хөгжил төлөвшил, хүмүүжил нь тухайн гэр бүлийн орчны тусгал байдаг. Үүнээс үзэхэд:

- Иргэдэд гэр бүлийн боловсрол олгох тогтолцоог анхан шатны нэгжүүд болон хөдөө суурин газруудад өргөжүүлэх шаардлагтай байна.
- Телевизрадио гэх мэт олон нийтийн мэдээллийн хэрэгслээр гэр бүлийн боловсрол олгох чиглэлээр нэвтрүүлэг явуулах

2. Гэр бүлийн зүгээс хүүхэдтэйгээ харилцах харилцаандаа анхаарах. Үг яриа бол хүмүүжлийн асар хүчтэй зэвсэг мөн. Тиймээс бид харилцаандаа анхаарах, үзэл бодолдоо өөрчлөлт хийх шаардлагтай. Гэр бүлийн дулаан уур амьсгал, таатай харилцаа нь тэдний хүмүүжил төлөвшилд сайнаар нөлөөлөх нь дамжиггүй бизээ.

- Хүүхдэд багаас нь зөв үлгэр дууриал үзүүлэх
- Хүүхдийг үзэл бодлыг хүндэтгэх, ярилцах
- Тэдэнд дэмжлэг үзүүлэх

3. Хүүхдийг чөлөөт цагийг үр ашигтай өнгөрүүлэх. Өөрөө хэлбэл нийгмийн амьдралд идэвхитэй иргэн болж төлөвшихөд дэмжлэг үзүүлдэг байх. **Ингэснээр:**

1. Хүүхэд өөрсдийн нас биений онцлогт тохирсон зөв төлөвшлийг олж авна.
2. Цахим орчны зохистой хэрэглээ сайн муугаар нөлөөлөх хүчин зүйлсийг эцэг эхийн хариуцлагын дагуу тооцоолох.
3. Найз нөхөд зөв сонгож нөхөрлөх, буруу зүйл гэмт хэрэгт татагдахаас сэргийлэх
- 4.** Хүүхдэд нөлөөлөх эцэг эхийн нөлөө багшаас илүү байдаг. Өөрөөр хэлбэл эцэг эхчүүдийг ч гэсэн боловсрол сургалтын нэг хэсэг болгох хэрэгтэй.

- Санал: Эцэг эх багш нарын хоорондын харилцаа, үр хүүхдээ зөв хүмүүжүүлэхэд чиглэгдсэн эцэг эхийн ёс зүйн дүрмийг батлах нь зүйтэй төдийгүй цаг нь болсон гэж үзэж байна.

5. Бие хүний хөгжил, төлөвшилд өөрийх нь хүчин чармайлт их үүрэгтэй гэдгийг ухамсарлуулах. Манай ард түмний дотор “Эзэн хичээвэл, заяа хичээнэ”, “Дуудах нэрийг эцэг эх өгнө, дуурсах нэрийг өөрөө олж авна” гэдэг сайхан үг бий.



Ном зүй

А. Хууль тогтоомж

1. МУ-ын Үндсэн хууль 1992 он
2. Гэр бүлийн тухай хууль 1999 он
3. Хөдөлмөрийн тухай хууль 1999 он
4. Боловсролын тухай хууль 2006 он

Б. Ном, сэтгүүл

1. Ч. Баярхүү “Гэр бүлийн нийгмийн үүрэг” 2015 он
2. Батжаргал, “Гэр бүл ба эрэгтэйчүүд”, Жендэрийн асуудлуудын нэгтгэл, НҮБ-ын эмэгтэйчүүдийн сан, 2009.
3. Нийгмийн ухаан 2019 он
4. “Гэр бүл” сэтгүүл
5. Монголын мянганы сорилтын сан: “Төгсөгчдийн мөшгих судалгаа”

[illegible]

Илтгэгч: ОП 2а ангийн оюутан Х.Түвшинжаргал
Удирдагч багш: А.Дэлгэрмөрөн

Оршил

Хүмүүс таньтай яаж харьцвал өөртчинь амар байдаг вэ? Надад л лав миний яриаг сонсдог хөгжилтэй юу ярихаа мэддэг эерэг харилцаатай байхад болчихдог. Ер нь миний яриад байгаа харилцаа гэж юу вэ? Хүмүүс бие биетэйгээ ойлголцох хэлбэрийг л хэлээд байгаа юм. Хүмүүс харилцахдаа нэгнээ доромжилдог, дорд үздэг, дооглодог. Энэ нь харилцааны хэлбэр мөн боловч ингэж нэгэнтэйгээ сөрөг хандлагаар харилцсанаас бараг харьцаагүй байсан нь хамаагүй дээр.

Хамгийн гол нь хэн нэгэнтэй харилцаа үүсгэхдээ тухайн хүнээ хүндлэх, зөвөөр ойлголцох гэдэг зүйлийг ер мартаж болохгүй. Танихгүй хүн зөрөхдөө мөрлөөд өнгөрвөл хэдий та буруугүй ч уучлалт гуйх ухамсартай байх нь чухал. Ийм энгийн зүйлээс харилцааны зөв хэлбэрүүд эхэлдэг юм. Ядуу, өвчтэй, халтар, муухай ямар ч байсан хүнийг хүн гэдэг утгаар нь хүндэлж харилцах нь харилцааг улам бататгаж байдаг. Өөрөөр хэлбэл ямар ч хүнийг гаднах байдлаар нь дүгнэлгүй харьцах нь чухал. Манай сургуульд гаднах байдлаар дүгнэх нь харьцангуй гайгүй боловч харилцааны хувьд жоохон гунигтай санагддаг. Яагаад гэвэл анх орж ирээд сургууль болон хүүхдүүдтэй танилцаж байхдаа үнэхээр их айж байсан. Айдас маань маш энгийн л дээ, яг яаж зодуулдаг бол гэхээс л шар үс босоод хөлс цуваад, угаасаа намайг өлхөн зодчихоор гарууд ууртай ууртай хажуугаар зөрөөд л... Маргааш нь нөгөө аймар гаруудаас нь айгаад л за манай ангид тиймэрдүү гаруудаас байхгүй байгаасай гээд л хамаг мэддэг тарни залбирлаа уншаад эхний цаг дээрээ хоцорч орсон чинь аймар эелдэгээр тэр өдрийн харилцаа эхэлсэн. Хуучин сургуулийн хүүхдүүд маань ихэнх нь дуугүй, дотогшоогоо, асуудал үүсэхэд түүнийгээ хэлэхгүй байж байгаад гэнэт уурлаж, тэсэрдэг зантай. Гэтэл гадны хүмүүс илүү нээлттэй, асуудал гарахад түүнийгээ нууж хаалгүй чөлөөтэй ярилцаж шийддэг.

Ийм болохоор тэд асуудлыг хүндрэл биш юм шигээр бодож, амархан даваад гарчихдаг юм. Өөрт үүссэн асуудлаа дотроо бодож, шаналсаар байгаад түүнээсээ болоод их ууртай, догшин болчихдог. Уул нь манай сургууль харилцааны хувьд дажгүй юм шиг санагддаг гэхдээ 2020 оны 9 сарын 22нд манай сургуульд нэгнийгээ хутгалж гэмтээсэн хэрэг гарсан. Авто машин засварын ангийн Б сургуулийн үүдэнд хоёр охин явж байхад нь бөгснөөс нь барих гэж оролдсон. Энэ үйлдлийг нь зогсоохоор хоёрдугаар дамжааны Х, Б ирээд алгадсан гэсэн. Тэгээд нөгөө алгадуулсан хүүхэд хоёрдугаар дамжааныханд ингэж дээрэлхүүлэхгүй гээд зодолдсон байгаа юм. Тэгээд нэг хүүхдийг хэвлийн тус газарт нь хутгалж, гэмтээсэн. Тухайн хүүхдийг манай сургуулийн эмч цаг алдалгүй боолт хийж, яаралтай түргэн тусламж дуудсан. Энэ хэдий миний оролцох асуудал биш ч гэсэн харилцаа муудах нь ямар том хэрэг тарьдагыг эндээс харж болох юм. Энэ явдлаас үүдэн суралцагч бидний харилцаа, сайжруулах арга зам сэдвээр судалгааны ажил хийхээр сонголоо.

Зорилго:

Өөрийн сургуулийн суралцагчдын дунд харилцааны ямар асуудал байгааг судалж, цаашид сайжруулах арга замыг эрэлхийлэх,

Зорилт:

Харилцаа гэж юу болох, харилцаа хандлага амжилтын үндэс болохыг судлах
Сургуулийн орчинд гардаг харилцааны асуудлыг илрүүлэх
Эерэг харилцаа үүсгэхэд шаардлагатай зан чанаруудыг таниулах
Хувь хүн өөрийн харилцаагаа сайжруулах арга замыг эрэлхийлэх
Soft skills буюу зөөлөн ур чадвар ажилд ороход чухал шаардлагатай болох нь

Онол

Зан чанар нь хүний ёс суртахуун, итгэл үнэмшил, үнэ цэнэ зэрэг сэтгэцийн шинжийг илэрхийлдэг. 2000 оны эхэн үеэс зан чанарыг нарийвчлан судалж эхэлсэн. Хүний зан өөрчлөгддөг нь амьдралыг үзэх үзэл, итгэл үнэмшил, үнэ цэнэ, ёс суртахууны хэм хэмжээ өөрчлөгддөгтэй холбоотой юм. Иймд:

«Цаг цагаараа байдаггүй, цахилдаг хөхөөрөө байдаггүй» гэдэгтэй адил хүний зан чанар нэг хэвд байх боломжгүй юм. Гагцхүү хүний амьдралын суурь мэдрэмж болох итгэл үнэмшил, үнэ цэнэ, сэтгэл зүйн төлөв байдал болон ёс суртахууны хэм хэмжээ зэргээс шалтгаалан эерэг эсвэл сөрөг тал руу өөрчлөгдөх асуудал гарна. Хэдий хүний төлөв байдал болох шинж чанар болон зан чанар болон зан чанар утга нэг, хольж сольж хэрэглэгддэг ч хоорондоо ялгаатай. Төлөв байдал нь ерөнхий шинж бол харин зан чанар бол зан үйлийн илрэл юм. Хүний зан тухайн хүний төлөв байдлыг илэрхийлнэ. Тухайлбал хөнгөн, хуумгай догшин хэрцгий гэх мэт. Монгол хэлний их тайлбар толинд (2018) зан чанарыг «Хүний сэтгэлийн хөдөлгөөн, ааш авирын ерөнхий төлөв» гэж тодорхойлсон байна. Зан чанар гэдэг үгийг ааш араншин гэдэг ойлголттой хавсарч хэрэглэдэг. Араншин гэдэг нь хүний төрөлхийн зан ааш гэсэн үг (Монгол хэлний их тайлбар толь, 2018). Араншин нь хүний биологийн чанартай холбоотой араатанлаг шинж юм. Ааштай гэх ойлголт нь хүүхдээрээ гэсэн үгтэй аж. Хүүхдэд зан чанар төлөвшөөгүйтэй холбоотой тэд ааш араншинаа гаргадаг. Хүний араншин зан чанар болдог. Араншин «Ид»-г төлөөлдөг бол зан чанар «Эго»-г төлөөлдөг. Ёс суртахуун «Суперэго» ба араатанлаг «Ид» хоёрыг зан буюу «Эго» зохицуулдаг. Зан чанар сайтай хүн гэдэг араатанлаг биш, хэт баригдмал биш, амьдрал болон нөхцөл байдал уян хатан, тэнцвэртэй хандаж чаддаг хүнийг хэлэх ажээ. Харин сөрөг зан чанар гаргаж байгаа хүн «Төлөвшөөгүй ааш араншинтай», хоромхон зуур мэдрэгдэх хүсэл, хяслаа дарж чаддаггүй хүн юм. Сэтгэл зүйн насны хувьд хүүхдээрээ болон сэтгэцийн эмгэгтэй хүнд зан чанар бус ааш араншин нь илэрдэг. Петерсон ба Силегмэн нар хүний зургаан давуу чанарт үндэслэн бусад 24 шинж чанарыг тодорхойлсон (Peterson & Siligman, 2004). Сайхан ааштай, сайн хүн гэдэг ерөнхий ойлголтыг задлан доорх давуу байдлыг бид хүүхдэдээ болон өөртөө бий болгох нь тустай.

Философийн үүднээс ёс зүй гэдэг нь нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн үнэ цэнэ, зан үйлийн хэм хэмжээ бол ёс суртахуун нь хүний амьдралын зарчим юм.

(Cottone & Tarvydas, 2016) Өөрөөр хэлбэл, нийгэм, байгууллага, шашны удирдагчид бусдын дагавал зохих ёс зүйн хэм хэмжээг боловсруулдаг бол ёс суртахуун нь хүний чанар, хүнлэг ёс, хариуцлага хүлээх чадвар билээ.

Ёс суртахуун нь нэгт шударга ёс, хүний эрх, ёс зүйн хэмжээ, нийгмийн сайн сайхны төлөө, хоёрт эрх мэдэл болон уламжлалтай холбоотой хүндэтгэлийн түвшинд, гуравт хувийн сонголт болох үүрэг хариуцлагын хүрээнд үүсдэг (Ferrari & Okamoto, 2003). Америкийн сэтгэл судлалын эцэг, функционал сэтгэл судлалыг үндэслэгч Уильям Жеймс (1902) ёс суртахуунтай зан үйл нь сэтгэл хөдлөл болох хайр, итгэл найдвар дээр суурилах ёстой гэж үзсэн.

Гэтэл зарим нийгэм, шашин, бүлгийн хүрээнд тухайлбал нацист, социалист, террорист зэрэг бүлгэмийн ёс зүйн хэм хэмжээ нь хувь хүний ёс суртахуун болох хайр, итгэл, найдварын эсрэг чиглэсэн байдаг.

Энэ тохиолдолд хүн яагаад хүнлэг чанар, ёс суртахууныхаа хэм хэмжээнээс няцдаг вэ?

«1961 онд Дэлхийн 2-р дайны үеэр олон тооны хоригдлыг хоморголон хөнөөсөн үйл явдлыг зохион байгуулсан Герман хурандаа Адольф Эйхменийг шүүх хурал болсон. Түүнд ял тулгахад тэрээр эсэргүүцэн «Зөвхөн тушаал биелүүлсэн» гэж өөрийгөө өмгөөлсөн. Энэ хэргээс үүдэн Йелийн их сургуулийн эрдэмтэн Стенли Милграм хүний тушаал биелүүлж буй чиг хандлагын талаар судалгаа явуулсан. Тэрээр 20-50 насны 40 эрэгтэйгээс судалгаа авахад тэдний 65% нь өгсөн даалгаврын хүрээнд хүн алахад ч бэлэн байсан судалгааны үр дүн гарсан нь тухайн үеднэлээн шуугиан тарьсан. Ийнхүү дарангуйлах, хүчирхийлэх, тулган шаардах зэрэг өгсөн үүрэг даалгаврын дор хүн өөрийн ёс суртахууны хэм хэмжээнээс халин бүлгийн буюу бусдын ёс зүйн хэм хэмжээг зөв гэж дагахаас өөр аргагүй байдалд хүрдэг.

Гэхдээ бүлгийн болон бусдын хүчинд автсан ч өөрийн ёс суртахууны бат бөх зарчим болох хайр, итгэлээр хөглөгдсөн хүн амархан ёс зүйн хэмжээсийг зөрчдөггүй. Цэнэггүй, тусгаар бие хүн болоогүй хүн бусдын эрхшээлд эсрэгээрээ өөрийн тогтсон үзэл баримтлалгүй, үнэ автах нь хялбар байдаг. Тэрээр итгэл, найдвар, энэрэх сэтгэл дээр суурилсан өөрийн үзлээсээ урван, зөв бурууг дэнслэх гэхээс илүү бусдыг аялдан дагасан, аймхай хулчгар болдог.

Эцэст нь хэлэхэд, ёс суртахуунт хүн гэдэг нь хайр, итгэл найдвараар хөглөгдсөн хүнийг хэлнэ. Өөрөөр хэлбэл, хайраар дүүрэн, өөртөө болон бусдад итгэх итгэлийг өвөртөлсөн хүн ёс суртахуунт хүн ажээ. Учир нь ийм хүн бусдын эсрэг дайснагасан хандлага, зан үйл гаргадаггүй харин ч эсрэгээрээ сайн сайхан нийгмийг цогцлоохын төлөө амьдарч чаддаг байна.



Soft skills буюу зөөлөн ур чадварыг чухалчилж үзэх нь

Одоо үед ажилд ороход Soft skills буюу зөөлөн ур чадварыг чухалчилж үзэх болсон. Учир нь сонгосон мэргэжилдээ сайн байлаа ч бусадтай ойлголцож чадахгүй, багаар ажиллаж чадахгүй, бусдыг хүлээн зөвшөөрөхгүй бол тухайн ажилтантай хамтарч ажиллахад хэцүү байх болно. Тэгэхээр эндээс эерэг зөв харилцаа нь амжилтын үндэс гэдэг нь харагдаж байна. Ажлын байран дээрхи сонгон шалгаруулалт хийхдээ ажил олгогчид энэ хоёр ур чадварын аль алиныг нь хардаг.



Харин Зөөлөн ур чадвар гэдэг нь хувь хүний өөртэй нь холбоотой чадварууд юм. Үүнийг үнэлж, тодорхойлоход төвөгтэй, хугацаа их шаардагдах магадлалтай. Үүн дотроо харилцааны ур чадвар, бусдыг сонсох мөн бусдыг мэдэрч ойлгох гэх мэт хувь хүнийг амжилтанд хүргэх бүх л зан чанарууд ордог. Ажил олгогчид илүү энэ чадварыг чухалчилж үздэг. Тиймээс зан чанарыг нь ажилд авч ур чадварыг нь хөгжүүл гэдэг билээ.













Хатуу ур чадвар нь ажилтны ажил үүргээ гүйцэтгэхэд нь шаардлагатай мэдлэг, сурсан нарийн чадваруудыг хэлнэ. Энэ чадварыг их сургууль, курс дамжаа болон ажлын туршлага дээрээсээ олж авдаг. Хатуу ур чадварыг үнэлж тодорхойлоход хялбархан, жишээ нь хэрвээ IT-ын мэдлэг чадвартай мэргэжилтэн шаардлагатай бол түүний ажлаа хэр зэрэг гүйцэтгэж байгаагаас энэ чадвар тодорхойлогдох юм.



Судалгааны хэсэг

Судалгааг түүврийн аргаар авч нэгтгэсэн. Судалгаанд 8 мэргэжлийн 6 ангийн 120 суралцагч хамрагдсан. Нийт судалгааг нэгтгэхэд дараах үр дүн гарсан болно.



Дүгнэлт

Судалгааны үр дүнгээс харахад сургуулийн коридорт бусдыгаа мөрлөдөг, муухай харцаар айлгадаг гэх мэт харилцааны хамгийн наад захын асуудлууд дийлэнх суралцагчдад тохиолдож байна. Энэ нь надтай адилхан шинээр элсэж байгаа суралцагчдад айдас төрүүлдэг нь мэдээж. Суралцагчдын хувьд бусдаас эерэг харилцаагаа хүсдэг, өөрсдөө харилцаагаа сайжруулахыг хүсдэг, өөрийг нь сайн мэдэхгүй байж таамагаар мэддэг юм шиг ярих нь үнэхээр бухимдуулдаг гэсэн байна. Мөн бусад хүн намайг ойлгодог байгаасай, бусад хүн намайг сонсдог байгаасай, хүндэлдэг, хүлээн зөвшөөрдөг байгаасай гэж бүх хүмүүс боддог байна. Харилцаанаас үүдэн асуудал үүсэх нь олширч байна. Судалгаанаас үзэхэд хүүхдүүд эерэг харилцааг эхлүүлэх гэж хичээдэг ч сайн үр дүнд хүрж чаддаггүй сөрөг талруугаа шилжих нь асуудал болоод байна.

Хүүхэд гэр бүлийн толь гэж манай ахмадууд ярьцгаадаг. Тэгвэл ямар нэгэн харилцааны асуудалтай хүүхдүүдийн ар гэрт нь асуудал байгаа юм биш биз гэсэн асуудал гарч ирж байна. Харилцааны болон сэтгэл судлалын номноос харж байхад хүүхдийн зан чанар, харилцааны асуудлууд нь бага насанд нь төлөвшдөг гэж бичжээ.

Судалгааны 5-р асуултан дээр чамтай харилцааг эхлүүлсэн хүн хэд гэсэн асуултанд найз нөхөд гэж ихэнх суралцагчид хариулсан байна. Хүүхдүүд гэр бүлдээ зөв ойлголцдог, ямар 1 асуудал байхгүй бол гадуур гудамж талбайд уур бухимдалтай өсвөр насныхан болон насанд хүрэгчид байхгүй байх болов уу. Миний бодлоор өсвөр насныханы хамгийн сайн ойлгодог, зөвлөдөг, зөв чиглүүлдэг хүмүүс нь аав, ээж нь байх ёстой гэж боддог. Өсвөр насныхан ч бас аав ээжээ хүндэтгэн, тэднээс суралцдаг байх ёстой. Өсвөр насанд уур ир хүрдэг, бид уурлах ёстой гэсэн хандлагаар хандах нь буруу гэж боддог. Эдгээрээс дараах нэгдсэн дүгнэлтүүдийг хийж байна.

1. Сургуулийн орчинд суралцагчдын дунд харилцааны таагүй хэлбэрүүд байсаар байна
2. Суралцагчид өөрсдийн харилцаандаа дүгнэлт хийж, хүлээцтэй найрсаг харилцаж сурах нь олон найз нөхөдтэй болно, хүмүүс чамтайг хүрээлж эхэлнэ
3. Сургуулийн орчинд бусадтай эерэг харилцаж сурсанаар ажилд ороход шаардагдах зөөлөн ур чадвараа хөгжүүлж, улмаар хүссэн ажилдаа орж чадна.
4. Бусадтайгаа зөв харилцсанаар аливаа эрсдэл гэмт хэрэгт орохгүй
5. Гадаад хүмүүс яагаад аливаа асуудлыг амархан шийдэж чаддаг вэ гэвэл асуудалд хандах хандлага, цаашлаад сэтгэл зүйн мэдлэгтэй байдаг
6. Өсвөр насныхан бид гэр бүл зохиож үр хүүхдээ төрүүлэхдээ хүүхдийг аюулгүй тайван, өөртөө итгэлтэй, харилцааны ямар нэг асуудалгүй орчинд өсгөж хүмүүжүүлэх нь чухал юм байна гэсэн дүгнэлтэнд хүрлээ.

Ном зүй

1. Харилцаа Цэрэндагвийн Шинэдолгор Хуудас 26,57
2. Хүний хөгжил ба сэтгэл зүйн зөвлөгөө Д.Мөнхцэцэг Хуудас 159-163
3. <https://mn.chalized.com/зөөлөн-ур-чадвар-гэж-юу-вэ/> Сайт

[illegible]

Анги: Хувцсны загвар зохион бүтээлт За
Гүйцэтгэсэн: Жамъян овогтой Жавзандолгор
Удирдсан багш: Хувцас загвар, дизайны багш М. Энхтуяа



Агуулга

Удиртгал

1. Зохиомжийн хэсэг
 - Судалгааны хэсэг
 - Жигот ханцуйн судалгаа
 - Зохиомж, загвар сонголт
2. Материалын шинж чанарын судалгаа, сонголт
 - Материал сонголт
 - Материалын шинж чанарын туршилт
3. Зохион бүтээлт
 - Шинэ загварын зохион бүтээлтэд шаардлагатай биеийн хэмжээ, сулын хэмжээ
 - Шинэ загварын загварчилгаа, туршилт
 - Бүтээл
4. Дүгнэлт
5. Ном зүй



Удиртгал

Сэдэв сонгох үндэслэл:

Олсыг зөвхөн ахуйн хэрэглээнд буюу барилгын байгууламжийн ажил, спорт, хадганд авиралт, олс таталт, гар урлал, аврах ажлагаа, гэр ахуй зэргээр өргөн ашигладаг хэдий ч хувцасны нэгэн гоёл чимэглэл хувцасны фактур болгож хэрэглэж байна. Салаалсан хэлбэр, гадаргуун шинж чанар миний сонирхлыг татаж хувцасны хэрэглээнд оруулах боломж байгааг олж харсан. Энэ нь миний загварын санааг гаргах боломжийг бүрдүүлсэн. Загвартаа эмэгтэйлэг, гуалиг нарийн бэлхүүс, урт хөл болон энгэр цээж хэсгийг тодотгож өгсөн. Эдгээрийг гаргахын тулд 16-р зууны үед түгээмэл стиль болж байсан бөмбөгөр ханцуй эмэгтэй хүний гоё сайхан нарийн бэлхүүсийг тодотгосон загваруудад дээрх судалгааг хийсэн. Шинэ загвараа эмэгтэй хүний энхрий ялдам, эмэгтэйлэг хирнээ хүчирхэг төрхийг гаргахдаа төдийлөн ашигладаггүй, онцлог элемент болох олсны мушгирсан хэлбэрээр чимэглэл байдлаар илэрхийлж болохуйц харагдаж энэ сэдвийг сонгосон.

Зорилго: Энэхүү эмэгтэйлэг, нарийн бэлхүүс, уян зөөлөн дүр төрхийг олстой хослуулан гаргаж хувцасны шинэ шийдэл боловсруулахыг зорьж байна. Олсыг хувцсанд гоёл чимэглэлийн зориулалтаар оруулж болдог гэдгийг хүмүүс таньж мэдүүлэх зорилготой.

Зорилт:

- Олсны анхны үүсэл хөгжлийн түүхэн судалгааг хийх
- Судалгааны сонирхолтой хэсгүүдийг шинэ загварын хувцсанд тусгах
- Шинэ загварын хувцсанд тохирох материал сонголтыг хийх
- Хэв шинжит хүний биеийн хэмжээн дээр суурь үлгэрийг байгуулж загварчилгааг хийх
- Туршилтын даавуун дээр макетыг турших
- Бүтээл болгох

Судалгааны ач холбогдол :

Баяр ёслол болон гоёлын зориулалтаар өмсөж болохуйц загварын хувцасыг олстой хослуулж эмэгтэйлэг, гоё чамин хээнцэр байдлыг хослуулж өгснөөрөө хүмүүст шинэлэг сонирхолтой санааг өгч байгаараа ач холбогдолтой.

Судалгааны аргууд : —

- Эрэл хайгуулын арга
- Ажиглалтын арга
- Зохиомжийн арга


1. Зохиомжийн хэсэг

- 1.1. Олсны үүсэл гарлын судалгаа
- 1.2. Жигот ханцуйн судалгаа
- 1.3. Зохиомж, загвар сонголт

1.1. Олсны үүсэл гарлын судалгаа

Олсыг хүн төрөлхтний соёл иргэншлийн эхэн үеэс ашиглаж ирсэн. Хамгийн эртний олс нь байгалийн гаралтай ургамлын ургац байсан. Усан үзмийн ороонгыг ашиглан утаснуудыг хооронд нь мушгиж, сүлжих анхны оролдлогыг хийж эхэлсэн нь олс үүсэх үндэс болсон юм. МЭӨ 15000 оны үед хамаарах Ласкау дахь нэгэн агуйгаас 50,000 жилийн тэртээх ашиглаж байсан маш жижиг олсны хэлтэрхий олдож байсан байна. Энэ олс нь 7 мм орчим диаметртэй хоёр давхар тавигдсан чулуужсан хэлтэрхийнүүд байсан.

Эртний египетчүүд анхны олс хийх тусгай хэрэгслийг бүтээсэн байж магадгүй гэж үздэг. Египетэд олс МЭӨ 4000-3500 онд үүссэн бөгөөд усан үзэмний зэгсний утаснаас гарган авдаг байсан. Үүгээрээ олсыг үйлдвэрлэдэг байжээ. Эртний олсыг маалинга, өвс, папирус, арьс шир, амьтны үс зэрэг ислэгээр олон төрлөөр хийж байсан. Мянга мянган ажилчдын ороож эрчилсэн олсыг ашиглан, египетчүүдэд хөшөө дурсгалаа барихад шаардагдах хүнд чулууг зөөх боломж олгож байжээ. МЭӨ ойролцоогоор 2800 оноос эхлэн олсны ширхгээр хийсэн олс Хятадад ашиглагдаж эхэлсэн. Олс хийх гар урлал нь Ази, Энэтхэг, Европ даяар тархан олсыг үйлдвэрлэх болсон.



а. Олс эрчлэх төхөөрөмж Зураг 1

Дундад зууны үеэс 18-р зууны үе хүртэл Европт урт нарийн олсуудыг дэлгэж, дараа нь хооронд нь холбож эсвэл мушгиж илүү бүдүүн том олс үүсгэдэг байв. Маттерорм музей. 1865 оны 6-р сарын 14-ний анхны тасарсан олс. Швейцарийн Альп. Валеис. Швейцар. Европ.



Маттерорм музей. 1865 оны 6-р сарын 14-ний анхны тасарсан олс. Европ Зураг 2

18-р зууны эхэн үеэс олсны үйлдвэрлэл эрчимтэй хөгжиж эхэлсэн. Haskell-Dawes Machine Company нь 19-р зууны сүүлч, 20-р зууны эхээр Бостон (АНУ-ын нэгэн хот), МА, Пеннсилванийн Филадельфи хотод олс үйлдвэрлэх машин үйлдвэрлэж байсан. Энэхүү олс үйлдвэрлэх машин нь анхнаасаа маалинган, сисал, хөвөн гэх мэт байгалийн шилэн олс хийж байсан.



Европын хамгийн том олсны үйлдвэрлэл /Зураг -3/

Олс нь 1950-иад оноос хойш олсны үйлдвэрлэл улам бүр түгээмэл болж ирсэн Nylon, полипропилен зэрэг синтетик утас давамгайлж байгаа ч гэсэн зарим олс нь sisal зэрэг байгалийн утаснаас гаралтай хэвээр байна. Олсыг ерөнхийдөө зарим байгалийн буюу синтетик утаснаас гарган үйлдвэрлэх болсон. Олсны нийтлэг байгалийн утас нь манила, олсны ургамал, маалинган даавуу, хөвөн, ороомог, жут, сүрэл, сисал юм. Олс хийхэд ашигладаг синтетик эслэгт полипропилен, нейлон, полиэфир, полиэтилен, арамид ба нийлэг орно. Олс нь торго, ноос, амьтны үс зэрэг бусад ширхэгтэй материалаар хийгдсэн байдаг боловч ерөнхийдөө төдийлөн их байдаггүй. Район бол гоёл чимэглэлийн олс хийхэд ашигладаг сэргээгдсэн шилэн утас юм.



Байгалийн хөвөн олс Зураг 4

1.2 XVI – р зууны жигот ханцуйн судалгаа

Ханцуй: Жигот буюу хонины хөл ханцуйг 16р зуун анх харж байсан. 1820-аад оны сүүлч, 1830-аад оны эхээр (ойролцоогоор 1824-1836 он) дахин загварлаг болж, дараа нь 1890-ээд онд дахин нэг болжээ. Жигот бол франц хэлээр амьтны хөл ялангуяа хонь, хурга гэсэн утгатай бөгөөд ханцуй нь яг ийм хэлбэртэй байсан учраас ингэж нэрлэж байсан. Эдгээр ханцуйг нэвтрүүлэх болсон нэг шалтгаан нь 1820-1825 он хооронд эзэнт гүрний хэв маягаас романтик даашинзны хэв маягт шилжиж байсан явдал юм. Үүний үр дүнд бүсэлхийн шугам доошилж, 1825 онд гэхэд даашинзны бэлхүүс эмэгтэй хүний өөрийн бэлхүүснээс хэдэн инч дээш өргөгдсөн байсан. Ханцуй томрох тусам бэлхүүс нарийн гуалиг харагдуулдаг байсан. Бүсэлхийн шугамыг өөрчилснөөр илүү том ханцуй хөгжүүлэх бусад өөрчлөлтүүдийг авчирсан. 1829 он гэхэд дээд гарын илэрхий хэмжээ нь бэлхүүснээс хоёр дахин их байсан бөгөөд олон ханцуйд хэлбэр дүрсээ хадгалахын тулд доош чихмэл дэвсгэр, хатуу муслин (хатуу даавуу), эсвэл бакрам (хатуулга), эсвэл бүр халимны цагираг (олон цагирагнаас бүтсэн хэрбэлжүүлэгч) бүрэх шаардлагатай байсан.



а. 1830



б. 1894



в. 1834

Зураг -5 /а,б,в/

Эдгээр жигот ханцуй нь ихэвчлэн тохойноос доогуур чанга тул товчлох шаардлагатай байдаг. Хэдийгээр ажил хэрэгч бус боловч 1820-1830-аад оны үед эмэгтэй хүний өмссөн бараг бүх зүйл дээр ийм ханцуйвч олддог байв. Жишээлбэл, далайн эргийн хувцас, явган аяллын даашинз, явган чуулга, морь унаж хэвших, гашуудлын хувцас, үдшийн даашинз зэрэг нь бүгд байсан.

1.3 Зохиомж, загвар сонголт

Баяр ёслол, гоёлын үйл ажиллагаанд тохирсон эмэгтэйлэг загварлаг харагдуулах зориулалттай. Гоёмсог ба энгийн байдлын цогц илэрхийлэл болсон элегант стиль нь дээд зэрэглэлийн чанартай материал, энгийн хирнээ тансаг чимэглэл, 2-3 өнгийн хослол зэргээр эмэгтэйлэг хэрнээ хүчирхэг дүр төрхийг бий болгодог стиль юм.

Классик буюу сонгодог стильтэй элементүүдээрээ бага зэрэг төстэй ч гоёл чимэглэл, малгай, шил, бээлий, цүнх, гутал зэргээр хослуулж, өөрчлөн хэрэглэснээрээ элегант стилийг бий болгодог. Ажил, албан тушаалын хувьд тогтсон, өөрийн хэв маягаа олсон эмэгтэйчүүдийн стиль. Мөн энэ стилийг тодорхойлох хэлбэр (силуэт) нь Х буюу элсэн цаг хэлбэртэй хувцаслалт юм. Ихэвчлэн хуримын, гоёлын, зуны хувцаснууд энэхүү стилийг хийгддэг. Х буюу элсэн цаг хэлбэрийн силуэтийг гаргахдаа XI зууны эмэгтэйчүүдийг хэрэглээ болж байсан жигот ханцуй буюу нарийхан бэлхүүс тодотгох хэлбэр, силуэтийг өөрийн шинэ загварын эскизэндээ тусгаж өгсөн. /Зураг-7/



Фор эскиз /Зураг-7/

Элегант хувцасны хэв маягийг илэрхийлэх шинэ загварын эскизнээ хэлбэр силуэтийн гаргасан. Хувцасны силуэтийн зохиомжийг бүрдүүлэх хэлбэрийн хуваалт, гадаргуу, чимэглэлийг олсны салаалсан хэлбэр, гадаргуун шинж чанараар илэрхийлсэн. Энэ нь эмэгтэй хүний энхрий ялдам, эмэгтэйлэг хирнээ хүчирхэг төрхийг гаргаж чадсан шийдэл болсон. /Зураг -8/



Хуваалт гадаргуу, чимэглэл /Зураг-8/

Шинэ загварын өнгө сонголт: Элегант стил нь дан өнгөөр эсвэл 2-3 өнгөтэй хослуулж гарч ирдэг учраас эдгээр эскизийн өнгө хослолыг гаргахдаа улаан, бор шаргал, ногоон, цэнхэр ба хар өнгийг ашигласан.

Улаан өнгө нь хурц тод бардам байдал харуулдаг ба хар өнгө нь эрх мэдэл, хүсэл зоригийг илэрхийлдэг учраас хувцсандаа тусгаж өгсөн. Бор шаргал өнгө нь элбэг дэлбэг, бүтээлч байдлыг илэрхийлдэг ба улбар шар өнгө нь баяр цэнгэл, баатарлаг зориг, сүр жавхаа байдлыг илэрхийлдэг нь эрхэмсэг, энхрий ялдам эмэгтэй хүний байдлыг харуулж өгсөн.

Ногоон өнгөөр дагнаж байгаа нь тайван амгалан байдал, эрч хүчтэй, шинэлэг байдлыг илэрхийлдэг учраас намбалаг, бардам байдал шинэ дүр төрхийг тодотгож өгсөн. Цэнхэр өнгө нь идэвхтэй, хөгжилтэй байдлыг илэрхийлдэг учраас хувцсыг сонирхолтой, хүсэл зорилготой байдлыг харуулсан учраас эскизэндээ тусгаж өгсөн.



Өнгөөр ажилласан эскиз Зураг 9 /а,б,в,г/

Бүтээл болгох эскиз:

Загварын гол онцлог нь эмэгтэй хүний энхрий ялдам, эрхэмсэг, хүчирхэг дүр төрхийг гаргахын тулд бэлхүүсийг тодотгосон хуваалт, бөмбөгөр ханцуй, тэгш мөр, энгийн хирнээ чамин чимэглэл зэргээр шийдсэн. Шинэ загварын хувцсандаа тайван байдал, шинэчлэл, эрч хүчийн бэлэг тэмдэг болсон ногоон өнгийг оруулж өгснөөр эмэгтэй хүний эрч хүчтэй, шинэлэг, намбалаг тайван байдлыг харуулж байгаа бөгөөд үүнтэй хослуулан хүч чадал, эрх мэдэл, хүсэл зоригтой байдлыг илэрхийлдэг хар өнгөтэй хослуулснаар энэхүү хувцас маань эмэгтэй хүний өөртөө итгэх итгэл, бардам зан, энхрий ялдам байдал, шинэлэг байдлыг харуулсан.



Бүтээл болох эскиз /Зураг-10/

2. Материалын шинж чанарын судалгаа, сонголт

2.1 Материалын сонголт

Бүтээл болгох загварын эскизийн дагуу ногоон даалимбан материал, хар капрон материал сонгож, олсыг аксессуар чимэглэлээр гадаргуун дизайн гаргахад хослуулж оруулахаар сонгосон. Сонгосон даалимбан материалын хувьд биетэй учраас биед суулт сайтай, индүүдлэг авахдаа сайн, суналтгүй, агшихгүй, будаг тогтворжилт сайн, биед харшлах сөрөг нөлөөгүй, эдэлгээ сайтай давуу юм. Даавуун дээр олсоор аксессуар чимэглэл болгон тогтоон оёход барьцтай, эвтэйхэн, оёход хүндрэлгүй, дизайны өвөрмөц шийдэл гаргасан туслах материал. Капрон тор нь гоёмсог гялгар гадаргуутай, суналтгүй, агшилтгүй, маш нимгэн, хөнгөн, хурдан индүүдлэг авч байгаа байдал зэргүүд нь эскизийг дагуу бүтээл болгоход шаардлага хангаж байсан.

Үндсэн ба туслах материалуудын нэр төрөл:



1. Үндсэн материал



2. Ханцуйнд орох капрон материал

Физик ба механик шинж чанарын үзүүлэлтүүд: Даалимбан материал нь 1,50 см-ын өргөн энтэй, биетэй, суналтгүй, агшдаггүй, индүүдлэг маш сайн авдаг, чиг бага нэвтрүүлдэг, хурдан үрчийлт авдаг, будаг тогтворжилт сайн, бага зэргийн сэмрэлттэй. Ханцуйн капрон нь гөлгөр гадаргуутай, маш нимгэн, хөнгөн, сэмрэлт ихтэй, индүүдлэг хурдан авдаг ба хурдан үрчийдэг, хувцсанд хуниас, нугалааг гаргахад маш тохиромжтой.

2.2 Материалын шинж чанарын үзүүлэлтүүдийн туршилт


Туршилт -1 Материалын үрчийлтийг энгийн аргаар тодорхойлох
Цамцны материал:

Туршилтын үр дүн:	Материал	Материал дээр туршилт хийсэн байдал
Хурдан үрчийдэг		
Хурдан үрчийдэг		
Үрчийлт багатай		



Туршилт-2 Материалын будаг тогтворжилт тодорхойлох

Туршилтын үр дүн:	Материал	Материал дээр туршилт хийсэн байдал
Цамцны материал: Будаг тогтворжилт сайн		
Будаг тогтворжилт сайн		
Өмдний материал: Будаг тогтворжилт сайн		


Туршилт-3 Материалын шаталт

Туршилтын үр дүн:	Материал	Материалын шаталтын үйл явц	Материал шаталтын дараах байдал
Цамц: Хурдан шатдаг, үнстэй, шар дөлтэй, үүрч нунтаг болж шатдаг, цаасны шаталттай ижил үнэртэй.			
Маш хурдан шатдаг, үнстэй, шар дөлтэй, хайлж наалдамхай зууралдаж бөөгнөрч шатдаг, эвгүй хурц үнэртэй.			
Өмд: Маш хурдан шатдаг, үнстэй, шар дөлтэй, хайлж наалдамхай зууралдаж бөөгнөрч шатдаг, эвгүй хурц үнэртэй.			

Туршилт-4 Материалын агшилт

Туршилтын үр дүн:	Материал	Материалын шаталтын үйл явц	Материал шаталтын дараах байдал
Цамц: Агшилгүй			
Агшилгүй			
Өмд: Агшилгүй			

Материалын ширхэг ба нэхээс:



Материалын үнийн жагсаалт:

Д/д	Материал	Хэмжих нэгж м	Хэмжээ	Нэгжийн үнэ төг	Нийт үнэ төг
1	Цамцны ногоон даавуу	М	1.00	3000	3000
2	Сорт (дотор)	М	1.50	6500	9750
3	Олс	М	100	100	10000
4	Аксессуар	Ш	75	100	7500
5	Тор	М	1.00	6000	6000
6	Капрон	М	2	6000	12000
7	Өмдний ногоон даавуу	М	2	6000	12000
	Дүн				60.250

3. Зохион бүтээлт хэсэг

3.1 Зохион бүтээлтэд шаардлагатай биеийн хэмжээ, сулын хэмжээ

3.2 Шинэ загварын загварчилгаа, макет


3.3 Шинэ загварын бүтээл

3.1 Шинэ загварын зохион бүтээлтэд шаардлагатай биеийн хэмжээ, сулын хэмжээ

Шинэ загварын зохион бүтээлтийн гаргахын тулд суурь үлгэрт шаардлагатай хэмжилтүүдийг, 46-размерын загвар өмсөгчийн хэмжээн дээр тулгуурлан 17-төрлийн хэмжилтийг хийсэн. Мөн хувцсыг хөдөлгөөн хийхэд чөлөөтэй байлгах, технологи ажиллагааны нэмэлт, загварын сулыг нэмж тооцоолон суурь үлгэрийг график тооцооны аргаар байгуулалтыг гаргасан. Шинэ загварын загварчилгааг хийхийн өмнө байгуулсан суурь үлгэрийн туршилтын даавуун дээр эсгэж суурь үлгэрийг хүний биед суулт таарамжийг шалгасан.

3.2 Шинэ загварын загварчилгаа

Сонгосон загварын эскизийн дагуу суурь үлгэр дээр загварчилгааг хийсэн. Загварчилгааг хийхдээ загварчилгааны өргөсөлтийн арга, хуваалтын аргуудыг муляжны аргатай хослуулан гаргасан. Энгэр дээр эмэгтэй хүний нарийн бэлхүүсийг тодотгох зорилгоор бэлхүүсний шугамыг ташаанаас энгэр гол болон арын гол шугамруу гурвалжин ташуулдаж загварчилсан. Цээж хэсэгт хуваалтын аргыг ашиглан мөрнөөс бэлхүүсний шугам руу загварчилгааг хийсэн. Мөн ханцуйн толгойн өндөр, өргөн ба урт дээр өргөсөлт хийж туршсан.



Загварчилгаа /Зураг -11/

Туршилтын явцад ханцуйд хийсэн өргөсөлт нь ханцуйг том бөмбөгөр харагдахад тохиромжгүй байсан учраас муляжны аргаар өргөсөлтүүдийн хэмжээг нэмж илүү том болгосон. Цээжний хормой хэсэг нь бэлхүүсний нарийн харагдуулахад тохиромжгүй байсан учраас тухайн бүрдэл хэсгийг хассан.



Туршилтын загвар /Зураг-12



Шинэ бүтээл /Зураг-13/

Дүгнэлт:

Шинэ загвар санаагаа олсноос авч, 16-р зууны үеулс орнуудын дундэлгэрсэн Жиготбуюу том бөмбөгөр ханцуйг хослуулан эмэгтэй хүний эрхэмсэг байдал, гуалиг бие галбир, эмэгтэйлэг байдлыг гаргаж өгсөн. Энгэр цээжинд хийсэн хуваалт загварчилгаа нь мөр болон хөхийг илүү тодотгож эмэгтэй хүний энхрий ялдам байдлыг гаргаж, мөн бэлхүүсийг тодотгож, том бөмбөгөр ханцуйн нь бэлхүүсийг улам нарийн харагдуулж байгаа нь Элегант болон Романтик стилийг хослуулан харагдуулж байгаа юм.

Ногоон өнгө нь тайван аюулгүй байдал, эрч хүч, үхэшгүй мөнхийн бэлгэддэг учир хувцсандаа тусгаж өгсөн. Шинэ загварын хувьд ар, энгэр, ханцуй, хормойноос бүрдэж байгаа бөгөөд энгэрийн голоор тор оруулан өгч, ханцуйн толгойноос манжет хүртлээ хуниаслаж ханцуйн бөмбөгөр хэлбэрийг капрон тороор гаргаж өгсөн. Их биед чимэглэл болгон олсыг эгнүүлэн гараар тогтоон оёж, олсны голд аксессуар чимэглэл оруулж өгөн чимэглэсэн.

Олсыг хэлбэр гадаргуу, шинж чанар талаас илүү нарийвчлан судалж, өөр шинэ шийдэл бүхий энгийн өдөр тутмын хэрэглээнд тохирсон хувцасны загвар дээр туршилт хийж ажиллана

Ашигласан ном мэдээллийн хэрэгсэл

- Ханцуй судалгаа: www.geriwalton.com, pinterest application
- Олсны судалгаа: en.wikipedia.org, pinterest application, sites.google.com
- Өнгөний судалгаа: dversam.ru, mn.wikipedia.org
- “Хувцасны дизайны өнгө зохицол”
- Ш. Саранчимэг, Ц. Нямжав “Оёмол хувцасны технологи”
- М. Энхтуяа “Хувцасны дизайны техник ажиллагаа”
- М. Энхтуяа “Хувцасны эсгүүр хийх аргачлал”

This image shows a single sheet of white paper with horizontal ruling lines. The lines are evenly spaced and run across the width of the page. There are no margins, text, or other markings on the paper.

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ БИДНИЙ АМЬДРАЛД НӨЛӨӨЛӨХ НЬ

ИЛТГЭГЧ: ХГД 1А АНГИЙН ОЮУТАН Г.ХОНГОРЗУЛ

Агуулга

1. Удиртгал
2. Онолын хэсэг
 - Мэдээллийн технологи гэж юу вэ?
 - Технологийн хувьсал хүмүүст хэрхэн нөлөөлдөг вэ?
 - Гар утасны үүсэл хөгжил, түүний хэрэглээ
3. Судалгааны хэсэг
 - Цахим орчинд идэвхтэй байдаг хүмүүсээс авсан судалгаа, үр дүнд хийсэн боловсруулалт
4. Дүгнэлт
5. Ном зүй

Сэдэв сонгосон үндэслэл:

Мэдээллийн технологи хөгжсөн өнөө үед хүүхэд, залуус бид бүхэн ухаалаг хэрэглээг зохистой хэмжээнд ашиглаж байх нь маш чухал билээ. Үүнээс гадна бидний өдөр тутмын амьдралд өргөн ашиглагддаг мэдээлэл харилцаа холбооны технологиуд нь хэр хугацаанд хэрхэн өөрчлөгдсөн тухай бага ч болов мэдээллийг та бүхэнд хүргэх болно.

Илтгэлийн зорилго:

Хорин нэгдүгээр зуунд амьдарч байгаа бидний хувьд эргэн тойронд мэдээ мэдээлийг маш олон зүйлээс хүлээн авч мөн түгээдэг болсон байгаа учир үе тэнгийн залуусдаа багахан ч гэсэн мэдлэг олгоход оршино.

Зорилт:

- Илтгэлтэй холбоотой онолын материал цуглуулж, уншиж судлах
- Цахим орчинг хэр үр дүнтэй ашигладаг талаар хүмүүсээс судалгаа авах
- Судалгааны үр дүнд боловсруулалт хийх
- Дүгнэлт гаргах
- Судалгааны арга:
- Асуулга
- Жишиж харьцуулах
- Статистик боловсруулалт хийх
- Анализ сентизын арга

2. Онолын хэсэг

Мэдээллийн технологи гэж юу вэ?

Америкийн Мэдээллийн Технологийн Холбооны (ИТАА) тодорхойлсоноор “Компьютер дээр суурилсан мэдээллийн систем, програм хангамж болон техник хангамжийн дизайн, хөгжүүлэлт, хэрэгжүүлэлт, хангамж болон удирдлагыг судлахыг хэлнэ”. Мэдээллийн технологи нь цахим тооцоолуур болон програм хангамжийг хэрэглэн мэдээллийг хувиргах, хадгалах, хамгаалах, боловсруулах, дамжуулах болон найдвартайгаар хүлээн авах тухайг судалдаг. Мэдээллийн технологи нь одоо дэлхийг хавтгайруулагч хүчин зүйл болоод байгаа бөгөөд дэлхийн хөгжлийг тодорхойлогч тэргүүн эгнээний зүйл болж байна. Мэдээллийн технологи (МТ) нь ихэвчлэн бизнес болон бусад ахуйн нэгжийн хүрээнд өгөгдөл дамжуулах, удирдаж, хадгалах, хүлээн авах компьютерийн програм мөн харилцаа холбооны хэрэгсэл юм.

Хөгжил дэвшил гэдэг хязгааргүй ч барагдах нөөцтэй дэлхийд, тодорхой хэмжээнд амьдрах хугацаатай хүн төрөлхтний хувьд эцсийн үр дүнд гарцаагүй хүнд байдалд оруулж мэдэх юм. Хүмүүс бодитоор бие биетэйгээ уулзаж, өөрийн хөдөлмөрөөр ямар нэг зүйлсийг хийж, интэрнетиин хараат бус байдалд шилжихийг хүсдэг болохыг ч үгүйсгэхгүй.

Технологийн хувьсал хүмүүст хэрхэн нөлөөлдөг вэ?

1968 оноос техник технологийн хөгжлийн талаархи элдэв мэтгэлцээн өрнөж эхэлжээ. Тэр үед өрнөж байсан яриа нь хүн төрөлхтөн удахгүй атганд багтах утсаар ярих болно тэр ч бүү хэл халааслаад авч яваад хаанаас ч холбогдож болно хэмээн утасны тухайд ярьж, нисдэг машин, асар хурдан галт тэрэг, хоёр зуун давхар байшин бий болно гэхчлэн ирээдүйд бий болох олон зүйлсийн талаар зөгнөн ярьцгаадаг байсан. Ойрын хэдэн жилдээ Мэдээллийн технологи (МТ)-ийн зээлийн төлвийг тодорхойлох хамгийн гол хүчин зүйл Digital Transformation буюу Цахим хувьсал юм. Цахим хувьсал гэдэг нь бизнесийн стратеги, бодлого төлөвлөлт, үйл ажиллагааг технологийн 4 гол чиг хандлагатай (Клауд, Ухаалаг утас, Нийгмийн сүлжээний системүүд, Их өгөгдөл) нягт уялдуулан хийхийг хэлнэ. Хүний хэрэглээ улам бүр хялбаршиж байгаа нь хэсэг бүлэг хүмүүсийн оюуны чадавхийн үр дүн гэж хэлж болно. Харин бэлэн бүтээгдэхүүн хэрэглэгчдийн хувьд энэ нь сөрөг нөлөө үзүүлж байж болох юм хэмээн АНУ-ын социологич Харви Сакс үзэж байгаа юм. Сүүлийн хоёр жилийн дотор маш эрчимтэйгээр дэлхийн нийтийн интэрнетиин хэрэглээ асар хурдтай өссөн. Энэ нь ухаалаг төхөөрөмжөөр дамжуулан интэрнет ашиглах болсон нь ийнхүү нөлөөлж байгаа юм. Мөн техник технологи хөгжихийн хэрээр хүмүүсийн хоорондох бодит харилцаа үгүй болж байгаа нь маргаангүй үнэн. Оюун ухааны хэт зарцуулалт нь хүмүүсийг орчноос таслах шалгаан болж байгаа. Түүнчлэн хүмүүс асар их мэдээлэлтэй болж ирсэн нь зарим талаараа сөрөг үр дагаварт хүргэх жишээтэй. Зарим нэг ухаалаг утасны талаарх сонирхолтой баримтуудаас:

- Дэлхий дээрх 10 хүн тутмын 6 нь 00-д утастайгаа ордог байна.
- Хүн өдөрт дунджаар 110 удаа утсаа “цоожилж”, ямар ч хэрэгцээгүй хэрнээ нээж үздэг.
- Өнгөрсөн жил гэхэд л дэлхий даяар нийт 1.3 тэрбум ухаалаг гар утас зарагдсан байна.
- Таны ухаалаг гар утас 1969 онд сансарт аялж байсан “Apollo 11” сансрын хөлгийн хянах дэлгэцнээс хэт дахин их хүчин чадалтай гээд боддоо.
- “Номофобиа” бол гар утаснаасаа салахаас айх айдсын нэршил юм.
- Ухаалаг гар утас худалдаанд гарахаас өмнө 200 сая “Nokia” маркийн товчлуурт гар утас зарагдаж байжээ.

- GSM стандартад нийцэх анхны гар утсыг “Alcatel” компани зохион бүтээж байжээ.
- Англи улсад жилд дунджаар 100,000 гаруй гар утас 00-д “харамсалтайгаар” унадаг. Энэ нь дэлхий дээр байгаа 5 хүн тутмын нэг нь ингэж унагаадаг гэсэн үг юм.
- Хятадууд компьютерээс илүү гар утсаа түгээмэл хэрэглэдэг бөгөөд, гудамжаар утсаа оролдон явж байгаа хүмүүсийг гэнэтийн ослоос сэргийлэх тусгай зам хүртэл тавигджээ.
- Япончуудын хэрэглэж байгаа гар утасны 90% нь уснаас хамгаалагдсан.
- Арван Франц хүн тутмын 4 нь “утасны дон” туссан байдаг.

Гар утасны үүсэл хөгжил, түүний хэрэглээ

1973 онд Мартин Күүпер болон түүний “Motorola” компанийн багийнхан өнөөдрийн бизнесүүд болон өсвөр насныхны амьдралыг хөдөлгөөнд оруулдаг цор ганц зүйл болох нэг зүйл зохион бүтээсэн нь — гар утас байман юм.. Энэ нь тоосгоны дайтай байсан бөгөөд бүх нийтийн худалдаанд гарах хүртэл дахин арван жил болсон.

“Күүпер” Тэр үед интеграцчилсан холболтууд байгаагүй. Компьютерууд, богино холбоосын зурагтууд, LCD дэлгэцүүд байгаагүй. Тийм зүйлс 1973 онд бүтээгдээгүй байсан юм. Гэвч бид олон жил автомашины утас зохион бүтээсэн бөгөөд бид хувь хүмүүст зориулсан илүү хөдөлгөөнт, авсаархан утас зохион бүтээх цаг болсон гэж үзсэн. 100 жилийн туршид хүмүүс ширээн дээрээ, эсвэл гэртээ байгаа утсаар хоорондоо холбогдсон утаснуудад холбоотой, түүгээр хязгаарлагдсан байсан. Одоо хүмүүсийг автомашинд нь занганд оруулах хэрэг үү? Энэ бол нэг их сайн зүйл биш. Тэгээд бид “AT&T”-тэй өрсөлдөхөөр шийдсэн. 1973 онд бид гайхалтай танилцуулга зохион байгуулсан. Хамгийн сайн танилцуулга бол утсаа бүтээгээд түүгээрээ хүн яриулах явдал гэж бид үзсэн. Тэгээд бид утсаа бүтээсэн” хэмээн хэлж байжээ.

Анхны утасны хэмжээний хувьд 11-11 инч (25-27 см) өндөр 1.5 инч өргөн, 4 инч зузаан байсан бөгөөд 2.5 паунд жинтэй байсан. Үнийн хувьд эхний утаснууд арилжааны зориулалтаар бүтээгдээгүй бөгөөд нэг сая орчим ам.долларын өртөгөөр бүтээгдсэн байна. Харин түүнээс хойш арван жилийн дараа 1983 оны 10 сард гар утсаа худалдаанд гаргахад нэг нь 3,900 ам.долларын өртөгтэй байсан. Өнөөгийн шилжүүлсэн ханшаар бол нэг гар утас бараг 10,000 ам.доллар байжээ.

Харин Монголын хамгийн анхны ухаалаг утас бол Эхлэл брэндийн “Hulan-21” юм. Монгол инженерүүдийн ур ухаан шингэсэн гар утас үйлдвэрлэхээр нийт 11 мэргэжилтэн 2 жилийн хугацаанд ажиллаж байна. Гар утасны суурь системийг 100 хувь монгол программистууд бүтээж байгаагаараа онцлог бөгөөд эхний гар утсаа энэ оны наймдугаар сарын 18-нд хэрэглэгчийн гарт хүргэхээр ажиллаж байна. 16-28 насны эдгээр залуус Монголдоо үйлдвэрлэх гар утасны загвараа “Hulan-21” гэж нэрлэсэн бөгөөд 21 нь энэ оныг, “Hulan” гэдэг нь Чингис хааны хамгийн хайртай хатны нэрээр бэлгэджээ.

Тус утасны хамгийн дээд үнэ нь 900 мянган төгрөг байх юм. Одоогоор, техникийн шинжилгээ төлөвлөгөө нарийн тодорхойлолтуудаа гарган судалгааны шатыг дуусгаад байгаа бөгөөд үйлдвэрлэлийн шатандаа ороход бэлэн болжээ. Түүхий эдийн 80 хувь нь гадных, 20 хувийг дотооддоо бүтээж байгаа ажээ. Үйлдлийн систем нь хамгийн сүүлийн үеийнх “Android-11” ашиглана. Мөн монгол хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан программууд суулгах юм. Мөн “Hulan-21”-ийг монголчуудын хийсэн аппликейшнээр баяжуулах аж. Цаашдаа тус брэндийг гадаадад гаргах зорилготой ажиллаж байна.

Компьютерийн хувьсал

Хүний нийгэм үүссэнээс хойш биеийн хүчний хөдөлмөрийг хөнгөвчлөх багаж техникийн хөгжилт нь оюуны хөдөлмөрийг хөнгөвчлөх багаж техникийн хөгжилтэй харьцуулахад XIX зуун хүртэл харьцангуй хурдтайгаар хөгжиж ирсэн. Нийгмийн хөгжлийн явцад хүний сэтгэн бодох, тооцоолох үйл ажиллагааг орлох техник хийх санаа, зорилго хүний анхаарлыг их татаж байв. Олон зуун жилийн туршид хүн төрөлхтний бүтээсэн уурын хөдөлгүүр, суурь машин, нисэх онгоц зэрэг нь цөм хүний биеийн хөдөлмөрийг хөнгөвчлөн, хүний ажиллах чадварыг тал бүрээр хөгжүүлж, шинэ бололцоог нэмэгдүүлж иржээ. Харин компьютерийг зохион бүтээснээр хүн төрөлхтний түүхэнд анх удаагаа оюуны хөдөлмөрийг хөнгөвчлөх, тооцоолох, сэтгэн бодох авьяас чадварыг хөгжүүлэх бололцоог олгосон байна. Манай эриний 60-аад оны дунд үеэс хатуу биеийн физикт технологийн хувьсал гарч, микроэлектроникийн салбар шинжлэх ухаан биеэ даан эрчимтэй хөгжсөний үр дүнд 1971 онд мэдээлэл боловсруулах чадвартай “микропроцессор” гэдэг бичил элементийг бүтээснээр тооцоолох техникийн хөгжилд хүчтэй түлхэц өгсөн байна. Одоогоос 150 гаруй жилийн өмнө Английн математикч Чарльз Беббидж (1792-1871) анх удаа арифметикийн дөрвөн үйлдэл гүйцэтгэх чадвар бүхий тоо бодох машины төслийг зохиосон байна.

ТЭМ машин буюу компьютер нь 4 үе шатыг өнгөрөөсөн гэж үздэг.

1.1940-1950 оны үе. Энэ үеийн компьютерүүдэд электрон ламп хэрэглэж байв.

2.1950-1960 оны үе. Транзистор, хагас дамжуулагчийг ашиглаж байсан.

3.1960-1970 оны үе. Физикт электроник орж ирснээр том биш микросхемийг хэрэглэж эхэлсэн.


4.1970 оноос хойш. Нарийн бүтэцтэй микросхемийг хэрэглэж байна. Компьютерийн хөгжлийн түүхэнд нэрээ үлдээсэн бүхий л тоног төхөөрөмж, хэрэгслүүдээр компьютерийн музей байгуулсан байдаг.

3. СУДАЛГААНЫ ХЭСЭГ


- Хүмүүсээс авсан судалгаа, үр дүнд хийсэн боловсруулалт
 - Энэхүү судалгаанд цахим орчинд идэвхтэй байдаг 50 хүн хамрагдсан болно.
- Судалгаагаа 7 асуулгаар авсан.

Доорх судалгааны үр дүнг үзвэл:


Social орчинд та ямар нэгэн байдлаар дарамтанд өртөж байсан уу?



Social орчинд та ямар төрлийн дарамтанд өртдөг вэ?



Social орчин таньд эерэгээр хэрхэн нөлөөлж байна вэ?




Та social орчинд өдөрт хэдэн цагийг зарцуулдаг вэ?




Social орчинд та өөрийн байр сууриа эзэлж чаддаг уу?



Social орчин таньд сөрөгөөр хэрхэн нөлөөлж байна вэ?



Та дэлхийн улс орны талаарх мэдээлэл хангалттай авч чаддаг уу?



Дүгнэлт

Интернэт хэрэглээ гадаадын социологийн компаниудаас гаргасан мэдээгээр өдгөө интернэтэд 7-14 насны 6-8 сая хэрэглэгч байдаг ба тэдний 25 хувь нь сургуулийн өмнөх насны хүүхдүүд байдаг, хүүдүүдэд эхний ямар ч хараа хяналтгүйгээр интернетээр хэсүүчилдэг. Интернетээр хүссэн вебээрээ зугаалан, удаан хугацаагаар ашиглах зэрэг хязгааргүй эрх чөлөө өсөж яваа бидний сэтгэхгүй, хүмүүжил, төлөвшилд тодорхой хэмжээгээр сөргөөр нөлөөлдөг байна. Бидэнд аюулгүй, боловсрол таны мэдэхүйн, сонорхолтой, иймэрхүү интернэт хамтын орчин хэрэгтэй байна. Гадаадын орнуудад хүүхэд залууст зориулсан төрөл бүрийн сүлжээ буюу веб орчин олон байдаг. Харин бидэнд зориулж, бидний интернэт дэх аюулгүй байдлыг бүрэн хангасан, нийгмийн амьдралд дасан зохицох боломжийг олгосон зөвхөн бидний эрх ашигт нийцсэн иймэрхүү орчинийг үүсгэж болохгүй байгаа. Дэлхийн ертөнц улам бүр даяарчлагдаж, мэдээллийн технологи хурдастай хөгжиж, та бидний өдөр тутмын амьдралын хэв маягийг ихээр өөрчлөх болсон өнөө үед хамгийн хурцаар тавигдаж байгаа асуудал нь хүний хөгжил болоод түүнийг илэртийлэх мэдээллийн технологийн асуудал юм. Хүүхэд залуус бидэнд зөв хүн болж төлөвших, нийгэмд зөв амьдрахын тулд бидэнд зориулсан мэдээлэл хүртээмжтэй байж, бидний нийгэм дэх мэдээллийн хэрэглээ зөв байх ёстой. Энэ бүхэнтэй мэдээллийн технологийн хэрэглээ, ашиглалтын асуудал холбоотой.

Бид мэдээллийн хүртээмж, мэдээллийн технологийн хэрэглээний асуудалд анхааран ажиллах, ашиглах зайлшгүй шаардлагатай болснийг анзаарсан байх. Миний бичсэн эссе та бүхэнд таалагдаж, яг өнөөдрийн мэдээллийн технологийн байдалтай санал нийлж байгаа гэдэгт итгэлтэй байна.

Ном зүй:

- WWW.SLADESHARE.NET
- WWW.PREZY.COM
- WWW.CAAK.COM
- WWW.GOGO.COM
- WWW.NEWS.COM

[illegible]

ИЛТГЭГЧ: ҮЗТ 1А АНГИЙН СУРАЛЦАГЧ Б.МӨНХЗУЛ

АГУУЛГА

Удиртгал

НЭГ: Онолын хэсэг

- 1.1 Манлайлал түүний ойлголт
- 1.2 Манлайлалын түвшин
- 1.3 Манлайлагчийн хэлбэр
- 1.4 Манлайлагчийн эрх мэдэл

ХОЁР: Судалгааны хэсэг

- 2.1 Судалгааны зорилго
- 2.2 Судалгааны асуулга
- 2.3 Судалгааны үр дүн

ГУРАВ: Дүгнэлт

ДӨРӨВ: Ном зүй



НЭГ: ОНОЛЫН ХЭСЭГ

1.1 Манлайлал түүний ойлголт

Манлайлал гэдэг нь тэдгээр тодорхойлоход маш хэцүү үзэл баримтлалуудын нэг юм. 40 гаруй жилийн өмнө “үзэл баримтлалыг тодорхойлохыг оролдсон олон хүмүүс байдаг тул манлайллын олон янзын тодорхойлолт байдаг” гэж Стогдил (Stogdill — 1974) баталсан. Беннис (Bennis) өнгөрсөн зууны төгсгөлд багадаа 650 манлайллын тодорхойлолт ном зохиолд байгааг гаргаж ирсэн (Bennis and Townsend 1995). Энэ тоо нэмэгдсээр байгаа бөгөөд Кэллэрмэн (Kellerman) Вокмэнн (Volkman) -тэй ярилцлага дээрээ хэлэхдээ: “Би манлайлагч болон манлайлал гэсэн үгнүүд ойролцоогоор 1400 өөр тодорхойлолттой байдаг гэж сонссон” гэжээ. Эдгээр тоонууд бодит эсвэл хэтрүүлсэн, энгийн үгээр бол энд манлайлал гэж юу вэ гэсэн нэг санаа байхгүй ба түүнчлэн илүү сайн тодорхойлолтыг хайж байдаг.

Гэхдээ манлайлал нь бусад нөлөөлөх чадвар, хүн бүрт байгууллага, бүлгийн өмнө тавигдсан зорилго зорилтыг хэрэгжүүлэх хүсэл тэмүүлэл төрүүлэх урлаг мөн хаашаа явах чигийг заагч луужин юм гэж ихэнх ном сэтгүүл, илтгэлд тодорхойлсон байна.

1.2 Манлайлалын түвшин

Эхний түвшин бол албан тушаалд тулгуурласан: Манлайлал бөгөөд бүх удирдагчид энэ түвшингээс эхэлдэг. Албан тушаалд тулгуурласан удирдагч нь бусад нөлөөлөх хүч гэхээр зүйл байхгүй тул ажлаа явуулахын тулд албан тушаалын эрх мэдлээ ашигладаг. Дээд түвшинд үргэлж ганцаардмал байдаг гэдэг үг энэ түвшний захиралд илүү тохирно. Дээрх шинжийг агуулсан захирлыг удирдагч хэмээн нэрлэхэд ч хүндрэлтэй. Ийм захирлын хажууд хүмүүс хүчин чармайлтаа бүрэн гаргаж ажилладаггүй бөгөөд тэр бүр удаан хугацаанд тогтож ч ажилладаггүй. Энэ байдлаас гарах арга бол дараачийн шатанд дэвших явдал юм. Байгууллагын зүгээс таньд итгэж албан тушаалд дэвшүүлсэн бол та дараачийн шаталд шилжих тал даар илүү хичээж ажиллах нь зүйтэй.

Хоёрдугаар түвшинд Харилцаанд тулгуурласан удирдагчид харъяалагддаг. Хүнтэй ажиллахад харилцаа хамгийн чухал болохыг энэ шатлалын удирдагчид сайн мэддэг. Багийн гишүүд буюу ажилчид нь удирдагчаа хувь хүнийнх нь хувьд хүндэлж түүний алсын харааг хүндэлж хамтран ажиллахад бэлэн байдаг. Энэ шатлалын бас нэг онцлог нь харилцаанд тулгуурласан удирдагч болоход та заавал албан тушаалтай байх албагүй. Ажилчид, удирдлагын хоорондын сайн харилцаа нь эерэг тааламжтай харилцааг үүсгэх ба удирдагчийн зүгээс ажиллагсдаа хувь хүн талаас нь анхаарч байгаагаа мэдрүүлэх нь чухал юм. Түүнчлэн боломжтой үед нь ажилтныг санаачлага гарган хүчтэй талаа харуулан ажиллах үед сайшаан урмын үгийг харамгүй хэлж сурах хэрэгтэй. Харилцаанд тулгуурласан удирдагч нь эхний шатлалтай харьцуулахад олон давуу талтай ч ажлын таатай орчин бүрдүүлснээр л амжилтанд хүрч гайхалтай үр дүн үзүүлнэ гэж байхгүй. Амжилтад хүрэхийн тулд Захирал нь сайн гүйцэтгэлтэй манлайлагч буюу гурав дахь түвшний удирдагч болон дэвших нь зүйтэй:

Энэ түвшинд удирдагч нь багаа удирдан амжилттай ажиллаж илүү үр дүн, гүйцэтгэл гаргадаг.

Өмнөх түвшнээс ялгагдах гол ялгаа бол удирдагч нь ажилчдынхаа хувь хүний хэрэгцээ шаардлагад санаа тавьсны дараа тэднээс илүү үр дүн гаргахыг шаарддаг оршино. Зарим тохиолдолд ажилтан ажил дээрээ сайн үр дүн гаргаж байгаа хэдий ч хувь хүний хэрэгцээ шаардлага нь хангагдаагүй нөхцөлд ажилдаа сэтгэл ханамжгүй болох, ажлаасаа гарах гэх мэт асуудлууд гардаг. Энэ түвшний удирдагчид нь алсын хараагаа тодорхойлж түүнд хүрэхийн тулд бусад ойлгуулж бас нөлөөлж чаддаг. Сайн гүйцэтгэлтэй ажиллаж, өндөр үр дүн үзүүлэхийн тулд Удирдагч нь цаг төлөвлөлт, цагийн менежмент сайтай байгаад зогсохгүй хийх ажлаа чухлаар нь эрэмбэлж чаддаг байх нь зүйтэй. Та өдрийн турш идэвхтэй ажиллах цагаа хуваарилахдаа дараахь зарчмыг баримталвал илүү үр дүн үзүүлж чадна гэдгийг судлаачид тогтоожээ.

- Та өөрийн давууталыг ашигласан ажилд нийт цагийн 70%-ийг зориулах
- Нийт цагийн 20% нь мэдлэг, чадвараа сайжруулахад

- Нийт цагийн 5%-ийг өөрийн хүчтэй талаас гадуурх ажлуудыг хийх.
- Сул талаа засахад 5% тус тус зарцуулах

Гүйцэтгэл, үр дүнг эрхэмлэдэг удирдагчдын хувьд хамт ажиллагсад нь түүнийг хүндлэн хайрлаж байгууллагынхаа алсын хараанд хүрэхийн тулд өөрсдийн мэдлэг ур чадварыг бүрэн дайчилж сэтгэл гарган ажилладаг. Нөгөөтэйгүүр удирдагч ч бүтээмжтэй, сэтгэлтэй багийн гишүүдийн тусламжтайгаар байгууллагаа амжилтанд хүргэдэг. Энэ төрлийн удирдагч олон сайн талуудтай ч байгууллагын амжилт үр дүн түүнээс шууд хамааралтай болдог тул удирдагч ажлаас гарах, удаан хугацааны чөлөө авахад бизнесийн үйл ажиллагаа доголдох аюултай. Энэ асуудлыг шийдэхийн тулд Гүйцэтгэл сайтай удирдагч маань дараагийн дөрөв дэх түвшин буюу Бусдыг хөгжүүлэх шатлал руу дэвшин орох боломжтой.

Бусдыг хөгжүүлэхийн тулд сургалт болон хувь хүний хөгжилд нь анхаарахаас гадна удирдагч хүн өөрийн ажил үүргийн хүрээнд хариуцлагатай үүрэг даалгаврыг хуваарилан гүйцэтгэлд нь дэмжлэг тусалцаа үзүүлэх байдлаар багийн гишүүдийг хөгжүүлэхэд хөрөнгө оруулалт хийх нь чухал. Менежментийн зөвлөхийн хувьд дөрөвдүгээр түвшний удирдагчдад ажлын цагийнхаа 50%-ийг бусдыг хөгжүүлэхэд, харин үлдсэн цагийг үндсэн ажилдаа зарцуулах нь зүйтэй хэмээн зөвлөдөг.

Дөрөв дэх түвшний удирдагчид удирдлага дор байгаа бүх хүмүүсийг лидер болгох боломжгүй тул хамгийн өндөр потенциалтай гэж үзсэн 20% дээр төвлөрч тэднийг хөгжүүлэхэд цаг энерги зарцуулах нь зүйтэй. Энэ түвшний удирдагчдын өмнө тавигддаг хамгийн том сорил бол бусдыг хөгжүүлэхэд цаг, мэдлэг, чадвараа харамгүй хуваалцах сэтгэлтэй байж, өөрийгээ үргэлж хоёрт тавьж сурах явдал байдаг.

Манлайллын оргилд хүрэх нь бараг л бүтэшгүй зүйл хэмээн санагдаж болох ч олны хайр хүндлэлийг хүлээж, өөрөөсөө өөр олон удирдагчдыг төрүүлэн тэрхүү удирдагчид нь мөн л дор бүрнээ дараагийн шатны удирдагчдыг төрүүлэн геометрийн прогрессоор үржүүлж чаддаг асар их нөлөөтэй удирдагчид цөөн тоотой ч бас байдгийг дурьдах нь зүйтэй. Бусад хүлээн зөвшөөрөгдсөн 4,5 дугаар түвшний удирдагчид олон тоотой төрж гарвал байгууллагын өсөлт хөгжилд төдийгүй улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд ихээхэн ач холбогдолтой.

Манлайллын таван түвшний талаар ойлгож мэдсэнээр одоо удирдах ажил хийж буй захирлууд эдгээр түвшний алинд нь харъяалагдаж байгаагаа тодорхойлоод зогсохгүй дараагийн түвшинд дэвшихэд чухам ямар ур чадвараа дээшлүүлж юу хийх талаар зорилгоо тодорхойлох боломжтой болно. Ийнхүү чадварлаг удирдагчдыг тасралтгүй төрүүлэх нь байгууллагын өсөлтийг хангах хамгийн үр дүнтэй арга зам болохыг дэлхийд болон үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагууд төдийгүй улс орны туршлага харуулж байна.



1.3 Манлайлагчийн хэлбэр

The автократ удирдлага: Энэ нь хянагч нарт бүлгийн оролцоогүйгээр шийдвэр гаргах, удирдамж гаргах боломжийг олгодог. Өөрөөр хэлбэл, энэ төрлийн манлайлалд эрх мэдэл нь шууд тушаал өгдөг бөгөөд ямар ч тохиолдолд заавал дагаж мөрдөх үүрэгтэйгээр илэрхийлэгддэг зүйл юм. Удирдагч анхаарлаа төвлөрүүлдэг бүх хүч чадал, хэн ч таны шийдвэрийг сорихгүй. Энэ бол нэг чиглэлтэй манлайллын дасгал бөгөөд захирагдагсдын хийх ёстой зүйл бол удирдагчийн өгсөн удирдамжийг дагах явдал юм.

Хамт олны дэмжлэг: Манлайлал нь гүйлгээнд суурилсан, өөрөөр хэлбэл удирдагчид болон тэдний дагалдагчдын хоорондох солилцооны үйл явц. Дагагчид даалгавраа биелүүлж чаддаг тул ажлын үр дүнгийн шагнал, удирдагч нь давуу талтай байдаг.

Бололцоо олгон удирдлах: Манлайлал, мөн дараахь байдлаар мэддэг төлөөлөгчийн манлайлал Энэ бол хөндлөнгөөс оролцохгүй байх хэв маяг, байнгын санал хүсэлт дутагдалтай байдаг. Энэ нэр нь франц хэлээр “өнгөрөх болтугай” эсвэл “энэ байг” гэсэн үг юм. Laissez-faire удирдагч шаардлагатай үед л оролцдог мөн хамгийн бага хяналт бүхий. Энэ бол өндөр туршлагатай, бэлтгэгдсэн, хүсэл эрмэлзэлтэй ажилчдад үр бүтээлтэй ажиллахын тулд бага хяналт шаарддаг гэсэн онол дээр суурилсан авторитар бус хэв маяг юм. Эдгээр ажилчид нь мэргэжлийн хүмүүс бөгөөд бие даан гүйцэтгэх чадварыг эзэмшдэг тул даалгаврыг бага зэрэг сонор сэрэмжгүй биелүүлж чаддаг.

1.4 Манлайлагчийн эрх мэдэл

- Албадлагын
- Урамшуулалын
- Экспертийн
- Үлгэрлэх
- Хууль ёсны
- Итгүүлж үнэмшүүлэх
- Оролцуулах

Манлайлагчийн чадвар

- Шийдвэр гаргах
- Мэдээлэл цуглуулах чадвар
- Ажиглалт хийх чадвар
- Тулж ажиллах чадвар
- Хэрэгжүүлэх чадвар
- Зорилго тодорхойлох чадвар
- Заах болон ойлгуулах чадвар
- Магтах болон зэмлэх чадвар
- Философич
- Шударга байх чадвар





ХОЁР: СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Судалгаа

- Хүйс?
 - Эрэгтэй
 - Эмэгтэй/20% эрэгтэй 80% нь эмэгтэй судалгаанд хамрагдсан ./
- Та аль салбарыг сонирхдог вэ?
 - Урлаг,соёл 18
 - Спорт 18
 - Мэргэжил 19
 - Харилцааны ур чадвар 14/Урлаг,соёл 10% спорт 20% мэргэжил 40% харилцаа30% тус тусын салбарыг сонирхдог гэсэн судалгаа гарж ирсэн./
- Манлайлал гэж юувэ?

/...90% бусдад нөлөөлөх чадвар өөрийгөө бүрэн ялан дийлж бусдын болон өөрийн төлөө хэнийг ч зөв зүйлд уриалан, удирдан залах ...10% нь удирдах тушаалтануудыг хэлнэ./
- Манлайлагчийн доор ажилснаар ажлын бүтээмжинд хэр нөлөөлдөг вэ?
 - Маш сайн
 - Сайн
 - Дунд/85% нь сайн гэсэн 15% нь маш сайн /
- Бусдыг удирдан чиглүүлэхэд ямар бэрхшээл саад гардаг вэ?
 - Харилцааны бэрхшээл
 - Мэдлэг дутагдал
 - Бусадтай сайн ойлголцож чаддаггүй
 - Бусад/Мэдлэг дутмагаас болж хүүхдүүд удирдан чиглүүлэхэд бэрхшээл саад маш их гарж ирдэг./
- Сайн манлайлагч байх нь таньд ямар давууталтай вэ?
 - Бусдыг санал сэтгэлийг ойлгож авах
 - Бусдад нөлөөлөх чадвар сайжирсан
 - Бусдад зорилтыг нь хэрэгжүүлэх хүсэл тэмүүлэлийг бий болгож чаддаг
 - Бусдад зааж зөвлөх

Бусдад зорилтыг нь хэрэгжүүлэх хүсэл тэмүүлэлийг бий болгож чаддаг байхад сайн манлайлагч болно гэж үздэг.

ГУРАВ: ДҮГНЭЛТ

Манлайллыг зөвхөн заяамал шинжтэй, цөөн тооны удирдагч болон албан тушаалт хүмүүст л хамаатуулж ойлгодог байсан ойлголт орчин үедээ өөрчлөгдөж бизнесийн ертөнц илүү өрсөлдөөнтэй, улам тогтворгүй болж буйтай холбогдон манлайлагчдын хэрэгцээ улам бүр өссөөр энэ нь ямар ч хүн бүсдэг зөв зүйлд үлгэрлэн манлайлж болхыг харуулж байна.

Манлайлын ур чадварт суралцах, эзэмших нь хүн бүрт нээлттэй, боломжтой бөгөөд өөрийн зорилгодоо тууштай, суралцагч, шинийг эрэлхийлэгч, зөв хандлагатай байвал жинхэнэ манлайлагч болж чадах юм.

НОМ ЗҮЙ: АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. <https://www.slideshare.net/SoyolooSdl/ss-14811691?fbclid=IwAR2oLUWstZ-MCzr5qqKN8pvsWryCHm4nlvyYDTRCXeoxT2y-ok2bYj4ersaw>
2. https://www.slideshare.net/nyamdemberel/manlailal-leadership?fbclid=IwAR0RrqsMuWJi-U8A15L_YW4CXWjkAowL6c1hFTph9sI8ErT9b8SYDW8fBskM
3. https://m.facebook.com/nt/screen/?params=%07B%022note_id%022%03A3534570513266047%07D&path=%02Fnotes%02Fnote%02F&_rdr

ТЭМДЭГЛЭЛ

[illegible]

“ҮСЧИН” МЭРГЭЖИЛ СУРАЛЦАГЧДЫН ХӨГЖИЛ ТӨЛӨВШИЛД НӨЛӨӨЛӨХ НЬ

ИЛТГЭГЧ: ҮЗТ 1А АНГИЙН СУРАЛЦАГЧ Б.БАТЗАЯА
УДИРДСАН БАГШ: АУД Д.НАРАНТУЯА

МЭРГЭЖИЛ БҮХЭН САЙХАН

Мэргэжил бүхэн өөрийн өнгө төрх, таашаал мэдрэмжтэй байдаг. Мэргэжлийн болон техник мэргэжлийн сургуулийг сонгон мэргэжил эзэмшиж байгаа оюутан суралцагч бид үнэхээр азтай хүмүүс билээ. Ялангуяа “Үсчин” мэргэжлийг сонгон суралцаж мэргэжил эзэмшиж байгаа бид хүмүүст өнгө зүс нэмж, сэтгэлийн таашаал өгдөг. Үс сайхан бол зүс сайхан гэдэг. Хүмүүс үсээ засуулснаар сэтгэл нь сэргэж, дотор хүн нь баярлахын зэрэгцээгээр, хүний ааш авир, харилцаа, ажлын бүтээмжинд хүртэл нөлөөлдөг. Ийм л учраас бид эзэмшсэн мэргэжилдээ үнэнч байх нь хамгийн чухал.

1.ОРШИЛ

Оюутан хүний гол үүрэг бол суралцах, эрхэм зорилго, үүрэг хариуцлага гэж ойлгож болно. Суралцагчийн идэвхи сонирхол, сурлагын амжилтанд нөлөөлж байгаа хүчин зүйлсэд цогц судалгаа хийх зайлшгүй шаардлагатай. Сурах үйл явцад суралцагчийн хэрэгцээ, сонирхол, нөөц боломж, идэвхи зүтгэл ихээхэн чухал зүйлс бөгөөд, сургалтын орчин нөхцөл, анги танхимын тохижилт, сургалтын материаллаг орчин, суралцагчийн санхүүгийн байдал, эцэг эхийн анхаарал, багшийн заах арга барил, туршлага харилцааны эв дүй, үе тэнгийн суралцагчдын нөлөөлөх нөлөөлөл их чухал байдаг. Суралцагчид амжилттай эсвэл амжилтгүй суралцахад дээр дурьдсан олон хүчин зүйл эерэг болон сөрөг хүчин нөлөө үзүүлж байдаг байна.

Зорилго:

Үсчиний мэргэжил, үсчин болохоор суралцаж буй суралцагч, мэргэжлийн зэрэг ахиулж буй оюутан, суралцагчдад нөлөөлөх хүчин зүйлсийг илрүүлж үнэлэлт, дүгнэлт өгөх

Зорилт:

- Судалгааны материалыг боловсруулах
- Асуулга судалгаа авах
- Асуулга судалгааны үр дүнд тулгуурлан судалгааны ажлаа бичих

Судалгааны объект:

“Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл Урлалын политехник коллеж”

Судалгааны ач холбогдол:

Энэхүү судалгааг хийснээр тухайн мэргэжлээр ажиллаж сурч байгаа хүмүүсийн төлөвшил хувь хүний үзэл баримтлалд хэрхэн нөлөөж, ур чадвараа дээшлүүлж, эерэг хандлагыг хэрхэн түгээж байгаа нь судалгааны ач холбогдол юм.

2.СЭДВИЙН СУДАЛГДСАН БАЙДАЛ:

Суралцагсдын голлох үйл ажиллагаа бол мэргэжлийн мэдлэг, ур чадвар, дадалыг эзэмшихэд чиглэсэн сурах үйл ажиллагаа юм. Амжилттай суралцахын тулд суралцагч нь өөрийн эзэмшиж буй мэргэжлийн чиглэлдээ дур сонирхолтой байгаад зогсохгүй, биеэ даан сурах арга барилыг сайтар эзэмшсэн байх. Үүнээс гадна тэдний сурлагын амжилтанд сургуулийн захиргааны сургалтын бодлого, сургалтын материаллаг орчин нөхцөл, багш оюутаны харилцаа, үнэлгээ, хичээлийн зохион байгуулалт заах арга зүй, ангийн нэгдэл нягтрал, уур амьсгал, сургалтын төлбөр болон хөнгөлөлт, урамшуулал зэрэг олон хүчин зүйлс нөлөөлдөг. Мөн ажиллах орчин, хамт олон, хамт олны уур амьсгал итгэлцэл нь хувь хүний өсөн дэвших үйл явц ур чадвар, зөв дадалыг эзэмшихэд нөлөөлж байдаг байна.


3. СУРАХ АРГА БАРИЛ

Суралцагч хүн бүр суралцах хэв маягаараа ялгаатай байдаг. Өөр хоорондоо суралцах хэв маягууд бидний сургалтанд нөлөөлдөг байна. Зарим оюутнуудын хувьд мэдээллийг сонсож сургалтыг амжилттай явуулдаг бол нөгөө хэсэг нь мэдээллийг нүдээрээ харж хүртэх хандлагатай байдаг. Суралцах хэв маяг нь 8 төрөлд хуваагдана. Үүнд:


1. А. Экстраверт буюу гадагшаа чиглэсэн
2. Б. Экстраверси
3. В. Интроверт
4. Г. Интуитив
5. Д. Бодол санаанд тулгуурласан
6. Е. Мэдрэмжинд тулгуурласан
7. Ё. Шүүмжлэлт сэргэхүйн
8. Ж. Хүртэхүйн гэж хуваагддаг байна.

4. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Судалгаа явуулах нь их хэмжээний мэдээллийг богино хугацаанд олж авах, дотоод үзэл бодлыг илрүүлэн гаргах сайн талтай боловч судалгааг зөв боловсруулаагүйгээс алдаа гарах сул талтай. Эмпирик судалгаа нь ажиглалт, туршилт болон өгөгдөл дээр суурилна. Гарсан үр дүнг шинжилж харьцуулна. Судалгааг Google Form application ашиглан онлайнаар авсан. Судалгаанд Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэр урлалын коллежийн ҮЗТ 1а ангийн оюутнууд, Баянхонгор аймаг РТК-ийн үсчин мэргэжилээр сурч буй суралцагчид, мөн уг мэргэжилээр ажиллаж байгаа 5-20 жилийн туршлагатай Улсын, нийслэл, бүсийн тэмцээнүүдэд оролцож байсан үсчидээс судалгааг авсан болно. Уг судалгаа нь нийт 5 асуулттай. Асуулга нь тухайн мэргэжлийг эзэмшиснээр хэрхэн төлөвших, манлайлах, ур чадвар, сурлага, бие хүний амжилтанд нөлөөлдөг хүчин зүйлсийг нээн илрүүлэх зорилгоор зохиогдсон юм. Ингээд сурлагын амжилтанд нөлөөлдөг хүчин зүйлсийг оюутнууд хэрхэн тодорхойлсон байдлыг авч үзье.



1-р зураг Хүйсийн харьцаа



2-р зураг. Сургууль курс дамжаа төгссөн байдал




3-р зураг. Сурлагын амжилтад багш нарын харилцаа заах арга барил ур чадварын нөлөөлөл. Суралцагсдын 89% нь сэтгэл хангалуун байдаг гэсэн хариултыг өгжээ.



4-р зураг Мэргэжлийн зэрэг

- 6р түвшин буюу мастерууд энэхүү судалгаанд оролцоогүй байна. Нийт 2%-ыг эзэлжээ.
- 1-р зэрэг буюу 5р түвшиний үсчид 7%
 - 2-р зэрэг буюу 4р түвшиний үсчид 28.6%
 - 3-р зэрэг буюу 3р түвшиний үсчид 14.4%
 - 1-2р түвшин буюу дадлагжигч 48% оролцсон байна.



5-р зураг. Таны амжилтанд хамт олны хүчин зүйлс нөлөөлдөг эсэх гэсэн асуултанд 100% тийм гэсэн хариулт өгжээ.

5. Судалгааны дүгнэлт

Үсчиний мэргэжил нь суралцагчдын хөгжил төлөвшилд нөлөөлөх нь оюутан ба бие хүний сурах хэрэгцээ, сурах үйл ажиллагааны үнэлгээ, үр дүн нийгэмд эзлэх байх суурийг тодорхойлж байдаг чухал үзүүлэлт юм. Энэхүү үзүүлэлт хэр өндөр байх нь оюутны сэтгэл ханамж, өөрийгөө ухамсарлахад нөлөөлдөг байна.

Хамгийн ихээр нөлөөлөх хүчин зүйлсүүд нь оюутнаас өөрөөс нь шалтгаалах зүйлс буюу өөрийн сурах арга барил, судалгаа шинжилгээний арга зүйг эзэмшсэн байдал, өөрийгөө илэрхийлэх байдал, оюун ухааны задлан нэгтгэн дүгнэх, харьцуулах чадвар, ном мэдээллийн эх сурвалжийг хайх, олох, унших бичих чадвар, цаг ашиглалт, цагийн менежмент, ажлын зохион байгуулалт, өөрийн идэвхи чармайлт, хэрэгцээ сонирхол, ой тогтоолт анхаарал төвлөрөлт, бөгөөд үүний дараагаар оюутны хамт олны нэгдэл нягтрал, уур амьгал, харьцаа, эцэг эхийн анхаарал, найз нөхөд хамтран суралцагчийн дэмжлэг, багшийн харилцаа, заах арга ур чадвар, үнэлгээний бодитой уян хатан шударга байдал, сургалтын анги танхимийн хүрэлцээ, тав тух, интернэт wifi хэрэглээ, номын сангийн үйлчилгээ, номын хангамж хүртээмж зэрэг сургалтын материаллаг орчин, сургуулийн захиргаа сургалтын бодлого, оюутныг урамшуулах бодлого зэрэг хүчин зүйлс нөлөөлдөг байна.

Энэхүү судалгааг цар тахал хөл хорионы үед онлайнаар суралцаж байгаа сурагчдаас авсан учраас оюутны сэтгэл ханамжийн байдлаас харахад wifi хэрэглэх боломж, хурд, номын сангийн үйлчилгээ, оюутнуудын мэдлэгийн чанар, түвшингийн ялгаатай байдал, хамт олны нэгдэл, уур амьсгал, нягтрал, багшийн заах арга зүйд сэтгэл ханамжгүй байгааг харуулжээ.

“ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ 21-Р ЗУУН ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛ”

ИЛТГЭЛ БИЧСЭН: ТЧ 2А АНГИЙН СУРАЛЦАГЧ А. БАЯРМАГНАЙ

Агуулга

1. Хураангуй
2. Түлхүүр үг
3. Үндэслэл
4. Үндсэн хэсэг
5. Дүгнэлт хавсралт
6. Ашигласан материал

ХУРААНГУЙ

21-р зуун дахь техник, технологийн хөгжил, цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан уламжлалт сургалтын системийг шинэчлэн сайжруулах. Тогтвортой хөгжлийн “Чанартай боловсролыг дэмжих” зорилгын дагуу, мэдээлэл харилцаа холбооны технологид суурилсан цахим сургалтыг чанаржуулах, цахим сургуулийн системийг бий болгох.

ТҮЛХҮҮР ҮГС

Уламжлалт сургалт, суралцах арга барилын шинэчлэл, цахим сургалт, цахим сургуулийн систем.

ЗОРИЛГО

Орон зай, байршил, цаг хугацаанаас үл хамаарах сургалтын системийг бий болгох, цахим сургалтыг сайжруулах. Багш, сурагч, эцэг эхийн гурвалсан харилцааг бий болгох, сургалтын үйл ажиллагааны талаарх санал хүсэлтийг хүлээн авах харилцаа холбооны хялбар системийг хэрэглээнд нэвтрүүлэх. Сургуулийн нэгдсэн мэдээллийн сантай болох.

ЗОРИЛТ

- Суралцагчдын суралцах үйл явц, багш, эцэг эх, сурагчийн харилцаанд тулгарч буй бэрхшээлийг тодорхойлох
- Цахим сургалтын давуу тал, сул талыг тодорхойлж, вэбэд суурилсан сургалтыг боловсролын чанарыг сайжруулах дэвшил болгон ашиглах
- Цахим сургалтын платформоор дамжуулан суралцагчдыг олон талаар хөгжүүлэх, багшийн ур чадварыг дээшлүүлэх

СЭДЭВ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ

- Сургуулийн нэгдсэн мэдээллийн системийг илүү боловсронгуй болгож, багш суралцагч, эцэг эх хоорондын холбоо, мэдлэг туршлага солилцох боломжийг бий болгох.
- Багшийн хичээл, сургалтын материалыг архивлаж, багшийн ажлын хэт ачааллыг бууруулах
- Суралцагчдад өөрт тохирсон арга барилыг эзэмшин, үр дүнтэйгээр хаанаас ч, ямар ч нөхцөлд чанартай боловсрол эзэмших боломжийг олгох.

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТУХАЙ ҮНДСЭН ОЙЛГОЛТ

“Тогтвортой хөгжил гэдэг нь байгаль нийгмийн аль ч түвшний, ямар ч төвөгтэй системийн хөгжлийг хангахдаа түүний аюулгүй байдлыг хадгалж, өнөөгийн болон хойч үеийнхээ “амьдралын чанар”-ыг хэвийн түвшинд байлгах үйл явцыг хэлнэ” гэжээ.

Тогтвортой хөгжил (Sustainable Development)

Ирээдүй хойч үе хэрэгцээгээ хангах чадварыг бууруулахгүйгээр дэлхийн өнөөгийн хүн ам хэрэгцээгээ хангах хөгжил. Заримдаа тогтвортой хөгжлийн тухай ойлголтыг зөвхөн байгаль орчныг хамгаалахад чиглэгдсэн ойлголт гэж үздэг нь ихээхэн учир дутагдалтай. Нийгмийн бүх гишүүд өөрийн нийгмийг хөгжүүлэхэд тэгш оролцож, түүнийхээ үр шимийг хүртэж сайхан амьдрах ёстой, эрүүл орчинд аж төрөх ёстой, эрүүл, боловсролтой байх ёстой, энэ бол тогтвортой хөгжлийн нийгмийн хүрээний үндсэн зорилт болох юм.

Тогтвортой хөгжлийн зорилго гэж юу вэ?

“Тогтвортой хөгжил -2030 хөтөлбөр”-ийг анх 2012 онд Рио Де Жанейро хотод улс орнуудын төрийн тэргүүнүүд оролцсон НҮБ-ын “Тогтвортой хөгжил” бага хурлын үеэр санаачилсан.

Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ) нь 2015 онд хэрэгжилтийн хугацаа нь дуусгавар болж буй “Мянганы хөгжлийн зорилтууд”-ын үргэлжлэл юм.

2015 онд НҮБ-ын Ерөнхий Асамблейн 70 дугаар чуулган болж, ТХЗ-ын 17 зорилго, 169 зорилтыг баталж, 2016 оны 1 сарын 1-нээс “Тогтвортой хөгжлийн зорилго” (ТХЗ) албан ёсоор дэлхий нийтээр хэрэгжиж эхэлсэн.

“Тогтвортой хөгжлийн зорилт-2030” нь #нийгэм, #эдийн засаг, #байгаль орчин гэсэн гурван тулгуурт суурилан тогтвортой хөгжилд хүрэх дэлхийн нийтийн урт хугацааны бодлогын баримт бичиг юм.

Тогтвортой хөгжлийн 17 зорилго:

1. Ядуурлыг устгах
2. Өлсгөлөнг зогсоох
3. Эрүүл мэндийг дэмжих
4. ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ
5. Жендерийн эрх тэгш байдлыг хангах
6. Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах
7. Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх
8. Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтийг дэмжих
9. Инноваци болон дэд бүтцийг хөгжүүлэх
10. Тэгш бус байдлыг бууруулах
11. Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих
12. Хариуцлагатай хэрэглээг дэмжих
13. Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах
14. Далай тэнгисийн нөөцийг хамгаалах
15. Хуурай газрын эко системийг хамгаалах
16. Энх тайван шударга ёсыг цогцлоох
17. Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх

4. ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ: “21-Р ЗУУНЫ СУРАЛЦАХ

“ШИНЭ АРГА БАРИЛ”

Хүний нийгмийн хөгжил, технологийн дэвшилтэй уялдан мэдээллийн хэмжээ асар их болж тэр хэрээр сургалтын процесс шинэчлэгдэн шинэ зуунтай золгосон 20-р зууны дунд үед уламжлалт сургалт буюу нүүр нүүрээ харсан сургалт зонхилж байсан бол орчин үед электрон сургалт, хосолсон сургалт илүү өргөн хүрээнд ашиглагдаж байна. Мэдээлэл харилцааны технологи, электрон сургалт, интернэт болон вэбэд суурилсан цахим сургалт нь 21-р зуунд суралцах шинэ араг барил болж байна.

Чанартай боловсролыг дэмжих зорилгын ахиц дэвшил:

Төрөөс авч хэрэгжүүлж буй боловсролын талаар баримтлах бодлого нэмэгдсэн ба хүүхэд хамгааллын тусгай бодлоготой болсон нь ахиц юм. Түүнчлэн 15 болон түүнээс дээш насны нийт хүн амын 98% нь бичиг үсэг тайлагдсан, хамран сургалт сайжирч 98.6-100%-тай болсон, тогтвортой хөгжлийн боловсролын агуулгыг бүх шатны боловсролын хөтөлбөрт тус тус тусгасан нь боловсролын салбарт гарч буй дэвшил юм.

Чанартай боловсролыг дэмжих зорилгод тулгарч буй сорилт, бэрхшээл:

Боловсролын тогтолцоо, чанар, тоног төхөөрөмжийн чанарын шаардлага хангахгүй, сургалтын агуулга, хөтөлбөр ойр ойрхон өөрчлөгддөг /16 жилд гурван удаа шинэчлэгдсэн/, сургалтын материал, сурах бичиг хангалтгүй байгаа нь сорилт байсаар байна. Мөн тэгш хамруулан сургах боловсролын тогтолцоо алдагдсан, гурван ээлжээр хичээллэж буй сургууль 28, дээд боловсролтой ажилгүй залуучууд олон хэвээр буй нь чанартай боловсролыг дэмжихэд тулгарч буй бэрхшээлд багтаж байна.

Цаг үеийн нөхцөл байдал болон, хөгжингүй орны цахим сургалтын цар хүрээ:

2020 онд, зөвхөн АНУ-д гэхэд цахим сургалтын худалдаа 37.6 тэрбум доллар байхаар тооцоолсон байна. Covid-19 вирусийн тархалтаас шалтгаалан энэ тоо өсөх ч магадлалтай. Олон улсын онлайн сургалтын платформд богино хугацааны болон мастер докторын гэх мэт эрдмийн зэрэг олгох боломжтой 69 улсын 15,957 зайн сургалтын хөтөлбөр бүртгэлтэй байна. Зөвхөн АНУ-д, 2017 онд 6,651,536 оюутан дор хаяж нэг онлайн сургалтад хамрагдсан байна

Цахим сургалтын давуу тал:

- Орон зайнаас үл хамааран хаанаас ч холбогдох
- Ихэнх хичээлүүдийг өөрийн боломжтой цагтаа, шөнө ч үзэж судлах
- Нэг удаагийн лекцтэй харьцуулахад олон дахин давтаж үзэх боломжтой
- Удаан ойлгож, удаан мартдаг (slow learners) суралцагсдад хичээлээ ойлгох илүү боломжит хугацааг олгодог бол хурдтай суралцагч нарт танхимын сургалттай харьцуулахад ижил хугацаанд улам их мэдлэг авах боломж
- Сэдвийн хүрээн дэх өргөн хэмжээний мэдээллээс өөрт чухлыг нь сонгож, цагаа оновчтой зарцуулахад суралцана
- Суралцах зүйлээ суралцагч өөрөө удирдана.
- Эдийн засагт хэмнэлттэй

Цахим сургалтын сул тал:

- Интернэтийн хурд, технологийн дутмаг байдал;
- Багшаас тэр даруй асуулт асууж, харилцан ярилцах боломж хязгаарлагдмал;
- Электрон номын сан, эрдэм шинжилгээний бүтээл, видео танилцуулга гэх мэт тухайн улсын хэл дээрх цахим эх сурвалж, сургалтын материал хангалтгүй байх;

- Багаар, хамтран ажиллах боломж хязгаарлагдмал;
- Лаборатори, дадлага, дасгалын аргаар үзэх хичээлүүдийг цахимаар авах боломж тун бага.
- Хөгжим, бүжиг, биеийн тамирын хичээлүүдийг онлайнаар үзэхэд үр дүн муутай;
- Шавилан сурах, менторшипийн харилцаа үүсэх боломж хязгаарлагдмал;
- Амьд харилцаа үүсэхгүйгээс шалтгаалан багшийн оюутныг мэдрэх, түүнд нийцүүлэн “сургах” арга зүй хязгаарлагддаг.

ЦАХИМ СУРГАЛТЫН ХҮРЭЭНД ТУЛГАРЧ БҮЙ АСУУДЛЫГ ЦАХИМ СУРГУУЛИЙН СИСТЕМИЙГ НЭВТРҮҮЛСНЭЭР ШИЙДВЭРЛЭХ НЬ:

Цахим сургуулийн систем гэж юу вэ?

Цахим сургуулийн систем нь сургуулийн үйл ажиллагаа, сургалтын үйл явц, статистик тоо баримтыг нэгтгэн боловсруулж, багш-суралцагч-эцэг эхийн гурвалсан харилцаан дээр тулгуурлан байнгын холбоотой байх, мэдээлэл санал хүсэлт солилцох, асуудлыг хамтран шийдэх, цахим сургалтын чанарыг сайжруулах зорилготой систем юм.

Цахим сургуулийн системийн үр дүн, давуу тал:

СУРАЛЦАГЧДАД:

- Хичээлийн хуваарь, дүнгийн мэдээлэл, өөрийн сурагчдын амжилт болон дүнг харьцуулан дүн шинжилгээ хийх
- Суралцагчид хоорондоо хичээлийн болон сонирхдог зүйлсийнхээ талаар санал бодлоо солилцож, бүлэг үүсгэн хоорондоо харилцах, хамтран суралцах үйл ажиллагааг дэмжих
- Ямар нэгэн шалтгааны улмаас хичээлд суугаагүй суралцагч тухайн өдрийн хичээлийг нөхөн судлах боломжтой
- Удирлага багш нартайгаа чөлөөтэй харилцаж, санал бодлоо илэрхийлэх
- Сургуулийн үйл ажиллагааны талаарх санал хүсэлт дэвшүүлж хувь нэмрээ оруулах

ЭЦЭГ ЭХЧҮҮДЭД:

- Хүүхдийнхээ хичээлд хоцорсон байдал, ирц, хичээлийн хуваарь, дүн, олон нийтийн арга хэмжээнд оролцсон идэвх, үйл ажиллагаатай танилцах
- Багш нарын заасан хичээлийн хөтөлбөр төлөвлөгөөтэй хүссэн үедээ танилцах, тухайн хичээлийг багшийн заасан арга барилын дагуу хүүхдээ давуулах
- Хүүхдийнхээ сургалтад нөлөөлж буй асуудлаар багш, менежер, сургуулийн захиргаа, бусад эцэг эхтэй цахимаар солилцох

БАГШ НАРТ:

- Давтлага, зөвлөмж, суралцагчдын талаарх мэдээллийг эцэг эхчүүдэд нэгдсэн журмаар цаг алдалгүй хүргэх
- Эцэг эх болон удирдлагад өөрийн хичээлийн агуулгыг танилцуулах
- Цахим хичээл, хичээлийн хэрэглэгдэхүүнийг архивлах
- Бусад багш ажилчидтай мэдлэг туршлага солилцох

СУРГУУЛЬД:

- Сургууль, багш ажилчид, сурагч, эцэг эхийн хандалтын тайлан мэдээ, мэдээллийн нэгдсэн сантай болох
- Багш, суралцагч, эцэг эхээс сургуулийн үйл ажиллагааны талаарх санал хүсэлтийг хүлээн авч ил тод нээлттэй үйл ажиллагаа явуулах
- Багш суралцагчдыг үнэлэх шударга системийг бий болгох
- Мэдээллийг түгээх урсгалыг сайжруулах, цаасан хэлбэрийг халж зардлаа хэмнэх
- Сургуулийн дотоод үйл ажиллагаа, бизнес процессыг боловсронгуй болгох

ДҮГНЭЛТ

Цахим сургуулийн системийг манай сургуулийн сургалтын үйл ажиллагаанд нэвтрүүлсэн явдал нь цар тахлаас үүдэн цахимаар сургалт зохион байгуулагдаж буй энэ үед ихээхэн ач холбогдолтой ажил болсон юм. Энэ нэгдсэн систем нь багш нарын хувьд хичээл сургалтын материал хэрэглэгдэхүүнээ цэгцтэй байршуулах, үйл ажиллагаагаа зохион байгуулахад их ач тустай байгаа.

Суралцагчдын хувьд техник технологийн мэдлэгээ дээшлүүлэх, тогтмол цагт мэдээллийг авах, хичээл сургалтын үйл ажиллагаанд хуваарийн дагуу оролцох давууталуудих байна. Хэдийгээр сургалтын нэгдсэн системтэй болсон давуу талтай ч цаашид улам сайжруулах, үйл ажиллагааг өргөжүүлэх санал байна **Үүнд:**

1. Цахим сайтад нэвтрэх хурдыг сайжруулах
2. Суралцагчдын идэвх оролцоог нэмэгдүүлэх
3. Суралцагчдын эцэг эхтэй цахим системээр хамтран ажиллах, суралцагчдын хичээлийн оролцоо дүнг харах боломжтой байх
4. Багш нарын хичээл, гэрийн даалгаврыг тус тусад нь хавтсанд байршуулах

ТЭМДЭГЛЭЛ**“ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ ХХІ-ЗУУН****ИЛТГЭГЧ: ОБОЗБ АНГЙЙН СУРАГЧ СОДТУЯА**

Тогтвортой хөгжил гэж юу вэ?

Тогтвортой хөгжил гэдэг нь өнөө үеийн хэрэгцээг хангахдаа ирээдүй үеийнхээ хэрэгцээгээ хангах боломжийг хязгаарлахгүй байх явдал юм.

Тогтвортой хөгжил нь 5 зүйлээс бүрддэг. Үүнд:

- Хөгжил
- Хүн
- Байгаль
- Хамт олны ажиллагаа
- Энх тайван

ТХЗ нь 2016-2030 оныг хамарсан 15 жилийн хугацаанд хэрэгжихдээ дараах 5 элементийг хамруулна.

People-Хүн төрөлхтөн

- Ядууралыг устгах
- Эрүүл энх, сайн, сайхан аж байдлын төлөө

Planet- Эх дэлхий

- Цэвэр ус, ариун цэврийн байгууламж
- Хариуцлагатай хэрэглээ, үйлдвэрлэл
- Уур амьсгалын өөрчлөлт
- Далай тэнгис, гол мөрөн
- Эх газар

Prosperity-Хөгжил, цэцэглэлт

- Хүртээмжтэй, цэвэр эрчим хүч
- Зохистой хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн өсөлт
- Үйлдвэрлэлт, шинэ санаачлага, дэд бүтэц
- Тэгш бус байдлыг бууруулах
- Тогтвортой хот, суурин

Peace- Энх тайван

- Ядууралгүй
- Жендерийн эрх тэгш байдал
- Амар амгалан, хүртээмжтэй нийгэм

Partnership-ТХЗ-ын төлөөх түншлэл

Тогтвортой хөгжлийн зорилго гэдэг нь (ТХЗ) 2015 онд хэрэгжилтийн хугацаа нь дуусгавар болж буй –Мянганы хөгжлийн зорилтууд”-ын үргэлжлэл юм. 2015 онд НҮБ-ын Ерөнхий Асамблейн 70 дугаар чуулган болж, ТХЗ-ын 17 зорилго, 169 зорилтыг баталж, 2016 оны 1 сарын 1 нээс “Тогтвортой хөгжлийн зорилго” албан ёсоор дэлхий нийтээр хэрэгжиж эхэлсэн.



Байгаль орчин

2019 онд Монгол улсад төрсөн 1000 хүүхэд тус бүрийн 17 хүүхэд нь 5 нас хүрэлгүй хорвоог орхижээ. Мөн онд Өмнөд Солонгос улсад төрсөн 1000 хүүхэд тутмаас 3 хүүхэд өөд болсон бол, Афганистан улсад энэ тоо 62 байсан юм. Тэгвэл эдгээр улсуудын аль нь илүү тогтвортой хөгжилтэй вэ?

Дээрх асуултын хариу бол мэдээж Өмнөд Солонгос юм. Яагаад гэвэл 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл маш бага байна гэдэг нь, Өмнөд Солонгост иргэд нь харьцангуй эрүүл мэндийн үйлчилгээг сайн авч чаддаг, амьдрах орчин амгалан тайван, өлсгөлөн болон ядуурлын хэмжээ бага, эрүүл ахуй болон цэвэр усны хэрэглээ хангалттай хүртээмжтэй байгаа гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл, Өмнөд Солонгос улс нь бусад улсаас харьцангуй, хүн бүрэн бүтэн амьдрахад хэрэгтэй хамгийн доод хэмжээний шаардлагуудыг хангасан, найдвартай, “тогтвортой” нийгмийг бүрэлдүүлсэн байна гэж хэлж болно. Гэвч үнэхээр харамсалтай нь дэлхий дээрх нийтулс орнуудаас ердөө тоотой хэд нь л Өмнөд Солонгос шиг нийгмийг цогцлоож чадсан юм. Иймээс 2015 онд, энэхүү улс хоорондын амьдралын чанарын хэт зөрүүтэй байдлыг арилгахын тулд, олон улсын хамтын хүчний туслалцаатайгаар дэлхий даяар тогтвортой хөгжлийг хурдасгахын тулд, НҮБ-аас “Тогтвортой Хөгжил – 2030 Хөтөлбөр”-ийг зарласан билээ. НҮБ-аас хүн төрөлхтөн тогтвортой хөгжилд хүрэхийн тулд биелүүлэх шаардлагатай 17 зорилгуудыг тодорхойлж, түүнийгээ “Тогтвортой хөгжлийн зорилтууд” (Зураг 1.) хэмээн нэрлэсэн юм.



Зураг 1. Тогтвортой хөгжлийн 17 зорилгууд

НҮБ-аас тогтвортой хөгжлийн зорилгуудыг тодорхойлж өгснөөр, хөгжил гэж яг юу вэ гэдгийг хүн бүр ойлгоход хялбар болгож, зөвхөн улс орон гэлтгүй, хувь хүн ч гэсэн ажил амьдралдаа эдгээр 17 зорилгуудыг өөрийн зорилго болгож, тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулахад асар их туслалцаа үзүүлсэн юм. 2015 оноос хойш ялангуяа бизнес эрхлэгчид, бүх төвшний компани болон төрийн бус байгууллагууд эдгээр 17 зорилгыг чухалчлан үзэх нь эрс ихэссэн байна. Аливаа улс орны засгийн газар, улс төрчдийг үнэлэхдээ ч гэсэн эдгээр 17 зорилгыг биелүүлэхийн төлөө ямар ажлыг хэрхэн хийснийг нь чухалчлан үзэж байна.

НҮБ тогтвортой хөгжлийн хөтөлбөрөө зарлахдаа “... ядуурал болон бусад бүх амьдралын хэрэгцээний хомсдлыг арилгах арга хэмжээнүүд нь боловсрол болон эрүүл мэндийг сайжруулах, тэгш бус байдлыг багасгах, эдийн засгийн өсөлтийг идэвхжүүлэхтэй эн зэрэгцэхүйц хэмжээнд авагдах ёстойгоос гадна, эдгээр бүх зорилгууд нь цаг уурын өөрчлөлттэй тэмцэж ой болон далайн экосистемийг хамгаалсан байх ёстой.” гэж заасан байдаг. Өөрөөр хэлбэл, тогтвортой хөгжилд зайлшгүй шаардлагатай нөхцөл нь “байгаль орчноо хамгаалсан, цаг уурын асуудалтай тэмцсэн” байх ёстой гэсэн үг юм. Хүн төрөлхтөн байгаль орчны асуудлаа шийдвэрлэлгүйгээр хэчнээн хөгжсөн ч, тэр нь тогтвортой хөгжил бус, хэзээ нэгэн цагт устаж үгүй болохоос өөр гарцгүй хөгжил байх болно. Харин олон улсын хэмжээнд НҮБ зэрэг томоохон байгууллагууд энэхүү асуудлыг анхааралдаа авч эхэлсэн нь 20-р зууны сүүл хагасаас гэж хэлж болох юм.


Анх 1972 онд Нэгдсэн Үндэсний Байгууллагын Байгаль Орчны Хөтөлбөр (UNEP), мөн 1988 онд Уур Амьсгалын Өөрчлөлтийн Засгийн Газар Хоорондын Хороо (IPCC) байгуулагдсанаар, улс орнууд байгаль орчны асуудлыг шийдвэрлэхээр хамтран ажиллаж эхэлсэн гэж хэлж болно. IPCC-гийн гол үүрэг бол олон улсын эрдэмтэн судлаачдын судалгааны ажлын үр дүнг нэгтгэн шинжилж, түүн дээр тулгуурлан дэлхийн дулаарлын талаарх томоохон дата статистикийг гаргах, засгийн газрууд байгаль орчны асуудалтай тэмцэхийн тулд ямар бодлого хэрэгжүүлэх хэрэгтэй вэ гэдгийг зөвлөх, үнэлгээ хийх явдал юм. Өөрөөр хэлбэл, аливаа улс орны засгийн газар байгаль орчны асуудлыг шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх бодлого, зорилт нь IPCC-ээс гаргасан тайлан зөвлөгөөг бодит ажил болгон хэрэгжүүлэхийг нэн чухалчлах хэрэгтэй аж. Түүнээс гадна, цаг уурын өөрчлөлттэй тэмцэхийн тулд олон улсын хэмжээний гэрээ хэлэлцүүлэг, хурал уулзалтыг зохион байгуулж, гэрээний хэрэгжилтийг хянах нь ч гэсэн IPCC-ын үүрэг билээ. Жишээлбэл, 1997 онд Киото хотод олон улсын уулзалтыг зохион байгуулж, “Киотогийн Протокол” хэмээх гэрээг байгуулж, цаашлаад 2015 онд “Парисын Гэрээ”-г байгуулсан юм.

2015 оны “Парисын Гэрээ”-р дэлхийн 196 улс орнууд хэлэлцээр хийж, аж үйлдвэрийн хувьсгалаас хойших дэлхийн дундаж температурын ихсэлтийг 1.5°C -ээр хязгаарлана хэмээх зорилтыг тогтоосон байдаг. Гэвч энэхүү зорилтдоо хүрч чадахуйц хэмжээний арга хэмжээг авч буй улс одоогоор цор ганц Марокко л байна. Улс төр, эдийн засгийн хүчээрээ дэлхийд хамгийн том нөлөөтөйд тооцогддог АНУ энэхүү асуудлыг шийдвэрлэхэд хамгийн том нөлөөтэй улс боловчиг, эдийн засгийн ашиг сонирхол, хэт үндсэрхэг үзлийн зөрчилдөөний улмаас Парисын гэрээнээс гарахаа хүртэл зарлаад байна. Хэрэв нөхцөл байдал одоогийнхоороо үргэлжилсээр байвал 21-р зууны төгсгөл гэхэд дэлхийн дундаж температур аж үйлдвэрийн хувьсгалын үеэс 4.1°C - 4.8°C -р өсөх нь тодорхой юм. Энэ фактыг дэлхийн лидерүүд, улс орны засгийн газрууд мэдсээр байж яагаад зохимжтой арга хэмжээ авч чадахгүй байна вэ? Дэлхийн дундаж температурыг 1.5°C -р хязгаарлаж чадахгүй бол хүн төрөлхтний ирээдүйд хэрхэн нөлөөлөх вэ?


Жишээ нь: Дэлхийн байгаль орчны асуудлыг шийдвэрлэхийн тулд, цаашлаад хүн төрөлхтний дэлхий дээрх иргэншил устаж үгүй болохгүйн тулд улс орнууд хэрхэн хамтран ажиллах хэрэгтэй вэ? Эдгээр асуудлуудыг шийдвэрлэх гол хүчин зүйл нь НҮБ-ын доорх олон улсын байгууллагууд, ТББ-ууд болоод байна.

Зураг 2. Дэлхийн дундаж температурын өсөлт (1951-1980 оны дундаж температуртай харьцуулав)


А World of Agreement: Temperatures are Rising
Global Temperature Anomaly (relative to 1951-1980, $^{\circ}\text{C}$)



Зураг 3. IPCC-с гаргасан 2014 оны үнэлгээний тайлан
(эх сурвалж хэсгээс унших боломжтой)



Эцэст нь хэлэхэд, хөгжил гэдэг нь зөвхөн хүн төрөлхтөн л тав тухтай, баян чинээлэг амьдарч байвал болох бус, байгаль эх дэлхийнхээ экосистемийг хамгаалах явдалтай салшгүй холбоотой юм. Дэлхийн улс орнуудад хувийн эрх чөлөөг чухалчлахын хирээр нэгж иргэн бидний өдөр тутмын сонголт, үйлдлүүд дэлхийн тогтвортой хөгжилд шууд нөлөөлж байна



Ном зүй

1. 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл
2. НҮБ тогтвортой хөгжлийн зорилгийн танилцуулга
3. Дэлхийн дундаж температур аж үйлдвэрийн хувьсгалын үеэс 4.1-4.8 С-р өснө
4. Дэлхийн дундаж температурын өсөлт)

ТЭМДЭГЛЭЛ

This image shows a single sheet of white paper with horizontal blue ruling lines. The lines are evenly spaced and run across the width of the page. There are no margins, text, or other markings on the paper.

“ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ ХХІ-ЗУУН

ИЛТГЭГЧ: ОБО1А АНГИЙН СУРАГЧ Г.АНУДАРЬ

Онолын үндэслэл

Ковид цар тахлын хөл хорионы үед бүхий л шатны боловсролын байгууллагууд цахим сургалт руу шилжих хэрэгцээ шаардлага гарч ирсэн. Бид өмнө нь цахим сургалтыг ойлгохдоо хичээлд бэлтгэх, хичээлийн зорилгоо хэрэгжүүлэх асуудалтай холбож ойлгодог, тэр хүрээнд авч хэрэглэдэг байсан бол одоо цахимаар хичээлийг хүргэх, цахимаар мэдлэг бүтээлгэх, ур чадвар эзэмшүүлэх асуудал тулгарч байна. Ялангуяа МСҮТ болон коллежид мэргэжлийн боловсрол олгодог тул онолын мэдлэгээс гадна дадлагажуулах шаардлагатай нь цахим сургалтын үед бодит асуудал болоод байна.

Сэдэв сонгосон үндэслэл

Чадварлаг боловсон хүчин бэлтгэхийн тулд боловсролд орчин үеийн шинэлэг арга барил, технологиудыг ашиглах шаардлагатай ба энэ үйл явцыг хурдасгахад цар тахал том нөлөө үзүүлсэн. Цар тахалын тархалтын оргил үед дэлхийн нийт суралцагчдын 91.3% нь сургуульд явах боломжгүй, онлайн болон бусад ямар нэг хэлбэрээр сургалтаа үргэлжлүүлэн, зарим улсад хязгаарлагдмал боломжоос хамаарч сургалт зогсоход хүрсэн байна. /en.unesco.org/

Харин Монгол Улсад 2020 оны 1-р сарын 27-оос энэ хичээлийн жил дуустал боловсролын байгууллагууд өөрсдийн нөөц боломжид суурилан цахим хэлбэрээр сургалтын үйл ажиллагааг зохион байгууллаа. 2019-2020 оны хичээлийн жилийн сүүлийн хагас жилд буюу цар тахлын улмаас үүссэн хөл хорионы үед цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, насан туршийн болон тусгай хэрэгцээт боловсрол, элсэлтийн ерөнхий шалгалтанд зориулж нийт 4210 цагийн теле хичээлийг үндэсний хэмжээнд хүргэжээ. Гэвч зөвхөн ЕБС-ийн батлагдсан сургалтын төлөвлөгөө ёсоор энэ хагас жилд 1-12 дугаар ангид 6393 цагийн хичээл орохоос 3790 орчим цагийн хичээлийг теле хэлбэрээр зохион байгуулсан. Энэхүү теле болон төрийн бус өмчийн ЕБС-ийн онлайн хичээл сургалтаар суралцагчид төлөвлөгдсөн хөтөлбөрийн үр дүнг эзэмшсэн гэдгээс илүү агуулгын бататгал, давталт хийсэн гэж дүгнэж болно.

Цахим хичээлийн хүртээмжтэй байдлын хувьд авч үзвэл судалгаанд хамрагдсан сурагчдын 16 орчим хувь нь теле хичээлийг хангалттай хэмжээнд үзэж судлах боломжгүй байсан байна. Улаанбаатар хотын сурагчдын 59 хувь нь гар утас ашиглаж байсан бол сумдад энэ үзүүлэлт 77 хувьд хүрчээ. Судалгаанд хамрагдсан нийт сурагчдын 6 орчим хувь нь телевиз, компьютер, гар утасгүй байгаа нь эдгээр хүүхдүүд теле хичээлийг үзэж сурч чадахгүй байх магадлал өндөр байгааг харуулж байна. /ikon.mn/

Хичээл сургалтын үр дүн талаас харахад хариуцлага, орчин, технологийн ялгаатай байдлаас хамаарч цаашид суралцагчдын хоцрогдол, ялгаатай байдал улам хол болох нөхцөл үүсч байна. Энэ нь цаашид урт хугацаанд хэмжээний хохирол учруулах учир гэнэтийн өөрчлөлтөнд тасалдахааргүй уян хатан сургалтын аргыг боловсруулах шаардлагатай. ХХІ- Мэдээллийн эрин зуунд шинэ технологийг сургалтад ашиглах нь хамгийн зөв шийдэл учир энэхүү сэдвийг сонгон авсан болно.

Судалгааны ажлыг дараах зорилго, зорилт

Зорилго: Суралцагчдын сурах арга барилын онцлогоос шалтгаалсан хоцрогдол, ялгаатай байдлын зөрүүг багасгах, технологийн дэвшлийг ашигласнаар сургалтын чанарыг сайжруулж үр дүнг дээшлүүлэх, сурагчдын бодит ур чадварыг сайжруулах боломжийг эрэлхийлж, арга зүй боловсруулахад оршино.

Зорилт:

1. Оюутан сурагчдад тулгамдаад буй цахим хичээлтэй холбоотой ямар хүндрэлүүд гарч байгаа талаар судлах
2. Ирээдүйд үүсч болох эрсдэлт нөхцөлд сургалтын хэрэглэгдэхүүний харьцангуй байдлаас үүссэн хичээлийн хоцрогдол, ялгаатай байдлын зөрүү бага гаргах сургалтын аргыг боловсруулах, суралцагчдад бие даан суралцах чадварыг нэмэгдүүлэх


Түлхүүр үг: Цахим сургалт, 21-р зуун, технологийн дэвшил, шинэ нормал

Үндсэн хэсэг

Гэнэтийн өөрчлөлт ба сургалтын онцлог:

Даяаршил, МХТ, мэдлэгийн тэсрэлтийн уялдаа холбоо нь орчин үеийн нийгэмд гайхалтай өөрчлөлтүүдийг авчирсан бөгөөд энэ нь бидний орчин үеийн амьдралын хэв маягийн бүхий л асуудлыг сорьж ирсэн. Эдгээр өөрчлөлтүүдийг даван туулахын тулд бид энэ дижитал эрин үеийг тодорхойлдог олон тооны электрон технологийг ашиглах чадвартай боловсон хүчнээ бэлтгэх хэрэгтэй. Космополит хандлагатай, соёл дамжсан ойлголттой, бүлгийн төслүүддээр олон соёл орчинд ажиллах чадвартай, боловсрол олгоход бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэх чадвар бүхий иргэдийг бэлтгэх шаардлагатай. Өнөө, маргаашийн “дижитал уугуул иргэдэд” боловсрол олгох арга барилд, ялангуяа хөгжиж буй орнуудад эрс өөрчлөлт хийхээс өөр зүйл шаардагдахгүй /**Ranbir Sinkh Malik, Educational challenges in 21st century and sustainable development**/.

Сургуульд явах нь ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн төрийн бодлогын хамгийн сайн хэрэгсэл. Гэтэл уламжлалт танхимын сургалт цар тахалаас болж явагдах боломжгүй болсон бөгөөд үүнийг бид цахимаар үргэлжлүүлж байгаа нь олон эерэг ба сөрөг үр дагавар авч ирж байгаа. Заах аргын болон суралцах аргын ялгаатай байдлаас үүдэн цахим хичээлийн үр дүн багасч, хоцрогдол үүсч байгаа нь нууц биш. Жишээ нь: ҮҮПКоллежийн зарим оюутнуудын дунд судалгаа хийхэд:



Судалгаанд оролцсон оюутнуудын 90%-нь хоцрогдож байгаа гэж хариулжээ. МСҮТ, коллеж болон их сургуулиуд шинэ мэдлэгийг бий болгохын зэрэгцээ зохих чадварыг хөгжүүлэх, тогтвортой байдлын мэдлэгийг дээшлүүлэхэд хувь нэмрээ оруулах замаар дэлхийн хөгжлийн ирээдүйн төлөв байдлыг тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэдэг. Ийм байгууллагуудад цахимаар дадлагын ур чадвар олгох, боловсролын тогтвортой байдлыг хангах нь улам хэцүү болж байна. Тогтвортой хөгжил бол хүн төрөлхтний хэрэгцээ, хүрээлэн буй орчны чадварыг харилцан уялдуулан хангаж байдаг өөрчлөлтийн үйл явц мөн.

Иймээс бид цаашид гэнэтийн эрсдэлт нөхцөл үүссэн үедийм асуудал үүсгэхгүйн тулд цахим хичээлийн давууталуудыг хөгжүүлж ашиглах нь ирээдүйн сургалтын арга барилд томоохон дэвшил болох юм.

“Тогтвортой хөгжил -2030 хөтөлбөр”-ийг анх 2012 онд Рио Де Жанейро хотод улс орнуудын төрийн тэргүүнүүд оролцсон НҮБ-ын “Тогтвортой хөгжил” бага хурлын үеэр санаачилсан.

Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ) нь 2015 онд хэрэгжилтийн хугацаа нь дуусгавар болж буй “Мянганы хөгжлийн зорилтууд”-ын үргэлжлэл юм.

2015 онд НҮБ-ын Ерөнхий Асамблейн 70 дугаар чуулган болж, ТХЗ-ын 17 зорилго, 169 зорилтыг баталж, 2016 оны 1 сарын 1-нээс “Тогтвортой хөгжлийн зорилго” (ТХЗ) албан ёсоор дэлхий нийтээр хэрэгжиж эхэлсэн /sdg.1212.mn/. Эдгээр нь ядуурал, өлсгөлөнг бууруулах, жендэрийн тэгш байдлыг хангах, шударга бус байдлыг үгүй хийх, зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтийг хангах г.м нийт 17 зорилттой байдаг. Үүнд боловсролын тэгш хүртээмж ч хамаарна. Гэтэл цар тахал гарснаар баян ядуугийн ялгаа улам ихэсч, үүнийг дагаад боловсролын хүртээмж улам багасч болсон бөгөөд өдгөө бид зөвхөн цахим сургалтын аргыг ашиглахаас өөр аргагүй болсон.

Цахим сургалт гэдэг нь нэг үгээр хэлбэл МХХТ-д суурилсан сургалт юм. Цахим сургалтын материалыг боловсруулах нь танхимын сургалтын материал боловсруулахаас үнэтэй /80%/, цаг хугацаа, хүн хүч, хөдөлмөр их шаарддаг. Харин боловсруулсны дараа цахим сургалтыг явуулах нь ангид сургалтыг явуулахаас олон талаараа давуутай байдаг ба хөгжүүлэхэд хялбар байдаг.

Сүүлийн үеийн судалгаануудад сонсох эрхтэнээр мэдээллийн 15%-ийг, харах эрхтэнээрээ 25%-ийг хүлээн авах чадвартай байдаг бол хоёуланг нь хослуулан хэрэглэсэн үед 65%-д хүрдэгийг нотолжээ.

Хүний харах мэдрэхүйгээрээ хүлээж авсан мэдээлэл сонсох мэдрэхүйгээр хүлээн авсан мэдээллээс илүү үнэмшилтэй байдгийн зэрэгцээ баттогтож, удаан мартагддаг. Мэдээлэл, холбооны харилцааны технологийг сургалтад хэрэглэснээр суралцагчдын хүлээн авч буй мэдээлэл нь өнгөтэй, орон зайн хэмжээстэй, хөдөлгөөнтэй, дуутай болж байна. /Жаргалсайхан Г. “Судалгааны ажил 2020-2021”/ **Цахим хэрэглэгдэхүүн нь суралцагчийн танин мэдэх үйл ажиллагааг эрчимжүүлж аливаа асуудалд бүтээлчээр хандан мэдлэг боловсролоо дээшлүүлэн бодит чадвар эзэмшихэд чухад үүрэг гүйцэтгэж байна.**

Энэ давуу талыг улам хөгжүүлж хувь хүний суралцах ба заах арга барилын ялгаатай байдлаас үүсдэг хоцрогдлыг гаргахгүй байх боломжтой. Өөрөөр хэлбэл, багш нар өөр өөрсдийн гэсэн нэг л аргаар хичээлээ заадаг, үүнээс болж бүх сурагчдад тэгш хэмжээний боловсрол түгээж чаддаггүй. Учир нь сурагчид ч гэсэн өөр өөрийн суралцах арга барилтай, үүнд нь багшийн заах арга, сургалтын программ тохироогүйн улмаас суралцагч хичээлдээ дургүй болох, идэвх буурах г.м сөрөг үр дагавар гардаг.

Дээр дурьдсанчлан сурагчдын мэдээлэл хүлээн авах арга хэрэгсэл нь сурах бичиг, ном сонингоор хязгаарлагдахгүй болсон. Цаг хугацаа, орон зайн хувьд алслагдмал юмс, үзэгдлийг хүн шууд танин мэдэж чадахгүйгээс гадна объектуудын хоорондын харьцаа, хамаарлыг шууд хүртэн мэдэх боломжгүй г.м бэрхшээлийг хүн төрөлхтөн мэдэрч, танин мэдэх аргаас ангижирсан. Чухамхүү энд л мэдээллийн технологийн ач холбогдол оршино.

Учир нь:

- Радио аппаратаар радио долгионыг;
- Фото зураг, киноны тусламжтайгаар өнгөрснийг;
- Телевизийн тусламжтайгаар олон мянган километрийн зайд оршиж байгаа юмс, үзэгдлийг харж, дууг радиогоор сонсож, тус тус танин мэдэж байна. Одоо үед эдгээр төхөөрөмжүүд нь алганд л багтчих гар утсаар солигдож байна гэхэд хилсдэхгүй. Цаашид ч мэдээллийн технологи улам хурдацтай хөгжих нь мэдээжийн хэрэг билээ.

Ойролцоогоор 10-20 жилийн дараа гэхэд хиймэл оюун ухаан гэх ойлголт хүн төрөлхтөний амьдралын салшгүй нэг хэсэг болно. Зарим нь эхнээсээ ашиглалтад орж буй. Мөн энэ асуудлыг судалдаг шинжлэх ухааны салбар, судалгааны чиглэл, их дээд сургуулийн хичээл, курсийг нэрлэхдээ энэ нэр томъёог ашиглана. Хиймэл оюун ухаан судлал, хиймэл оюун ухааны хичээл гэх мэт. Ихэнх хиймэл оюун судлаачид болон ном зохиолд судалгааны энэ чиглэлийг тодорхойлохдоо “ухаалаг агент бүтээх шинжлэх ухааны судалгаа” гэсэн байдаг. /mn.m.wikipedia.org/

Тэгвэл үүнийг сургалтад яаж ашиглах вэ?

Хүн бүрийн онцлогт тохирсон сургалтын арга боловсруулах боломжтой юу?


Хариулт нь тийм. Үүнийг МХХТ-г ухаалгаар ашигласнаар багшийн үүргийг гүйцэтгүүлж ч болох юм. Суралцагчдын сурах аргын онцлогт тохируулж виртуал модел (Virtual model Amara etc.) шиг тодорхой дүр бүтээн тухайн “багш”-тайгаа ярилцаж хамтран мэдлэг олж авах маягаар зөвхөн ЕБС-ийн насны хүүхдүүдэд биш хүнийг насан туршид боловсрол олгох бүрэн боломжтой.

Судалгааны хэсэг

Цахим сургалтын үед тулгамдаж буй асуудлууд

Судалгааны ажлаараа ҮУПКоллежийн оюутнуудын дунд судалгаа явуулж, тулгамдаж буй асуудлуудыг мэдэхийг зорьсон.


1. “Цахим хичээлд хоцрогдох болсон шалтгаан юу вэ?” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 63.5% нь “Дата/ wifi хүрэлцээ муу” гэж хариулснаас харахад оюутнуудын хичээллэх нөхцөл муу хангагдсан гэж үзэж байна.



2. “Удаан хугацаагаар цахимаар хичээллэх нь эрүүл мэндэд тань ямар сөрөг нөлөө үзүүлж байна вэ?” гэсэн асуултад “Хараа муудсан”, “Биеийн зарим хэсгээр чилж өвддөг болсон” гэх мэт хариултауд зонхилж байна. Энэ нь удаан хугацаагаар цахимаар хичээллэх нь хөдөлгөөний дутагдал үүсгэж үүнээс шалтгаалсан хууч өвчлөл үүсэх эрсдэлтэйг харуулж байна.

Цахим хичээл удаан хийх нь таны эрүүл мэндэд сөргөөр нөлөөлсөн бол ямар өөрчлөлт гарсан бэ? (олон хариу сонгож болно)

71 responses



3. Цахим хичээлийн дутагдлын талаарх асуултад багш нар хэт их лекц өгдөг, хичээлүүдээ уншиж л ойлгох хэрэгтэй болдог, дадлага хийж чаддаггүй г.м хариултауд ирсэн бөгөөд оюутнуудын сурах аргын онцлогоос хамаарч боловсролын ялгаа үүсч буйг үүнээс харж болно.

Эдгээрээс дүгнэхэд зөвхөн цахим хичээлээр дагнан суралцах нь суралцагчдад эрүүл мэнд болон боловсролын чанарт муугаар нөлөөлөх г.м сөрөг нөлөө гарч байна.

4. Шийдвэрлэх санал-хиймэл оюуныг сургалтанд ашиглах нь Анх “Хиймэл оюун ухаан” хэмээх нэр томъёог Жон Маккарти 1955 онд өөрийн бүтээлдээ ашиглаж, “ухаант машин техник бүтээх онолын болон инженерийн шинжлэх ухаан” гэж тодорхойлжээ. /mn.m.wikipedia.mn/

Хиймэл оюун нь өөрийгөө хөгжүүлж байдаг программ хангамжийн төгс программ юм. Бид бүхэн хиймэл оюуныг роботоор төсөөлж болно. Гэхдээ өнөөгийн робот бол зөвхөн тухайн зохиогчийн бичигдсэн алгоритмын дарааллаар ажилладаг билээ. Мөн өнөөгийн компьютер тоглоомууд нь үүний тод жишээ юм. Хэрэв бид төгс хиймэл оюуныг зохион бүтээх аваас хүн төрөлхтөн өөрсдийнхөө бүтээсэн зүйлд устаж үгүй болох магадлалтай.

Хиймэл оюунд байвал зохих чадварууд:

1. Өөрт дүн шинжилгээ хийж, хариултыг өөрийнхөөр илэрхийлдэг байх.
2. Өөрийн алдааг олж засварладаг
3. Хүний сэтгэхүйгээс илүү давсныг сэтгэх

Дэлхийн хоёрдугаар дайны дараа, хэсэг бүлэг хүмүүс бие даан оюун ухаант машиныг хийхээр ажиллаж эхэлсэн. Английн математикч Алан Тюринг 1947 онд анхны судалгаагаа танилцуулсан. Тэрээр машин бүтээхээс илүү компьютерын програмчлалаар ХО-г судлах нь хамгийн сайн гэдгийг анх шийджээ.

1990-ээд он болон 21-р зууны эхэн үед ХО-ны салбар хэдий анхаарлын төвд байгаагүй ч хамгийн дээд амжилтдаа хүрэв. Хиймэл оюун ухааныг ложистик, мэдээллийн олборлолт, эмчилгээний дүн шинжилгээ болон бусад олон салбарт технологийн үйлдвэрлэлээр дамжуулан ашигладаг. Тэгвэл үүнийг сургалтанд ашиглавал танхимын болон одоогийн цахим хичээлүүдэд гарч буй дутагдлуудыг арилгах боломжтой.

Давуу тал

1. Суралцагчдын зан төлөв, онцлог, сурах арга барилд тохирсон аргаар мэдлэг олгоно
2. Багш нар суурь мэдлэгээ хангалттай судалсан хүүхдүүдтэй ажиллах учир ажлын ачаалал багасч болно
3. Сурагчид хичээлийн хоцрогдолд орохгүй, хичээлдээ дургүй болох, бэлэнчлэх сэтгэлгээ үүсэхгүй, бүтээлч, бие дааж суралцах чадвартай болно
4. Цаашлаад хүмүүс компьютерийг тархитайгаа холбож өөрсдийн гэсэн simulation ертөнцийг бүтээх ч боломж байгаа бөгөөд ингэж чадвал бодит байдалд туршихад хүндрэлтэй зарим төрлийн дадлагыг хийх боломж ч бий.

Сул тал

1. Хиймэл оюун ухааныг ийм өндөр түвшинд хараахан хөгжүүлээгүй байгаа
2. Сургалтад нэвтэрсэн ч багшийн ажлыг бүрэн орлох нь учир дутагдалтай ба онолын мэдлэг олгоход л ашиглаж болох учир багшийн туслах болно.
3. Хиймэл оюун ухааныг бид хяналтаасаа алдвал хүн төрөлхтөн зогсоож чадахааргүй болох магадлалтай. Тиймээс хөгжүүлэлтэд ч гэсэн анхаарал болгоомжтой хандах хэрэгтэй юм.

Хиймэл оюун ухаанд суурилсан сургалтын хэрэглэгдэхүүний тод жишээ бол **TOMOYO** аппликэшин юм. Гадаадад суралцахыг өмнөх бэлтгэл болохуйц сонирхолтой хичээлүүдийг хиймэл оюун ухааны тусламжтай хэрэглэгчдээ санал болгодог. Нэг үгээр бол суралцагчдын туслах юм. Үүнтэй адилаар ерөнхий сургалтын системд суурь өөрчлөлт хийх боломжтой бөгөөд энэ нь цаг хугацааны асуудал болоод байна.



Дүгнэлт

Цар тахалын нөлөөгөөр хүмүүс чөлөөтэй шилжилт хөдөлгөөн хийх боломжгүй болж, үүнийг дагаад сургуулиуд ч үйл ажиллагаагаа зогсоон, цахим болон теле хэлбэрээр боловсрол олгох болсон. Үүнийг дагаад олон эерэг болон сөрөг үр дагавар гарч байна.

Цахим ба танхимын хичээлүүдэд аль алинд нь давуу болон сул тал байдаг учир харилцан тэдгээр сул талуудыг нөхөх байдлаар цагийг нь уялдуулан хосолсон сургалт явуулах нь нэг дор олон чадвар олгох бөгөөд ойлгохгүй үлдэх асуудал бага гарна. Гэвч ийм боломжгүй үед сургалтад ямар нэг байдлаар хоцрогдол үүсч байгаа учир технологийн дэвшил-хиймэл оюун ухааныг ашиглан боловсролын системд өөрчлөлт оруулах нь зөв шийдэл юм.

Гэвч энэ нь багшийн ажлыг бүрэн орлож чадахгүй учир зөвхөн туслахын үүрэг гүйцэтгэж, суралцагчдад суурь онолын мэдлэг олгож болох юм. Үр дүнд нь зөвхөн лекцийн мэдлэг өгч, эргээд түүнийгээ шалгахад өөр зүйл хийдэггүй, идэвхтэй аргаар зааж чаддаггүй багш нар мэргэжлийн зах зээлээс шахагдаж ур чадвараа нэмэгдүүлэхээс өөр аргагүй болно. Ингэснээр багшийн хөгжилд ч, боловсролын системд ч, сурагчдын чадварт ч томоохон ахиц гарах юм.



Ном зүй:

- Оюутан суралцагчдаас авах судалгаа;
- 21-р зууны боловсролын зорилтууд, тогтвортой хөгжил нийтлэл; 2018 оны 5сар (educational challenges in 21st century and sustainable development)
- wikipedia.mn
- ikon.mn
- 1212.mn
- Жаргалсайхан Г. “Судалгааны ажил 2020-2021”

This image shows a full page of blank white paper with horizontal ruling lines. The lines are evenly spaced and run across the width of the page, providing a template for writing or drawing. There are no margins, text, or other markings present.

ИЛТГЭГЧ: ЗБЖБҮА1А АНГИЙН СУРАГЧ Н.ХАЛИУНАА

Төлөвлөлт гэж юу вэ?

Энэ илтгэлээр хэрхэн сайн төлөвлөлт хийх аргачлалаас хуваалцах болно. Хэрвээ та ямар нэгэн ажил төлөвлөөд тэр төлөвлөгөөндөө төдийлөн хүрж чадахгүй эсвэл зүгээр л хүсэл хэвээрээ үлдээд байсан бол энэ хүслийг яаж зорилго болгоод, зорилгоо яаж төлөвлөгөөтэйгөөр биелүүлэх вэ гэсэн арга аргачлалаас хуваалцах болно. Төлөвлөлт, төлөвлөгөө гэдэг нь тусдаа нэг ойлголт юм. Төлөвлөлт гэдэг нь хүсэн хүлээж буй ирээдүйг төсөөлж, түүнд хэрхэн хүрэх шийдлийг тодорхойлох үйл ажиллагаа юм.

Харин төлөвлөгөө гэдэг нь төлөвлөлтийн үйл ажиллагааны дүнд бий болсон хэн, хэзээ, юу хийхийг тодорхойлж өгсөн шийдвэр юм.

Бид яагаад заавал төлөвлөх хэрэгтэй вэ?

Учир нь хийх гэж буй зүйлсээ төлөвлөснөөр зорилгоо тодорхойлоход тусална. Маргааш өнөөдрөөс илүү нөгөөдөр маргаашаас илүү болохын тулд, байгаагаасаа 15 шатаар дээр өндөрлөгт хүрэхийн тулд төлөвлөгөө хэрэгтэй.

Төлөвлөлтийн үндсэн 3 асуудал нь:

- Одоо бид хаана байна?
- Бид хаанаас хаашаа явахыг хүсэж байна?
- Үүний тулд юу хийх хэрэгтэй вэ? гэсэн асуулт юм.

Төлөвлөлт гаргахдаа юуг анхаарах вэ? гэвэл таны тавьсан зорилго бүхэн эргээд биелэх боломжтой байх хэрэгтэй.

Та яг ямар үр дүнд хүрмээр байгаагаа маш нарийвчлалтайгаар тодорхойлох хэрэгтэй.

Төлөвлөлт нь 4 үе шаттай байдаг.

1. Ямар үр дүнд хүрэхийг хүсэж байгаагаа тодорхойлно.

- Үүнээс үзэхэд төлөвлөлт гэдэг цикл нь дан ганц зорилгод хүрэхийн төлөө төлөвлөсөн биш. Энэ нь эргээд хүсэл болж болно, эерэг дадал зуршлийг бий болгоно

2. Үүнд хүрэхийн тулд хийх ёстой.

3. Гарсан үр дүнг үнэлэх

- Эхний төлөвлөлтөө эргэн харж тавьсан зорилгодоо хүрч чадсан уу аль эсвэл дөхөж ч чадаагүй юу гэдэг дээрээ дүгнэлт хийнэ.

4. Дүгнэлтээс гарсан үр дүнг үндэслэж дахин төлөвлөх

- Яг юун дээр алдсан юун дээр оносон гэдэг дээрээ үндэслэн ахин төлөвлөлт хийнэ.

Энэ тойрог нь зогсолтгүй үргэлжилсээр байдаг.

Хувийн амьдрал дээр ч байна уу эсвэл бизнес ч бай бид аливаа нэг зүйлийг төлөвлөсөөр л байдаг.

Үүнээс харахад төлөвлөлт гэдэг бол бидний амьдралийн салшгүй нэг хэсэг юм.

Төлөвлөлтийн түвшинг 3 ангилж үздэг.

1. **/Strategic planning/** буюу чиглэлтэй, ирээдүйн ерөнхий таамаглалтай, урт хугацааны зорилгыг хэлдэг.
2. **/Tactical planning/** буюу урт хугацааны зорилгод чиглэдэг.
3. **/Operational planning/** буюу үйл ажиллагааны зорилгод чиглэсэн, нарийвчлалтай, богино хугацааны зорилго юм.



Дүгнэлт:

Хэрэв бид төлөвлөгөөг өөрийн амьдралд хэрэгжүүлж дадал болгож чадвал бидэнд зөв хэвшил болно. Ялангуяа цар тахлын үедхүн бүр өдөрт хийх зүйлсээ төлөвлөвөл өдрийг үр бүтээлтэй хийсэн зүйлтэй өнгөрөөх боломж гарж ирнэ.

Хэрэв сайн төлөвлөж чадвал сайн үр дүн гарна. Жишээ нь төлөвлөлтгүй худалдан авалтын үр дүнд ашиггүй зарлага гарсан байх буюу сэтгэл ханамж муутай байх магадлалтай.

Хоногийн 24 цагтаа л багтаж амьдар. Өөрөөр хэлбэл өдрийн төлөвлөгөө гаргаж бай гэсэн үг.

Өдрийн төлөвлөгөө гаргана гэдэг бол цаг ашиглаж сурах анхний алхам юм.



ТЭМДЭГЛЭЛ

ЭРСДЛЭЭС АЙХ НЬ АМЖИЛТААС ТАТГАЛЗАХ

ИЛТГЭГЧ: ЗБЖБҮА1А АНГИЙН СУРАГЧ Д. ЗОЛЖАРГАЛ
УДИРСАН БАГШ: АНГИ УДИРДСАН БАГШ У. ОЮУНБАЯР



Агуулга

Төлөвлөгөө

1. Удиртгал.....хуудас
 - Судалгааны зорилт
 - Сэдвийн судлагдсан байдал
2. Үндсэн хэсэг.....хуудас
 - Тэргүүн бүлэг:
 - 1.1. Сэдэв сонгосон болох үндэслэл
 - 1.2. Бэлтгэсэн илтгэл
3. Дүгнэлт хэсэг.....хуудас
4. Ашигласан ном зүй.....хуудас



1.1. Зорилт

- Сэдвийн хүрээнд онолын мэдлэгтэй болох
- Өгөгдсөн сэдвийн хүрээнд мэдээллийг бусдад хүргэх

1.2. Судлагдсан байдал

Сэдвийн хүрээнд зорилгодоо хүрэхийн тулд хэрэглэгдэх ном, сурах бичиг, интернэт мэдээллийн систем зэргээс судалгаа хийж мэдээлэл цуглуулсан.

2. Үндсэн хэсэг

2.1. Оршил

Энэхүү “Эрсдлээс айх нь амжилтаас татгалзах гэсэн үг” гэдэг сэдвийг яагаад сонгосон бэ? гэвэл хэрхэн эрсдлээ давж, давааны цаана байгаа даваагаа давж улам дээш тэмүүлэж амжилтанд хүрэх, үүнд бусдыг хэрхэн байлдан дагуулж болох талаар миний болон бусдын санал ямар байдаг вэ? Хүн болгонд айдас болон түүнээсээ айсан эрсдэл гэх ойлголт байдаг. Түүнийгээ даван туулах арга замуудыг судлан бусдад түүнийгээ түгээн дэлгэрүүлэх гэсэн үндэслэлээр бэлтгэсэн юм.

2.2. Эрсдлээс айх нь амжилтаас татгалзах гэсэн үг

Та амьдралдаа хэр олон удаа эрсдэл гаргаж байсан бэ?

Эрсдэл гаргахаас айгаад арагш суусаар байна уу?

Та доорх үгнүүдээс алыг нь хамгийн их хэрэглэдэг вэ?

1. Би хийхгүй
2. Яаж хийх вэ?
3. Хэцүү юм
4. Би чадахгүй байх. Тэр хэмжээгээрээ таны амжилтанд хүрэх боломж тийм шатанд байна гэсэн үг.



Тиймээс дээрх үгнүүдийг мартаж хэрэгтэй. Эдгээр үг нь таныг амжилтаас хойш татаж байдгыг санаарай. Оролдож үзээгүй байж бууж өгнө гэдэг хамгийн хармасмаар зүйл. Амжилтанд хүрэх хамгийн гайхамшигтай чадвар бол өөрийгөө ялах гэдгийг олон алдартан амжилттай яваа хүмүүс хэлсэн байдаг. **Жишээ дурьдвал:**

- Жан-Жак-Русс \1712-1778\

Тэвчээр нь гашуун боловч үр жимс нь чихэрлэг байдаг.

- Томас-Альва-Эдисон \1847-1931\

Бидний хамгийн том сул тал бол бууж өгөх байдаг.

Амжилтанд хүрэх тодорхой арга бол дахиад нэг удаа оролдоод үзэх явдал юм.

Ямар нэгэн зүйлийг хийх зориг чинь хүрэхгүй байгаа бол энэ нь айдас болон хувирдаг ба айдас амьдарлыг удирдах үед сүүдэр чамайг ямагт дагаж байдаг. Тиймээс айдасаа даван туулах нь амжилтын суурь үндэс нь юм. Хүн бүр амжилтын өөд мацахыг хүсдэг. Гэвч амжилтыг хэн нэгэн хаа нэгтэйгээс бидэнд авчирч өгдөггүй учраас өөрөө тэмцэх хэрэгтэй.

“Суубилэг эхлэлийг тавьж болох ч

Үйл хэргийг гүйцээхэд тэвчээр хөдөлмөр хэрэгтэй” гэдэг үг байдаг. Хэрэв эрсдлээс айж байвал амжилтаас татгалзсантай адил. Судалгаагаар бид яагаад аюулгүй замаар тоглох дуртайг ийн тайлбарлажээ.

I. Эрсдлийг хэтрүүлэн тооцдог.

II. Өөрийн эрсдэлээ даван гарах чадвараа доогуур үнэлдэг.

Түүнчлэн эрсдэлээс зайлс хийх нь ойрын ирээдүйд аюулгүй мэт санагдавч “Хэрэв тэгсэн бол гэх” харуусалыг дагуулдаг. Ажил амьдралдаа зоригтой байж сурахын тулд хүссэн бүхэнээ олж авахад тань туслах дараах 4-н хаалгыг би нээж өгье.

1. Харилцан ярихдаа зоригтой байх
2. Тодорхой байдлаа үл тоон шийдэмгий байх
3. Хэдий таагүй байвч өөрчлөлтөнд таатай хандах
4. Үнэнхүү хүсэж байгаа зүйлээ асуу

XXI ЗУУНЫ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ БА ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

ИЛТГЭГЧ: ЗБЖБҮА2А АНГИЙН СУРАГЧ М.АНУЖИН

XXI зууны аялал жуулчлал ба тогтвортой хөгжил

Тогтвортой хөгжил гэж юу вэ?

Тогтвортой хөгжил гэдэг нь эдийн засгийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бүрэн тооцсон бүрэн хэрэглэж, нөхөн сэргээж болох, бүрэн шавхагдашгүй байгалийн нөөцийн ашиглалт дээр үндэслэсэн, хүрээлэн буй орчинд халгүй эдийн засгийн үзэл баримтлал юм.

Орчин үеддэлхий дахины хөгжлийн ерөнхий чиг хандлага нь зохистой хэрэглээг төлөвшүүлэх, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийг бий болгох, улс орнууд өөр өөрийн өвөрмөц шинж төрх, баялгаа хадгалах замаар “ногоон” хэв загварт шилжиж байна. Ийм нөхцөлд дэлхийн улс орнуудын эдийн засгийн тулгуур салбарын нэг болж, асар хурдацтай хөгжиж буй аялал жуулчлалын салбарт эерэг, сөрөг нөлөөлөл ихээхэн гарсан байна. Аялал жуулчлалын үйл ажиллагаанд хамгийн ихээр өртөж, үндсэн шинж чанараа алдаж байдаг зүйлс нь байгаль орчин, хүн ардын соёл, уламжлалт зан заншил буюу тухайн улс үндэстний бусад улс үндэстнээс ялгарах илэрхийлэл болдог зүйлс байдаг бөгөөд энэ нь тухайн аялал жуулчлалын бүс нутгийн дархлаа нь байдаг.

Тэгвэл бид дархлаагаа хэрхэн хамгаалах вэ?

XXI зуунд Монголчууд бид энэхүү дархлаагаа бусдад түгээх болон тогтвортой байлгах нь чухал асуудал юм. Дэлхий дахин өнөөдөр аялал жуулчлалыг “Ард түмнүүдийн найрамдал, хамтын ажиллагааг идэвхжүүлэгч”, “Утаагүй үйлдвэрлэл”, “Үл үзэгдэгч экспорт” гэдэг сонгодог утгаар нь эрчимтэй хөгжүүлж байна. Бид аялал жуулчлалаар дамжуулан дархлаагаа түгээх, бэхжүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулж болох юм. Энэ нь тогтвортой хөгжилд ихээхэн нөлөөлөх болно.

Монгол улсын хүн амын нягтрал 2016-2019 оны судалгаагааг хүснэгтээр үзүүлэв.

ХҮН АМЫН НЯГТРАЛ, аймаг, нийслэлээр

Аймаг	2016	2017	2018	2019
Улсын дүн	2.	2.	2.1	2.1
Баруун бүс	0.9	1.	1.	1.
Баян-Өлгий	2.2	2.2	2.3	2.4
Говь-Алтай	0.4	0.4	0.4	0.4
Завхан	0.9	0.9	0.9	0.9
Увс	1.2	1.2	1.2	1.2
Ховд	1.1	1.1	1.2	1.2
Хангайн бүс	1.5	1.5	1.6	1.6
Архангай	1.7	1.7	1.7	1.7
Баянхонгор	0.7	0.7	0.8	0.8
Булган	1.2	1.3	1.3	1.3
Орхон	127.2	130.	132.5	134.5
Өвөрхангай	1.8	1.8	1.9	1.9
Хөвсгөл	1.3	1.3	1.3	1.3
Төвийн бүс	1.	1.1	1.1	1.1
Говьсүмбэр	3.1	3.2	3.2	3.3
Дархан-Уул	30.9	31.5	32.1	32.4
Дорноговь	0.6	0.6	0.6	0.6
Дундговь	0.6	0.6	0.6	0.6
Өмнөговь	0.4	0.4	0.4	0.4
Сэлэнгэ	2.6	2.7	2.7	2.7
Төв	1.2	1.3	1.3	1.3
Зүүн бүс	0.7	0.8	0.8	0.8
Дорнод	0.6	0.6	0.7	0.7
Сүхбаатар	0.7	0.7	0.8	0.8
Хэнтий	0.9	0.9	1.	1.
Улаанбаатар	306.5	311.3	317.3	327.6
Улаанбаатар	306.5	311.3	317.3	327.6

Монгол улсын газар нутгийн талбай 1566600 км² юм. Харин нийслэл Улаанбаатар хотын газар нутаг нь нийт 4704.4 км² байдаг. Монгол улсын хүн амын ихэнхи хувь нь Улаанбаатар хотод оршин суудаг байна. Иймд хот суурин газрын болон хөдөө орон нутгийн иргэдэдийг **“Domestic tourism”** буюу “Дотоодын аялал жуулчлал”-д татан оролцуулах, мөн үүнтэй уялдуулан байгальтай харьцахад чиглүүлсэн зөвлөмж болон “Үзэсгэлэнт байгальд хэрхэн аялах”, “Тусгай хамгаалалттай газарт хэрхэн аялах”, түүнчлэн “Байгаль хамгааллын үйл ажиллагаа”, “Аж ахуй эрхлэгчдэд зориулсан байгаль хамгаалал” зэрэг байгаль хамгаалах талаар мэдээллүүдийг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа явуулж эко аялал жуулчлалыг хөгжүүлэх боломж бидэнд бий.

Олон Улсын Эко Аялал Жуулчлалын Нийгэмлэгээс (**International Ecotourism Society**) “Байгаль орчныг хамгаалах, орон нутгийн иргэдийн амьдралыг сайжруулахад чиглэсэн байгаль руу чиглэсэн аялал жуулчлалыг эко аялал жуулчлал гэнэ” хэмээн тодорхойлсон байдаг юм.

1985 онд Дэлхийн Аялал Жуулчлалын Байгууллага /WTO/, Нэгдсэн Үндэсний Байгууллагын Байгаль Орчны Хөтөлбөр /UNEP/ “Аялал жуулчлал ба Байгаль орчны тухай хамтарсан тунхаглал”-даа “Байгаль хамгаалахад аялал жуулчлалын уялдаа холбоог бэхжүүлснээр хөгжлийн үндсэн нөхцөл болно” гэж заасан байдаг. Тийм ч учраас эко аялал жуулчлал нь тогтвортой хөгжлийн үндсэн суурь болох бүрэн боломжтой юм.

Халдварт өвчин дэлхий дахинд тархаад буй энэ үед виртуал аялалыг ихээхэн хийх болсон боловч ихэнх улс орон аялал жуулчлалын салбараа хөгжүүлэхийн тулд эрсдэлтэй тулгарсан ч хилээ нээн гадаадын жуулчдыг хүлээн авч, жуулчид ч мөн эрсдэлээс зайлсхийлгүй хүссэн улс орон руугаа аялсаар байгаа нь хүмүүс биеэр үзэж, таашаал авахыг илүүд үздэгийн илрэл юм. Тийм ч учраас Монгол улсынхаа үзэсгэлэнт байгалийн нөөцөө ашиглах, цаашилбал байгалийн нөөцөө нэмэгдүүлэх тал дээр онцгой анхааран ажиллахын тулд гадаадын болон дотоодын жуулчид монголыг зорин ирж, байгалийн сайхныг биеэрээ мэдэрч аялах зугаалах боломжийг бий болгох хэрэгтэй гэж үзэж байна. Үүнтэй холбогдуулан нэгэн асуулт асууя.

Хүний тархи хэрхэн ажилладаг вэ?

1. Тархинд очсон дохион дээр дөрөөлж тархины үйл ажиллагаа явагддаг. Та бүхэн хэн нэгнийг мөргөлөө гэж бодъё. Тэр хүний царайг ямар нэгэн байдлаар харах болно. Тэгснээр тэр хүний царайг та тогтоож авна. Хэрвээ та тэр хүнтэй дахин таарвал “Өө энэ хүн чинь надтай мөргөлдсөн хүн байна шүү дээ” гэж таних болно. Та түүнтэй мөргөлдөөгүй байсан бол энэ орчлон хорвоо дээр байхгүй юм шиг л зөрөөд өнгөрөх байсан. Та тэр хүнтэй мөргөлдөж тэр хүний царайг харснаар дохио тархинд очсон байгаа юм. Тэгэхээр тархи нь тархинд очсон дохион дээр тулгуурлан ажилладаг байх нь.



2. Тааламжтай санагдсан зүйлээ хийхийг шаарддаг. Манай ангид 2020 оны намраас эхлэн Солонгос хэлний хичээл орж эхэлсэн. Багш маань хичээлээ үнэхээр сайн заадаг болохоор шимтэн хичээллэж байгаа. Анхны хичээлээ орж байхад нь “Солонгос хэл ийм сонирхолтой гэж үү?” гэж бодож байсан юм. Тэгээд хичээл ч дууслаа. Харин дараагийн өдөр нь миний тархи надаас нэг зүйлийг нэхсэн “Солонгос хэлээ хийгээч” гээд л бүр татаж чангаагаад болж өгөөгүй. Солонгос хэл миний хувьд аз жаргал мэдрүүлсэн учраас тархи минь нэхээд байсан юм билээ.

Тэгэхээр энэхүү тархи ажилладаг зарчим дээр суурилан ‘Аялын мэдрэмж’ нэртэй аппликэйшн зохион бүтээх нь цаг үетэйгээ уялдсан явдал болох юм. Та бүхэн ‘ОНХС-2021’ гээд санал асуулга явсаныг сайн мэдэж байгаа болов уу? Маш олон хүн санал хүсэлтээ илгээсэн байдаг. Энэхээс санал асуулга дотор одоогийн байдал цаашид юун дээр яаж ажиллавал зохих талаар асуулгууд байдаг л даа. Харин иймэрхүү санал асуулга явуулдаг “Аялал жуулчлал”-ын талаарх веб сайт болон аппликэйшн одоогоор монголд байдаггүй юм байна. Энэхүү аппликэйшн нь аялал жуулчлалтай холбоотой дараах асуулгуудыг хамарсан байвал зохих юм:

1. Аялаас төрсөн мэдрэмжээ илэрхийлдэг санал асуулгын хэсэг
2. Аялынхаа тухай нийтлэл бичих хэсэг
3. Хамт аялах хамтрагчаа хайх хэсэг
4. Жуулчны бааз, зочид буудлын талаарх тодорхой мэдээлүүд \Хаяг, байршил, үйлчилгээ, зэрэглэл...\
5. Аялын маршрутаа хуваалцах хэсэг
6. Аялал зохион байгуулдаг байгууллагын мэдээлэл ба үйлчлүүлэгчдийн сэтгэгдэл бичих хэсэг
7. Аялал жуулчлалын мэргэжлийн боловсон хүчний талаарх мэдээлэл.

Ингэснээр гадаад дотоодын жуулчид аялах газрынхаа тухай мэдээллийг болон бусдын сэтгэгдлийг виртуал орчноос шууд хүлээн авч үзсэнээр өөрийн аялын төлөвлөгөөгөө гаргахад нь илүү дөхөм болох юм.

Хятад улсад хулс гэх нэгэн ургамал ургадаг. Эхний дөрвөн жилийн хугацаанд хөрсөн дотроос ил нахиалахгүй юу болж байгааг харахад бэрх. Гэвч бидний харж чадахгүй хөрсөн дотор аварга том үндэс соёолж байдаг. Тав дахь жилдээ үндэс нь бүрэн нахиалдаг. Газраас цухуйсан үндэс 24м хүртэл огцом ургадаг. Ердөө нэг жилийн дотор 0-24м хүртэл ургаж байгаа юм. Гэхдээ тав дахь жилд нь ургуулахын тулд эхлээд дөрвөн жилийн хугацаа шаардлагатай байсан. Хөрсөн доорх өсөлт байхгүй бол газар дээр ургах боломжгүй юм. Магадгүй та бүхэнд миний балчирхан илтгэлийн санаа бүтэшгүй мэт санагдаж болох ч би энэ хулс мод шиг чимээгүй хөдөлмөрлөж, бүхнийг уриалан бат бөх үндэсийг бий болгосоор байх болно. Эко аялал жуулчлал бол тогтвортой хөгжлийн үндэс юм.



[illegible]

**МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ-ХӨГЖИЛД:ӨСВӨР
ҮЕИЙНХНИЙ МЭДЭЭЛЛИЙН ХҮРТЭЭМЖ,
МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ХЭРЭГЛЭЭ**

ИЛТГЭГЧ: ЦТ1А АНГИЙН СУРАГЧ Б.АЧХҮҮ

Хураангуй

Мэдээлэл, харилцаа холбооны технологи, хүүхэд залуучуудын мэдээлэл, холбооны технологийн хэрэглээ, өсвөр үеийнхний мэдээллийн хүртээмжийн талаарх өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлуудын талаар хөндөж, хүүхэд залуусыг зөв хүн болон төлөвших, нийгэмд зөв амьдрахад шаардлагатай хэрэгцээт мэдээллийн хүртээмжийг дээшлүүлж, зөв хэрэглээг төлөвшүүлэх шаардлагыг өнөөгийн бодит байдал, хэрэгцээтэй холбон гаргасан. Хувь хүний хөгжил бидний өдөр тутмын амьдрал, мэргэжил сонгох зэрэг хариуцлагатай үед шийдвэр гаргахад мэдээллийн гүйцэтгэх үүрэг, мэдээллийн хүртээмж, энэ бүхэнд мэдээллийн технологи ашиглах талаар өгүүлсэн.

Түлхүүр үг: мэдээлэл, харилцаа, холбооны технологи; интернэт хэрэглээ; өсвөр үе.

Би Мэргэжлийн боловсрол сургалтын Цахилгааны ангийн суралцагч, миний өмнө ирээдүйн мэргэжилтэн болох, амьдралын гол тулгуур мэргэжил эзэмших хариуцлагатай үе улам бүр ойртсоор. Мэргэжлээ зөв сонгоход алсын хараа чухал гэж ярьдаг. Энэ сонголт бол хувь хүний амьдралдаа хийдэг олон сонголтуудын хамгийн чухал нь яах аргагүй мөн. Хэдийгээр хүмүүс ийм ч мэргэжил ирээдүйтэй, тийм ч мэргэжил эрэл хэрэгцээтэй хэмээн ярьцгаадаг ч энэ бүхэн хоосон яриа мэт заримдаа санагддаг. Зүй нь иймэрхүү олон нийтийн дунд түгсэн үзэл бодол, ярианд бус, хувь хүний өөрийн үзэл бодол, авьяас, зах зээл дэх судалгаа шинжилгээнд тулгуурлах нь зүйтэй гэж би үздэг. Мэдээж эхний алхмаа зөв хийж мэргэжлээ зөв сонгож чадваас сэтгэл өөдрөг, үр бүтээлтэй ажиллаж, улмаар амжилтад хүрэх үүд хэн бүхний өмнө нээлттэй байна. “Хөдөлмөр 99 хувь, авьяас нэг хувь” гэсэн үг байдаг. Мэргэжлийн сонголтын яриа өрнөх бүрт “мэдээллийн технологи” гэдэг үг байнга л сонсогддог.

“Электроник”, “электрон тооцоолон бодох машин”, “цахилгаан хангамж” зэрэг үгсийн мөн чанарыг ч ухаж сайн ойлгоогүй хэрнээ орчин үеийн бас ирээдүйтэй мэргэжил байх хэмээн таамагласнаар мэргэжлийг сонгосон. Аливаа мэргэжил төдийгүй орчлон ертөнцийн юмс үзэгдэл, нийгмийн амьдралын талаарх бүхий л мэдээллийг бид интернэтээс авах боломжтой болж. Хувь хүний хөгжил, бидний өдөр тутмын амьдрал, мэргэжлийн хүрээнд шийдвэр гаргахад мэдээллийн гүйцэтгэх үүрэг, мэдээллийн хүртээмж, энэ бүхэнд мэдээллийн технологи ашиглах талаар өгүүлэхийг зорисон.

Өнөөдөр мэдээлэл, мэдлэг нь хүний нийгмийн хамгийн үнэт зүйл болж чадсан. Эрт дээр үеэс энэ дэлхийд хүч чадал ноёрхож, хүчтэй нь хүчгүйгээ боолчилж, газар орныг байлдан дагуулж, тэдний хөл дор сул дорой улс үндэстнүүд сөгдөн унаж байсан. Аж үйлдвэржилтийн эринд аварга том үйлдвэрүүд араасаа сүндэрлэн босож, ган хайлуулж, хамгийн хурдан, хамгийн хүчирхэг машин техник бүтээж чадсан их гүрнүүд хамгийн хүчирхэг, бас чадалтай байсан.

Өнөөдөр улс орон, хувь хүний хүч чадал, эрх мэдлийг, баян ядууг хэдэн төгрөгөөр хэмжих биш, гартаа оруулсан мэдээлэл, мэдлэгээр хэмжих болжээ. Энэ бүхэн мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжил, тухайн улс орон, эсвэл хувь хүний мэдээлэл, харилцаа холбооны технологийг ашиглаж буй байдал зэрэгтэй холбоотой байдаг болов уу.

Банк санхүү, боловсрол, эмнэлэг гээд л мэдээллийн технологийг ашигладаггүй салбар гэж үгүй, эдгээр бүх салбарт мэдээллийн технологийг ашиглах талаар мэдээж миний мэдлэг хомс, хүрэлцэхгүй. Иймд энэ талаар биш, өөрийг үе тэнгийнхан, найзуудынхаа наад захын хэрэгцээт мэдээллийн хүртээмж, мэдээллийн технологийн хэрэглээ хэрэгцээ, бас энэ бүхэнтэй холбоотойгоор бидний өмнө гардаг асуудал, бэрхшээлийн талаар ярихыг хүсэж байна. Мэдээж энэ асуудлаар томчуудын байр суурь биднийхээс өөр магадгүй тэд хэтийг харсан, “том” юм ярих нь дамжиггүй. Харин миний ярих зүйл бол хамгийн энгийн хэрнээ бидний хувьд тун чухал асуудал.

Нэгдүгээрт мэдээллийн “Хүртээмж”

Дээр дурдсан мэргэжилтэн болох, өдөр тутмын хичээлийн даалгаварт ашиглачихаар хүүхэд залуучуудад зориулсан баталгаат зөв мэдээлэлтэй, сургалт, танин мэдэхүйн монгол хэлээрх вэб ховор бараг байдаггүй. Эрээвэр хураавар мэдээллээс хэрэгцээт мэдээллийг төрөлх хэлээр (англиар биш) олж авах боломж тэр бүр байдаг бил үү? Олж авсан мэдээлэл цаг үетэйгээ нийцдэг бил үү? Эдгээр асуултын хариулт бас л бүтэл муутай талдаа. Эзэмших гэж байгаа мэргэжлийн онцлог, манайд энэ чиглэлийн мэргэжилтэн их байдаг эсэх, тавигдах шаардлага, төгсөөд ажил олдох эсэх, хаана ажиллах, яг юу хийхийн гэх мэт маш их мэдээлэлтэй баймаар байна. Бидэнд зориулсан бидэнд хэрэгтэй мэдээллийг бидэнд хүртээмжтэй болгомоор байна.

Хоёрдугаарт мэдээллийн технологийн “Хэрэглээ”

Өнөөдөр хүүхэд залуучууд, тэр дундаа ид төлөвших насандаа яваа өсвөр насныхан (манай улсын нийт сурагчид гэж хэлж болохгүй байх) интернэт сүлжээг ашигладаг, компьютер тоглоомоор их тоглодог, телевизийн олон сувгаар төрөл бүрийн мэдээлэл, нэвтрүүлгийг хүлээн авах боломжтой болсон. Үүнээс мэдээллийн технологи нь, хүүхэд залуусыг хөгжүүлэх, тэдний мэдлэг боловсролыг дээшлүүлэх, чөлөөт цагийг үр ашигтай өнгөрүүлэхэд чухал үүрэгтэй гэж хэлж болохоор ч бодит байдал дээр илүү сөрөг асуудлыг авчраад байх шиг. Дээрх бүх сувгуудаарх мэдээ мэдээлэлд бидний нас бие, сэтгэхүйн онцлогоос давсан, “томчуудад” зориулсан мэдээлэл их байдаг, ийм төрлийн мэдээлэл, бас түүнийг хүлээн авах, ашиглаж байгаад хяналт тавьж буй байдал ч алга.

Компьютерийн ард суугаад ан амьтан, эсвэл эсрэг талын баатруудыг зүгээр л цус урсган буудаж байгаа тоглоомоор инээд алдан тоглож байгаа хүүхдүүд интернэт кафе, гейм центрээр зөндөө л байна. Үүнийг томчууд тэр бүр анхаардаг билүү? Бас интернэт хэрэглээ. Гадаадын социологийн компаниудаас гаргасан мэдээгээр өдгөө интернэтэд 7-14 насны 6-8 сая хэрэглэгч байдаг ба тэдний 25 хувь нь сургуулийн өмнөх насны хүүхдүүд байдаг, тэдгээр хүүхдүүд эцэг эхийн ямар ч хараа хяналтгүйгээр интернэтээр хэсүүчилдэг. Энэ интернэтээр хүссэн вэбээрээ тэнэж, удаан хугацаагаар ашиглах зэрэг хязгааргүй их эрх чөлөө маань өсөж яваа бидний сэтгэхүй, хүмүүжил, төлөвшилд тодорхой хэмжээгээр сөргөөр нөлөөлдөг гэж би үздэг.

Гэвч энэ асуудал дээр интернэтийг ашиглаж буй бид буруутай биш, энэ орчныг бүрдүүлээгүй төр засаг, томчууд буруутай. Өөрийн мэдэх хэдхэн жишээ хэлье. Жишээ нь Hi5. Миний эргэн тойрныхон, бүх найзууд маань энд цуглардаг, зургаа хуваалцдаг. Харин хэн маань ч хувийн мэдээллээ нийтэд нээх нь зөв эсэх, цаашид ямар нэг сөрөг асуудал гарах эсэх талаар боддоггүй. Бас нэгэн жишээ одоогоос хэдхэн сарын өмнө dragonadoptors хэмээх луу гэжээдэг вэбэд мөн л бүгд орж, луугаа гэжээн өдөртөө олон удаа ханддаг болсон. Яагаад бидэнд зориулж, бидний интернэт дэх аюулгүй байдлыг бүрэн хангасан, нийгмийн амьдралд дасан зохицох боломжийг олгосон, зөвхөн бидний эрх ашигт нийцсэн иймэрхүү орчинг үүсгэж болохгүй гэж? Webkinz зэрэг олон орны хүүхэд залуучуудыг эгнээндээ нэгтгэсэн том сүлжээнд Монголын орон зайг нээж болохгүй гэж? Иймэрхүү вэбүүд нь хүүхдүүдэд боловсрол, танин мэдэхүйн интерактив агуулгыг санал болгоод зогсохгүй урьдчилан загварчлагдсан системийн дагуу хүүхдүүдийг ёс зүйд үл нийцэх тааламжгүй мэдээллээс бүрэн хамгаалдаг гэж би сонссон. Жишээ болгон авсан Webkinz сүлжээ гэхэд л 2009 оны сүүлийн байдлаар дэлхийн 26 хэлээр 50 гаруй орон ашигладаг, сард давтагдаагүй тоогоор 5 сая хэрэглэгч уг вэб гэсэн тоо бий.

Яагаад бид үүний нэгээхэн хэсэг нь байж болохгүй гэж? Дээрх бүх “Яагаад” гэсэн асуултуудын хариулт нь тун энгийн, мэдээж болно. Тэгвэл яаж? Гэсэн асуулт гарна. Хариулт нь санаачилга, бодит ажил. Энэ бол өмнө хэлсэн мэдээллийн хүртээмжтэй ч холбоотой.



Бидэнд юу хэрэгтэй вэ?

1. Бидэнд соёлтой интернэт хэрэглээг төлөвшүүлэх талаарх төрийн бодлого, томчуудын анхаарал,
2. Бидний нас сэтгэхүйд тохирсон сургалт, танин мэдэхүйн мэдээлэл бүхий монгол хэлээрх төрөл бүрийн вэб,
3. Бидэнд зориулсан хэрэгцээт мэдээллийг интернэтээр дамжуулан бидэнд нээлттэй, олдоцтой, хүртээмжтэй болгох,
4. Бидэнд зориулсан монгол хэлээрх нийгмийн сүлжээ.

Бид юу хийх хэрэгтэй вэ?

1. Мессеж, чаатаар харилдахаасаа өгсүүлээд цахим харилцаан биеэ соёлтой авч явах,
2. Наснаасаа ахадсан, ёс бус мэдээлэлтэй вэбээр хэсэхгүй байх,
3. Бидний төлөө дээрх чиглэлүүдээр хийгдэх ямар нэгэн ажлыг дэмжих, багш эцэг эхчүүдтэйгээ хамтран ажиллах.

Дүгнэлт

Эцэст нь хэлэхэд дэлхий ертөнц улам бүр даяарчлагдаж, мэдээллийн технологи хурдацтай хөгжиж, та бидний өдөр тутмын амьдралын хэв маягийг ихээр өөрчлөх болсон өнөө үед хамгийн хурцаар тавигдаж буй асуудал бол **ХҮНИЙ ХӨГЖЛИЙН АСУУДАЛ**. “Хүн болох багаасаа, хүлэг болох унаганаасаа” гэдэгчлэн хүүхэд залуус бидэнд зөв хүн болж төлөвших, нийгэмд зөв амьдрахын тулд бидэнд зориулсан мэдээлэл хүртээмжтэй байж, бидний нийгэм дэх мэдээллийн хэрэглээ зөв байх ёстой гэж үзэж байна. Мэдээж энэ бүхэнтэй мэдээллийн технологийн хэрэглээ, ашиглалтын асуудал шууд холбоотой.

Өсвөр үеийнхэн мэдээллийн хүртээмж, мэдээллийн технологийн хэрэглээний асуудалд анхаарч, нийтээрээ анхааран ажиллахыг уриалж байна.



ТЭМДЭГЛЭЛ

[illegible]

ӨСВӨР ҮЕИЙНИЙНХЭНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ИЛТГЭГЧ: ОП1А П.СОДБАЯР

Агуулга

Үндэслэл хэрэгцээ шаардлага:

Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаагаар өсвөр үеийнхэн 60% нь нөхөн үржихүйн үйлчилгээг хаанаас авахаа мэддэггүй, 37% нь эрүүл мэндийн багш, 47% нь олон нийтийн телевиз, 44% нь найз нөхдөөсөө БЗДХ,ХДХВ/ДОХ болон бэлгийн эрүүл мэндийн талаарх мэдээллийг тодорхой хэмжээгээр авдаг гэсэн үр дүн гарчээ. Мөн өөр нэгэн судалгаанд анх удаа бэлгийн хавьталд орсон 15-17 насныхны 80% нь энэ талаар ямар ч мэдлэггүй байсан байна. Бэлгийн замын халдварын судалгааг 15-18 нас, 18-23 нас, 23-25 нас, 25-35 насныханд явуулахад 15-18 насныхны дунд бэлгийн замын өвчлөл, жирэмслэлт, үр хөндөлт хамгийн их байгаа нь тогтоогджээ. Энэ бүх судалгааны үр дүнд ганц л үр дүнд хүрч байгаа нь өсвөр насныханд бэлгийн болон нөхөн үржихүйн мэдлэг, мэдээлэл дутмаг байна. Мэдлэг, мэдээлэлтэй ч түүнийгээ хэрэгжүүлж чадахгүй байна.

Дэвшүүлж буй асуудал:

Монголд бэлгийн харьцаанд орох нас жилээс жилд залуужиж байгаа болохоор хүүхэд, өсвөр үеийнхэнд нөхөн үржихүйн талаар өгөх боловсролдоо анхаарах цаг нь аль хэдийн болсон байна үүнд бид өөрсдөө хувь нэмэрээ оруулах шаардлагатай байна.

Зорилго:

Багш, Сургуулийн эмч, сургалцагчдын төлөөлөл бүхий “ ” өгөх төвөөр дамжуулан ҮҮПК-ийн өсвөр насныхан нөхөн үржихүйн эрүүл мэнд, бэлгийн боловсролын асуудлаар сургалт зохион байгуулан тэдэнд хэрэгцээт тусламж үйлчилгээг багаар үзүүлэх (Багш, Нийгмийн ажилтан, Сургуулийн эмч)

Зорилт:

- Өсвөр насны нөхөн үржихүйн эрүүл мэндийг тандалт судалгааг үзэх
 - Өсвөр насныханы сэтгэл зүйн онцлогыг судлах
 - 14-19 насны оюутан залуучуудын дунд ХДХВ-ийн мэдлэг, хандлагыг судлах
 - “ ” -энд багийн нэрийг бичнэ багийн нэрийг гаргахдаа итгэл, боловсрол, нууцыг хадгалах гэсэн утга санааг илэрхийлэх далд утгатай нэг болон холбоо үг байх багийг бүрдүүлэх
- Бидний үеийнхэн хэтэрхий нээлттэй юм шиг хаалттай байдлаар хүмүүжиж байна. Монголд бэлгийн харьцаанд орох нас жилээс жилд залуужиж байгаа болохоор хүүхэд, өсвөр үеийнхэнд нөхөн үржихүйн талаар өгөх боловсролдоо анхаарах аль хэдийн болсон байна.

Судалгааны арга:

Тоон судалгааны арга- Мэдээлэл цуглуулагч буюу ярилцлага авагч нь судалгаанд хамрагдагчтай шууд харилцаанд орохгүйгээр цаасан болон цахим хэлбэрээр өгсөн асуумжийн хуудсыг бөглүүлж судалгааны мэдээлэл авах арга юм.

ҮНДСЭН ХЭСЭГ

Өсвөр нас гэж юу вэ?

10-19 насныхныг өсвөр насныхан гэж үздэг. Өсвөр насанд явагдах бие бялдрын өсөлт, бэлгийн бойжилтыг биологийн буюушилжилтийн насны өөрчлөлтүүдгэнэ. Өсвөр үеийг эрт өсвөр үе (10-13 нас), дунд өсвөр үе (14-16 нас), хожуу өсвөр үе (17-19) гэж ангилдаг.

13-19 насныханы онцлог

Дааврын өөрчлөлтөсвөр насныхны сэтгэл зүйг тогтворгүй болгодог. Тэдтом болж байгаагаа илүү ихээр анзаардаг бөгөөд ганцаараа байхыг эрмэлзэж, бусдад уруу татагдах эрсдэлтэй болж эхэлдэг. Томоогүй зангаар тамхи татах, согтууруулах ундаа уух, эрсдэлтэй алхам хийх нь их. 13 нас орчимд ихэнх охидын анхны сарын тэмдэг ирсэн байдаг. Гэхдээ хүн хүний бие физиологи өөр гэдгийг санууштай.


Энэ үед хэрхэн харилцах вэ?

Мэдээж энэ маш чухал бөгөөд маш хэцүү үе гэдэгтэй хүн бүр л санал нийлэх биз. Тэд илүү хаалттай, дотогшоо болсон нь харилцааг хүндрүүлдэг. Гэхдээ л та энэ үед маш сайн найз, зөвлөх байх шаардлагатай юм. Хэрвээ та өмнө хүүхэдтэйгээ бэлгийн амьдрал, бэлгийн бойжилтын талаар хангалттай сайн ярилцдаг байсан бол энэ үеийг та 2 ажрах юмгүй давчих байх. Гэвч бидний ихэнх нь ингэж ярилцдаггүй бүлэгт багтана. Тиймээс энэ бүлгийнхэн/өмнө нь сайн ярилцаж байгаагүй эцэг, эхчүүд/ энэ үед л хүүхэдтэйгээ хүсээгүй жирэмслэлт болон түүний хор уршиг, жирэмснээс хамгаалах арга хэрэгсэл, БЗДХ-ын талаар ярилцах ёстой.

13-19 насныханы бэлгийн боловсролын асуудлууд

“Бэлгийн замаар дамжих халдварын талаарх судалгаанд 15-18 насныхны дунд бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөр өвчлөх, хүсээгүй жирэмслэлтэнд өртөх, үр хөндөлт хийлгэх тохиолдол хамгийн их байна гэдгийг тогтоожээ” Өсвөр үеийнхэн бэлгийн боловсролгүй, мэдлэггүй байгааг энэ судалгаа харуулж байна. Бэлгийн боловсролыг зөвхөн “Эрүүл мэндийн хичээл” тодотголоор эр бэлгийн эс, эм бэлгийн эс гэх мэтээр зөвхөн онолын төвшинд биологийн хүрээнд авч үзэх үнэхээр өрөөсгөл ойлголт юм. Монголчууд энэ сэдвийг хориотой сэдэв болгон хаалттай чигт нь үлдээж хэрхэвч болохгүй. Энэ сэдвийн мэдэхгүй байгаагийн улмаас маш их өсвөр үеийн залуучууд бие махбод ч гэлтгүй сэтгэл санаагаар хохирч байна. Үүнээс үүсээд өсвөр үеийн амиа хорлолт ихэсдэг.

Судалгаа №1 Өсвөр насны охидын төрөлт




Судалгаа №2 Статистик мэдээнээс

Зураг 2.10. ХДХВ/ДОХ-ын бүртгэгдсэн тохиолдол, нас баралтын тоо, бүртгэгдсэн оноор



Судалгаа №3 Статистик мэдээллийн нэгдсэн сан 2020 оны 12 сараас 2021 оны 03 сар



Судалгаа №4 ХДХВ, ДОХ-ын талаарх мэдлэг, суралцдаг сургуулиар

ХДХВ, ДОХ-ын талаарх мэдлэг	Улсын сургууль	Хувийн сургууль	МСҮТ
ХДХВ, ДОХ-ын талаар сонсож байсан	95.9	86.3	92.6
Бэлгийн үнэнч нэг хавьтагчтай байснаар ХДХВ-ийн халдвар дамжих эрсдлийг бууруулна	74.1	60.0	45.2
Бэлгийн хавьталд орох бүрдээ бэлгэвчийг хэрэглэсэнээр ХДХВ-ийн халдвараас сэргийлж чадна	84.2	75.6	82.7
ХДХВ-ийн халдвар дамжихаас сэргийлэх аргуудыг мэддэг хүн амын эзлэх %	68.7	54.9	44.2
Гаднаас нь харахад эрүүл хүн ХДХВ-ийн халдвартай байж болно	75.7	67.4	75.0
ХДХВ-ийн халдвар шумуулд хазуулахад дамжихгүй	37.1	36.2	26.0
ХДХВ-ийн халдвартай хүнтэй гар барих, хоол хүнсээ хувааж идэхэд ХДХВ-ийн халдвар дамжихгүй	74.9	67.9	55.8
ХДХВ-ийн халдвар дамжих замын талаар зөв ойлголттой хүн амын эзлэх %	28.6	25.4	19.2
ХДХВ-ийн халдвараас сэргийлэх аргуудыг зөв тодорхойлж, үндсэн ташаа ойлголтуудыг үгүйсгэсэн хүн амын эзлэх %	22.8	20.2	11.5

Судалгаанд оролцсон оюутнуудаас ХДХВ-ийн халдвар дамжих хамгийн өндөр эрсдэлтэй бэлгийн хавьталыг тодорхойлох асуултыг асуусан ба нийт оюутнуудын 55.0 хувь нь үтрээгээр бэлгийн хавьталд орох нь хамгийн өндөр эрсдэлтэй гэж үзсэн бол эрэгтэй оюутнуудын 62.6 хувь нь мөн уг хариултыг сонгосон. Харин эмэгтэй оюутнуудын 44.6 хувь нь энэхүү асуултад мэдэхгүй гэж хариулжээ. Нийт оюутнуудын 35 орчим хавь нь энэхүү асуултад хариулж мэдэхгүй байна.

Судалгаа №5 Оюутан залуусын бэлгийн зан үйл, суралцдаг сургуулиар

Үзүүлэлтүүд	Улсын сургууль	Хувийн сургууль	МСҮТ
Бэлгийн хавьталд орж үзсэн эсэх			
Тийм	62.6	61.4	47.1
Үгүй	37.4	38.6	52.9
Анх бэлгийн хавьталд орсон нас			
16 хүртэл	7.8	11.7	24.5
16-20	80.1	80.1	71.4
20 ба түүнээс дээш	12	8.3	4.1
Анх бэлгийн хавьталд орсон насны дундаж	17.7	17.3	16.6
Бүгд	100	100	100
Нийт хариулагчдын тоо	708	351	49
Сүүлийн 12 сарын хугацаанд бэлгийн хавьталд орсон эсэх			
Тийм	78.5	83	73.5
Үгүй	21.3	16.8	22.4
Санахгүй байна	0.3	0.3	4.1
Бүгд	100	100	100
Нийт хариулагчдын тоо	720	358	49
Сүүлийн 12 сарын хугацаанд бэлгийн хавьталд орсон хүний тоо			
1	73.8	72.1	68.6
2-4	24.4	24.1	31.4
5-аас дээш	1.8	3.8	0
Дундаж	1.5	1.6	1.5

Бүгд	100	100	100
Нийт хариулагчдын тоо	542	290	35
Сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдлын бэлгийн хавьталд орсон эсэх			
Тийм	33.6	27.5	34.8
Үгүй	66.4	72.5	65.2
Бүгд	100	100	100
Нийт хариулагчдын тоо	711	342	46

Улсын сургуулийн оюутнуудын 78.5 хувь, хувийн сургуулийн оюутнуудын 83.0 хувь, МСҮТ-ийн оюутнуудын 73.5 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд бэлгийн хавьталд орж байсан байна.

Судалгаа №6 Оюутан залуусын бэлгэвчийн хэрэглээ

	Анх бэлгийн хавьталд орох бүрдээ бэлгэвч хэрэглэсэн %	Нийт хариулагчдын тоо	Хамгийн сүүлд тохиолдлын бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн %	Нийт хариулагчдын тоо
Нийт	57.3	1127	57.4	455
Жинлэсэн % (95% ИХ)	57.3 (57.0-57.6)	92383	56.6 (56.1-57.1)	36971
Эрэгтэй	57.3	665	64.3	291
Эмэгтэй	57.4	462	45.1	164
Улсын сургууль	56.0	720	55.7	316
Хувийн сургууль	59.2	358	63.4	112
МСҮТ	63.3	49	51.9	27

Нийт оюутнуудын 6.9 хувьд нь сүүлийн 12 сарын хугацаанд БЗДХ-ын шинж тэмдэг илэрсэн бол 46.9 хувь нь эмчлүүлсэн, эрэгтэй оюутнуудын 2.8 хувьд нь шинж тэмдэг илэрч 58.3 хувь нь эмчлүүлсэн, эмэгтэй оюутнуудын 10.5 хувьд нь шинж тэмдэг илэрч, 44.3 хувь нь эмчлүүлсэн байна.

Судалгаа №7 Оюутан залуусын бэлгийн замаар дамжих халдвар

Үзүүлэлтүүд	Сүүлийн 12 сард БЗДХ-ын шинж тэмдэг илэрсэн %	БЗДХ-ын шинж тэмдэг илэрсэн бөгөөд улсын болон хувийн эмнэлэгт эмчлүүлсэн %	Нийт хариулагчдын тоо
Нийт	6.9	46.9	1874
Жинлэсэн % (95% ИХ)	8.2 (8.1-8.3)	3.4 (3.3-3.5)	157,138
Эрэгтэй	2.8	58.3	863
Эмэгтэй	10.5	44.3	1011
Улсын сургууль	6.6	38.5	1187
Хувийн сургууль	7.5	61.4	583
МСҮТ	7.7	50.0	104
Гэртээ, гэр бүлийн хамт	6.0	61.0	684
Гэртээ ганцаараа	14.8	50.0	27
Хамаатны гэрт	9.1	25.0	263
Оюутны байранд	6.1	35.7	687
Түрээсийн байранд	6.5	68.4	208

Судалгааны дүгнэлт


“Бэлгийн замаар дамжих халдварын талаарх судалгаанд 15-18 насныхан болон оюутан суралцагчдын дунд бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөр өвчлөх, хүсээгүй жирэмслэлтэнд өртөх, үр хөндөлт хийлгэх тохиолдол хамгийн их байгаа гэдгийг харж болно.” Өсвөр үеийнхэн бэлгийн боловсролгүй, мэдлэггүй байгааг энэ судалгаа нотолж байна. Энэ сэдвийг мэдэхгүй байгаагийн улмаас маш их өсвөр насний залуучуудбие махбодь ч гэлтгүй сэтгэл санаагаар хохирч байна. Үүнээс үүдээд өсвөр насны амиа хорлолт ихэсдэг бөгөөд нийгэмд маш их гадуурхагддаг.

Судалгаа №8 Доорхи асуултаар ҮҮПК-ийн оюутан суралцагчдаас нөхөн үржихүйн мэдлэгийг тандах судалгааг google Form ашиглан авсан.

Судалгаанд нийт 78 суралцагч хамрагдсан бөгөөд тэднийг насны байдал


1.Нас?

78 responses



2.Хүйс?


78 responses



Асуулт №1 Бэлгийн эрүүл мэнд, нөхөн үржихүйн талаар мэдлэгтэй эсэх?

3.Бэлгийн эрүүл мэнд, нөхөн үржихүйн талаар мэдлэгтэй эсэх?


78 responses



Асуулт №2 Та сургуулийнхаа эрүүл мэндийн багш, сургуулийн эмчээс дээрх сэдвээр дэлгэрэнгүй мэдээлэл авдаг эсэх?


4.Та сургуулийнхаа эрүүл мэндийн багш, сургуулийн эмчээс дээрх сэдвээр дэлгэрэнгүй мэдээлэл авдаг эсэх?

78 responses



Асуулт №3 Таны гэр бүлийнхэн дээрх сэдвээр нээлттэй ярилцдаг эсэх?


78 responses



Асуулт №4 Аль нь “БЗДХ”-өөс хамгаалах вэ?


7. Аль нь “БЗДХ”-өөс хамгаалах вэ?

78 responses





Асуулт №5 Хэрэв та болон таны ойр дотны хэн нэгэн “БЗДХ”-ээр өвдсөн бол хэнд хандах вэ?- Энэ асуулт нь нээлттэй асуулт байсан.



Асуултууд	Хариултууд
1.Бэлгийн эрүүл мэнд болон нөхөн үржихүйн талаар мэдлэгтэй эсэх?	Сайн-21.4%-15 Дунд-54.2%-38 Бага-21.4%-16 Огт мэдэхгүй-2.8%-2
2.Та сургуулийнхаа эрүүл мэндийн багш болон сургуулийн эмчээс дээрх сэдвээр дэлгэрэнгүй мэдээлэл авдаг эсэх?	Тийм-29%-19 Үгүй-71%-50
3.Таны гэр бүл Бэлгийн эрүүл мэндийн талаар нээлттэй ярилцдаг эсэх	Тийм-20%-14 Үгүй-80%-56
4.Аль нь “БЗДХӨ”өөс хамгаалах бэ?	Бэлгэвч-60%-51 Тэвчих-36%-31 Ерөндөг-2% Суулгац-1%
5."LGBT"-нь ямар хүн бэ?	Энгийн хүн-15%-11 Энгийн бус хүн-12%-9 Мэдэхгүй-68%-50
6. Та болон таны ойр дотны хэн нэгэн дээрх сэдвээр хохирч байсан уу?	Тийм-4.29%-3 Үгүй-95.71%-67

ДҮГНЭЛТ

“Бэлгийн замаар дамжих халдварын талаарх судалгаанд 15-19 насныхан болон оюутан суралцагчад Өсвөр үеийнхэн бэлгийн боловсролгүй, мэдлэггүй байгааг энэ судалгаа нотолж байна. Бэлгийн боловсролыг зөвхөн “Эрүүл мэндийн хичээл” тодотголоор эр бэлгийн эс, эм бэлгийн эс гэх мэтээр зөвхөн онолын төвшинд биологийн хүрээнд авч үзэх үнэхээр өрөөсгөл ойлголт юм. Энэ сэдвийг зөвхөн “Эрүүл мэндийн хичээл”-ээс биш сургуульдаа “Эрүүл мэндийн төв” байгуулж “Байгуулагдсан төв”-өөр дамжуулан оюутан суралцагч нарт нэмэлт мэдээлэл, сургалт, зөвлөгөө өгөх нь зүйтээ. Бид энэ сэдвийг хориотой сэдэв болгон хаалттай чигт нь үлдээж огт нууцалж болохгүй. Энэ сэдвийг мэдэхгүй байгаагийн улмаас маш их өсвөр насний залуучууд бие махбодь ч гэлтгүй сэтгэл санаагаар хохирч байна. Үүнээс үүдээд өсвөр насны амиа хорлолт ихэсдэг бөгөөд нийгэмд маш их гадуурхагддаг.

Ном зүй:

- <https://www.1212.mn/>
- ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТ -2019-<http://hdc.gov.mn/>
- <http://mfwa.mn/>-HYPERLINK “<http://mfwa.mn/>-НҮБ-ЫН”НHYPERLINK “<http://mfwa.mn/>-НҮБ-ЫН”ҮБ-ын Нийгэм эдийн засгийн зөвлөлтэй онцгой зөвлөлдөх статустай анхны ТББ
- Өвсөр үеийн дуу хоолой судалгааны тайлан-2017
- www.nccd.gov.mn-HYPERLINK “<http://www.nccd.gov.mn>-хдхв/”ХДХВ, ТЭМБҮҮГИЙН ХАЛДВАРЫН ТАРХАЛТЫН ТАНДАЛТ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

[illegible]

ИЛТГЭГЧ: АМЗ2Б М.ОРГИЛ

Агуулга

Зорилго:

Иргэншсэн нийгэмд хувь хүний биеэ авч явах байдал туйлын чухал зүйлийн нэг төдийгүй энэ нь хотын соёлд чухал байр суурь эзэлж, нийтийн дунд биеэ зөв авч явах, бусадтай зөв харилцах, тэднийг хүндэтгэх, хог хаягдлаа зүй зохистойгоор хогийн цэгт хаях зэрэг энгийн зүйлээс эхэлдэг болохыг ойлгуулахад чиглэгдэнэ.

Зорилт:

Бидний эргэн тойронд тохиолдож буй асуудлууд:

- Хог хаягдал
- Гудамжинд болон нийтийн эзэмшлийн газар шүлс, цэрээ хаях
- усдыг хүндлэн, зүй зохистой харилцах

Сэдэв сонгосон үндэслэл:

Бидний эргэн тойронд өдөр тутамд тохиолдож буй зүйлээс хог хаягдал, нийтийн эзэмшлийн газар ил задгай нус цэрээ хаях, автобус унаанд явахдаа жирэмсэн эхчүүд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, бага насны хүүхэдтэй хүмүүст хүндлэл үзүүлэх тэдэнд суудал тавьж өгөх зэрэг асуудал дээр тун хойрго хандаж буй зэрэгт дүгнэлт хийн дээрх асуудлуудын талаар үзэл бодлоо илэрхийлэхээр сэдвээ сонголоо.

Хотын соёл гэж юу вэ?

Иргэншсэн нийгэмд тухайн хүний биеэ авч явах байдлыг хэлнэ.

Хог хаягдал, хор нөлөө, хамгаалах асуудал

Сүүлийн үед хог хаягдал нийтийн дунд томоохон асуудлуудын нэг болоод байна. Байгаль орчин, гудамжинд хаа таарсан газраа хогоо хаях үедээ нэг бодоод үзээрэй. Хог нь гол ус, газрын хөрсөнд шингэснээр өвчин гаргах төдийгүй агаарын бохирдлыг ч бий болгодог. Энэ нь зөвхөн хүнд ч биш амьтан ургамалд ч давхар нөлөөлдөг ажээ.

Бидний хаясан хог хаягдал хэзээ задардаг вэ?

- Амьтны ялгадас нь 10-15 хоногт
- Хүнсний хог хаягдал, сонингийн цаас 1-3 сар
- Цаас нь 2 жилийн дараа л задардаг байна.
- Автомашины аккумулятор, тугалган цаас, зай нь 110 жил
- Дугуй ба хуванцар сав 120-200 жил
- Хөнгөн цагаан лааз 500 жил, шил 1000 жил болдог байна.
- Шүлс, цэрээ хаях

Бидний дунд нийтийн эзэмшлийн талбай, гудамжинд шүлс, цэрээ хаях тохиолдол байсаар байна. Энэ нь олныг хамарсан өвчин, тахал гарах үндэс суурь болсоор... Газарт ил задгай хаясан шүлс, цэр нуснаас улбаалж өвчний нян маш ихээр дэгддэг. Нус, цэр, шүлс агаараар дамжин өвчин болоод аманд буцаж ордог. Ялангуяа “COVID-19” корона дэлхий нийтээр өргөн тархаж манай улсад ч энэ өвчний тархалт их болсон өнөө үед хамгийн чухлаар тавигдаж буй асуудал болоод байна. Өвчнөөс сэргийлэх гол арга бол бидний эзэмшсэн соёл гэдгийг хүн бүр анхаарч шүлс, цэрээ ил задгай хаяхгүй байх явдал юм.

Бусдыг хүндлэх

- Автобусанд ахмад хүмүүс, жирэмсэн эмэгтэй, нялх хүүхэдтэй хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд суудал тавьж өгдөггүй, тэднийг харсан ч хараагүй мэт суудаг.
- Хаалгаар болон цахилгаан шат онгойход дотор байгаа хүмүүсээ гаргалгүй дайрч ордог.
- Банк, дэлгүүр гэх мэт үйлчилгээний газарт дугаарлаж зогсохгүй, дайрч үйлчлүүлдэг дутагдлууд байгааг онцгой анхаарч хүн бүр энэ дутагдлыг давтахгүйн төлөө анхаарах нь зүй ёсны асуудал болоод байна.

Тоо баримт:

- Нэг хүн хоногт 0,5 кг, жилд 200 кг хуурай хог хаягдал хаядаг.
- Улаанбаатар хотод өдөрт 800-1000 тн хуурай хаягдал гарч зөвхөн 50 хувь нь хогийн цэг рүү ачигдаж, үлдсэн 50 хувь нь гадаад орчин буюу АГААР, ХӨРС-ийг бохирдуулсаар байна.

Дүгнэлт

- Энэ бүгдээс үндэслээд дараах дүгнэлтийг хийж болохоор байна.
- Хогоо заавал хогийн саванд хийж занших
- Гудамж талбайд хогийн савыг олноор байрлуулах
- Нус цэр, шүлсээ зориулалтын алчууранд буюу салфетканд нийх, хаях
- Амьдарч буй газар, орчин тойрноо шүлс, нусаар шүршихээс зайлсхийх
- Ахмад хүмүүс, жирэмсэн эхчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, нялх хүүхэдтэй хүмүүсийг хүндлэн тэдэнд хүндэтгэлтэй хандаж байх
- Бусдыг хүндэлж байж бусдаар хүндлүүлдэг юм шүү.

[illegible]

ИЛТГЭГЧ: ЗБЖБУА 1А АНГИЙН СУРАГЧ Ч.САРАНЖАРГАЛ

1. Оршил

Хог хаягдал нь манай улсадгэлтгүй дэлхийн тулгамдсан асуудлуудын нэг болоодбайгаа. Мөн байгаль орчин болон хүний эрүүл мэндэд хор хөнөөл учруулах болсны сацуу улс орны хөгжих боломжыг нэг талаар хаагаад байгаа. Энэ асуудлын дагуу хог хаягдлын талаар бусдад зөв мэдээллийг хүргэе, сайхан ирээдүйг бүтээхийн тулд бусдыгаа уриалан дуудъя гэсэн үндэслэлээр энэхүү сэдвээр бэлтгэсэн.

2. Зорилго


Хог хаягдлын талаар мэдлэг олгох, хог хаягдал үүссэний улмаас гарч байгаа хор уршгыг таниулах, үнэлэлт дүгнэлт хийх

3. Хуулийн заалт

Монгол улсын хуулинд “Хог хаягдал” гэж хэрэглэгдэхгүй болсон эд юмсыг, “Ахуйн хог хаягдал” гэж айл өрхөөс гарах хог хаягдал болон түүнтэй найрлага, бүтцийн хувьд ижил хог хаягдлыг, “Аюултай хог хаягдал” гэж хүн, амьтан, ургамлыг өвчлүүлэх, гэмтээх, тэдгээрийн үр удамд хор хөнөөл учруулах болон байгаль орчны хэвийн төлөв байдалд сөрөг нөлөөтэй хортой, идэмхий, исэлдүүлэгч, шатамхай, дэлбэрэх аюултай, цацраг идэвхитэй, халдвартай шинж чанартай хатуу, шингэн, хийн хэлбэрийн хог хаягдлыг хэлнэ гэж тус тус заасан байдаг.


4. Судалгааны хэсэг

4.1. Зураг1: МУ-ын сүүлийн 10 жилийн хог хаягдлын хэмжээ, тонноор (төвлөрсөн хогийн цэгийн цэгт хүргэж, дарж булж буй нийт хог хаягдлын хэмжээ)



2018 оны байдлаар төвлөрсөн хогийн цэгт хүргэж, дарж булж буй нийт хог хаягдлын 41.6% буюу 1,393,753тн нь Улаанбаатар хотод үүссэн бол үлдсэн 58.4% буюу 1,959,795тн хог хаягдал нь хөдөө орон нутагт бүртгэгджээ.

Зураг2: Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн хог хаягдлын харьцаа



Нийт хог хаягдлын 30 гаруй хувийг хүнсний хаягдал эзэлж байна. Яагаад хүнсний хаягдал хамгийн өндөр хувьтай байгаа талаар нарийн тооцож үзвэл хүмүүс өдөр тутамд хэрэглэж буй хоол хүнснийхээ 45%-ыг нь хог болгодог гэсэн тооцоо гарсан байна.

4.2. 2016 оны БОАЖЯ-аас гаргасан судалгаагаар Монгол улсын хэмжээнд жилд 2.1 сая тонн (хоногт дунджаар 5150тн) зөвхөн хуванцар хог хаягдал цуглуулагддаг. Үүнээс 976 мянган тонн нь дахин боловсруулах боломжтой байдаг. Харин үлдсэн нь газар булагддаг эсвэл байгаль дээр зүгээр үлддэг гэсэн судалгаа гаргасан байна

4.3. Дэлхий даяар хором бүр 2 сая гялгар уут хэрэглэгддэг. Байж боломгүй мэт санагдаж байгаа байх. Гэвч “Ecowatch”-ын дурдсанаар дэлхийн улс орнууд жил бүр 500 тэрбумаас 1х наяд гялгар уут хэрэглэдэг гэж мэдээллэсэнээр дээр дурдсан 2 сая нь үнэн гэдгийг баталж байгаа юм. Нэг удаагийн гялгар уутны дундаж хэрэглээ нь 12 минут байдаг ч тэр гялгар уутны жижиг хэсгүүд 500-аас дээш жил хөрсөнд хадгалагдаж хөрс усыг бохирдуулж байдаг.

4.4 Дэлхийн хог хаягдлын дийлэнхийг нь хуванцар болон пластик эзэлдэг. Дэлхий нийт хог хаягдлаа хөрсөнд булах, далайд хаях, шатаах, дахин боловсруулах гэсэн аргуудаар алга болгодог. Тэгвэл хүмүүс далай тэнгистээ бүтэн нэг жилд 6 тэрбум (14 тэрбум фунт) хуванцар хог хаягдлыг хаядаг ба энэ хуванцар хог хаягдлын хаягдлын 90% нь 10 голоор дамжин далайд цутгадаг. Дэлхийн эдийн засгийн форумын судлаачдын үзэж байгаагаар пластикаар бохирдсон 10 гол нь Ази болон Африкт байдаг. Эдгээр далайд хаягдсан хогноос болж жил бүр 1.1 сая далайн амьтад амиа алдаж байдаг.

4.5 Олон улсын зах зээлд жил тутам 1000 гаруй нэр төрлийн химийн бодис гарч байгаагаас болж жилд 300-400 сая тонн аюултай хаягдал гарч байдаг. Үүнээс үүдэн аюултай хаягдлын хэмжээг багасгах, хор нөлөөнөөс хүн ам, байгаль орчныг хамгаалах талаар авах арга хэмжээг дэлхий нийтээр хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзээд 1989 онд “Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэхэд хяналт тавих тухай Базелийн Конвенц”-ийг баталсан ба энэ Конвенцид манай улс 1997 онд нэгдэн орсон

5. Хог хаягдлын хэмжээг багасгах, дахин боловсруулах аргууд:

- хэт их баглаа боодол болон нэг удаагийн хуванцар сав, соруул хэрэглэхгүй байх дахин ашиглах боломжтой сав хэрэглэх
- даавуун тор хэрэглэх хогоо ангиж хэвших
- үүсэхээс зайлсхийх
- минималист болон хог хаягдалгүй амьдралын хэв маягт суралцах



Эдгээр аргууд нь дэлхий нийтээр хэрэгжүүлж байгаа аргууд болно. Мөн хог хаягдлаа бууруулах хамгийн наад захын арга бол хогоо ангилахаас эхэлнэ.



Хогоо ангилах юм бол дахин боловсруулахад амар болно.

“Ландфиллийн арга” гэж байгаль орчинд нөлөөлөхгүйгээр хог хаягдлыг хөрсөөр дарж устгах үйл ажиллагааг хэлнэ.

6. Дүгнэлт

Та яг одоо миний яриад байгаа зүйлийг сонсож байгаа хэрнээ “за ямар хамаа байсан юм угаасаа ингэж л байдаг би хог хаялаа гээд миний хаясан хог ганцаараа дэлхийн хог хаягдалыг бүрдүүлэх биш” гэж бодож байж болно. Гэхдээ таны хаях гэж байгаа хог ирээдүйд гэлтгүй ер нь та болон таны үр хүүхдийн эрүүл амьдрах орчныг бохирдуулж байгаа шүү. Энийг сайн ойлгоорой.

Хог хаягдлын хэмжээ өдөр ирэх тутам л эрчимтэй нэмэгдэж байна. Хог хаягдал гарахыг хичнээн сайн, үр ашигтай болиулаа ч гэсэн бага хэмжээний хог үлдэх л болно. Гэхдээ бууруулж, багасгаж байна гээд далай тэнгисдээ хаяж амьтдыг алж үрэгдүүлээд, хөрсөнд булж хөрс, ус, агаарыг бохирдуулж болохгүй. Хүн бүхэн дор бүрнээ ухамсартай байж хог хаягдлаа задгай ил хаяхгүйгээр хогийн савнуудад ангилж хийгээд хариуцлагатай хандаж чадвал хог тодорхой хэмжээнд багасна. Мөн улс орны минь хувьд ч хөгжлийн нэг боломж ч байж болно. Хогон дотроо амьдраад байж болохгүй. Энэ чигээрээ байгаад байвал хэн хэндээ л хохиролтой. Тиймээс сайхан ирээдүйг өөрсдийнхөө гараар бүтээхийн тулд өнөөдрөөс та хог хаягдалдаа хяналж тавьж хэвшээрэй.

Ашигласан материал:

- Google
- Улаанбаатар хотын ахуйн хог хаягдал бүтцийн судалгаа
- Байгаль орчин аялал жуулчлалын яамны мэдээллийн сан
- www.Legalinfo.mn - хуулийн нэгдсэн портал сайт

ТЭМДЭГЛЭЛ

[illegible]

“МЭРГЭЖИЛ БА ИННОВАЦИ”

ИЛТГЭГЧ: МЕХ 1А АНГИЙН СУРАГЧ Г.ГАНБАЯР

Мехатроник гэж юу вэ?

Механикаас “меха”, электроникоос “троник” энэ хоёроос “Мехатроник” гэдэг үг бүрддэг.

Mechanical + Electronics = Mechatronics

“Mecha” + “tronics” = Mechatronics

“Мехатроник” гэх нэр томъёог 1969 онд Ясакава компаний ахлах инженер Тэцүро Мори гаргажээ.

Мехатроникч бол механик инженерчлэл, цахилгаан электроникийн инженерчлэл, програмчлалын инженерчлэл, компьютерийн шинжлэх ухааныг нэгтгэсэн мэргэжил юм. Мехатроник инженерчлэл нь компьютерийн удирдлагатай цахилгаан механик системийн загвар юм.



Мехатроник систем нь компьютерийн удирдлагатай механик систем юм.

Materials processing-Материал боловсруулалт

Automotive-Автомашин

Aerospace-Сансар

Medical-Эрүүл мэнд

Xerography-Хувилах техник

Defense system-Хамгаалалтын систем

Consumer products-Хэрэглээний тоног төхөөрөмж

Manufacturing-Үйлдвэрийн тоног төхөөрөмж

Мехатроникчийн хийж чадах бүтээлүүд



Дугуйтай робот



Агаарын робот



Хөлтэй робот



Автомат жолоодлоготой машин



Хатуу диск



Усан доорх робот



Аж үйлдвэрийн роботууд

Мэргэжил ба инноваци дүгнэлт

Ирээдүйд орон зайг үл хамааран ажлаа хийх виртуал орчинд ажиллах нөхцөлийг мехатроникч хүн л бий болгоно. Робот автомат төхөөрөмжүүдтэй бид ирээдүйд хамтарч ажиллахад бидний мэргэжил чухал учраас энэ мэргэжлийг сонгосондоо баяртай байдаг.

This image shows a single sheet of white paper with horizontal ruling lines. The lines are evenly spaced and run across the width of the page. There are no margins, text, or other markings on the paper.

ИЛТГЭГЧ: ЗБЖБҮА1А АНГИЙН СУРАГЧ Л.НАРАНЦЭЦЭГ



Эрдэм шинжилгээний бүтээлүүдийн эхлэл нь мэргэн байж, цаашдын сургалт үйлдвэрлэл шинэ санаа оновчтой бүтээлийг дэлгэрүүлэн хөгжүүлэх үйлсэд хамт олноороо мэргэшэх болтугай.

2022 ОНЫ СУРАЛЦАГЧДЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИЛТГЭЛҮҮДИЙГ ТАНИЛЦУУЛЖ БАЙНА.

САНААЧИЛАН БОЛОВСРУУЛСАН:

СУРГАЛТЫН АЛБАНЫ МЕНЕЖЕР : /Б.МЯДАГБАДАМ/

ЭХ БЭЛТГЭСЭН: Н.УНДРАМ

ЦАХИМ ХЭЛБЭРТ ШИЛЖҮҮЛСЭН: Э.ТҮВШИН



@rajivgandhicolleges



info@pas.mn



pas.mn